

 **Finanzgruppe**  
Sparkassenstiftung für  
internationale Kooperation

**Sparkassenstiftung für  
internationale Kooperation e.V.**  
Simrockstraße 4  
53113 Bonn, Germany  
Phone: +49 228 9703-0  
[www.sparkassenstiftung.de](http://www.sparkassenstiftung.de)

 **ipc**  
partner for development

**IPC - Internationale Projekt  
Consult GmbH**  
Voltastraße 31-33  
60486 Frankfurt, Germany  
Phone: +49 69 9050188-0  
[www.ipcgmbh.com](http://www.ipcgmbh.com)

## Тайлан

Монгол улсын Бичил, жижиг, дунд бизнес  
эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх  
хөтөлбөр

Гэрээний дугаар C45599/6547/50930

2021 оны 04 дүгээр сар



## **Баримт бичгийн мэдээлэл**

---

### **Нэр**

БЖДБ эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрийн тайлан

### **Монгол Улс дахь хамтрагч**

Монголбанк

### **Тайлангийн хугацаа**

05/10/2020-26/03/2021

### **Үндсэн зөвлөх баг**

Матиас Фохс, Төслийн менежер

Д. Оюунцэцэг, Дотоодын ахлах зөвлөх

Марга Шек, Олон улсын ахлах зөвлөх



**European Bank**  
for Reconstruction and Development



This programme is funded  
by the European Union

## Товчлол

ASB	ЕСБХБ-ны жижиг дунд бизнесүүдэд зориулсан зөвлөгөө
BEST	ЖДБ-ийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх хөтөлбөр
BNPM	Business Network Protection Mongolia
МБ	Монголбанк
ОАТ	Орлогын албан татвар
ЗБ	Зөвлөх баг
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЕХ	Европын Холбоо
СИ	Санхүүгийн институт
СБ	Санхүүгийн боловсрол
FLiCK	Санхүүгийн боловсролын сургалтын багц
СЗХ	Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо
GIZ	Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH
ILO	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
INFE	Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ
IPC	Internationale Projekt Consult GmbH
KOICA	Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага
MEFIN	Mutual Exchange Forum on Inclusive Insurance
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
MNT	Монгол төгрөг
БЖДБ	Бичил, жижиг, дунд бизнес
ТББ	Төрийн бус байгууллага
OECD	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
Q&A	Асуулт ба хариулт
ЖДБ	Жижиг, дунд бизнес
ToT	Сургагч багш нарын сургалт
UB	Улаанбаатар
USAID	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
USD	АНУ-ын доллар

## Агуулга

<b>1</b>	<b>ТАНИЛЦУУЛГА: ГЭРЭЭ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД</b>	<b>6</b>
<b>2</b>	<b>ХЭРЭГЖИЛТ БА ҮР ДҮН</b>	<b>9</b>
2.1	1-р үе шат – Санхүүгийн мэдлэгийн хэрэгцээ, шаардлагын үнэлгээ	9
2.1.1	БЖДБ-ын тодорхойлолт	9
2.1.2	Судалгааны үр дүнд хийсэн шинжилгээ	10
2.1.3	Судалгаа	12
2.2	2-р үе шат – Зөвлөлдөх	13
2.2.1	БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулах	13
2.2.2	Олон нийттэй харилцах	14
2.2.3	БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийн санал болгож буй бүтэц	15
2.3	3-р үе шат – Сургалтын сэдэв ба хэрэглэгдэхүүнийг эцэслэн батлах	15
2.3.1	БЖДБ эрхлэгчдэд зориулсан туршилтын сургалтууд	16
2.3.1.1	"Хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдлага" туршилтын сургалт	16
2.3.1.2	"Цахим худалдаа" туршилтын сургалт	22
2.4	4-р үе шат – Хэрэгжүүлэлт	25
2.4.1	Сургагч багшийн сургалт	25
2.4.1.1	Заах аргачлалын сургалт	26
2.4.1.2	Агуулгын сургалт	26
2.4.2	Эцсийн Зорилтот бүлэг (БЖДБ эрхлэгчид)-ийн сургалт	30
2.5	5-р үе шат – Хяналт үнэлгээ ба үндэсний хэмжээний хурал	30
<b>3</b>	<b>ДҮГНЭЛТҮҮД</b>	<b>34</b>
<b>4</b>	<b>ХАВСРАЛТУУДЫН ЖАГСААЛТ</b>	<b>35</b>

## Зургуудын жагсаалт

Зураг 1	– Төслийн хэрэгжилтийн үе шатууд	9
Зураг 2	– Хөтөлбөрийн хаалттай Facebook Group	18
Зураг 3	–Туршилтын сургалтуудын Chat Group	18
Зураг 4	– Screenshot – 1 дэх өдөр, 2021 оны 01 дүгээр сарын 28	19
Зураг 5	– Screenshot – 2 дах өдөр, 2021 оны 01 дүгээр сарын 29	19
Зураг 6	– Хүснэгт 1 – Сургалтын үнэлгээ	20
Зураг 7	– Screenshot – 1 дэх өдөр, 2021 оны 01 дүгээр сарын 28	23
Зураг 8	– Screenshot – 1 дэх өдөр, 2021 оны 01 дүгээр сарын 29	23
Зураг 9	– Screenshot – 1 дэх өдөр	27
Зураг 10	– Screenshot – 2 дах өдөр	28
Зураг 11	– Screenshot Үндэсний хурал	32

## Хүснэгт

Хүснэгт 1 – Сургалтын үнэлгээ - "Хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдлага" .....	20
Хүснэгт 2 – Сургалтын үнэлгээ - "Цахим худалдаа" .....	24
Хүснэгт 3 –Сургалтын үнэлгээ – “Сургагч багшийн сургалт” ..	28

## Хайрцагууд

Хайрцаг 1 – БЖДБ эрхлэгчдийн СБ-ын сайжруулах чиглэлээр олон улсын сайн туршлага

Хайрцаг 2 – Монгол Улсын хууль дахь жижиг, дунд бизнесийн тодорхойлолт

Хайрцаг 3 –OECD (INFE)-ийн БЖДБ эрхлэгчдийн СБ-ын үндсэн чадваруудын тодорхойлолт

## 1 Танилцуулга: Гэрээ болон хэрэгжүүлэх үе шатууд

Европын Холбооноос санхүүжүүлж, Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн Монгол улсын Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний C45599/6547/50930 тоот гэрээ нь 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гарын үсэг зурагдсан бөгөөд төслийн нээлтийн уулзалт 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан. Уг уулзалтанд Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Монголбанк, German Sparkassenstiftung for International Cooperation болон IPC – Internationale Projekt Consult GmbH-ийн төлөөлөгчид оролцсон юм. Гэрээний дагуу хэрэгжүүлэх төслийн зорилго нь техникийн туслалцаагаар дамжуулан Монгол Улсын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд Монголбанкинд дэмжлэг үзүүлэх юм.

Зөвлөх багийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг БЖДБ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа, санал асуулга явуулах үе шат, Зөвлөх багаас санал боловсруулж Монголбанк, ЕСБХБ-тай зөвлөлдөх үе шат, хөтөлбөрийг эцэслэн батлах үе шат болон хэрэгжилтийг хянах, төслийн үр дүнг танилцуулах оролцогч талуудын хурал зохион байгуулах үе шат гэсэн 4 үе шатанд хуваасан.

Төсөл эхэлсэн цагаас Зөвлөх баг Монголбанктай нягт хамтран долоо хоног бүр хуралдаж байсан бөгөөд зарим хурлуудад ЕСБХБ-ны төлөөлөгчдийг урилгаар оролцуулж байсан. Үүнээс гадна Монголбанкны зүгээс БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн голлох оролцогч талуудын дунд 2 удаагийн хурлыг зохион байгуулсан бөгөөд Зөвлөх баг болон ЕСБХБ хоёрдахь удаагийн хуралд оролцсон.

Зөвлөх багийн зүгээс 2020 оны 11 дүгээр сарын 27-нд онлайн хурал зохион байгуулж судалгааны үр дүнг Монголбанк болон ЕСБХБ-нд танилцуулсан. 2020 оны 12 дугаар сарын 01-нд сонгон шалгаруулах үзүүлэлтүүд болон сургагч багш сонгох үйл явцын дэлгэрэнгүй шаардлагыг Монголбанкинд хүргүүлж, Монголбанкнаас 2 сургагч багш, бусад оролцогч талуудаас нийт 12 сургагч багшийг Монголбанк сонгон шалгаруулахаар тохиролцсон.

Төслийн хүрээнд ажиллах сургагч багш нарыг хэрхэн сонгох, тэдэнд тавигдах шаардлагуудыг Монголбанктай хамтран тохиролцсоны дараа сургагч багш нарын жагсаалтыг 2021 оны 01 дүгээр сарын 18-нд сүүлийн байдлаар танилцуулсан. Сонгогдсон сургагч багш нарын эхний үндсэн сургалт (5 хоногийн) 2021 оны 01 дүгээр сарын 26-аас 2021 оны 02 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулагдсан. Энэхүү сургалтаар сургалтын арга хэлбэр, онлайн сургалтын зохион байгуулалт, сургалтын материалууд болон сувгуудын талаар танилцуулсан бөгөөд сургалтыг Sparkassenstiftung-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Маркус Лох удирдан явуулсан.

2021 оны 02 дугаар сарын 22-нд зохион байгуулсан Монголбанк, ЕСБХБ болон Зөвлөх багийн онлайн уулзалтаар Зөвлөх багийн хийсэн судалгааны үр дүнг хэлэлцэж, дараах үндсэн дүгнэлтүүд, хэрэгжүүлэх үлгэрчилсэн загварчлалд оруулах саналуудыг гаргасан. Үүнд:

## 1. Дүгнэлтүүд:

- Олон сэдвээр их хэмжээний материалууд байгаа боловч өөр өөр оролцогч талуудын дунд тарсан;
- БЖДБ эрхлэгчдийн хувьд онолын мэдлэгээ практикт нэвтрүүлэх олон хэлбэрийн, нэгдсэн зохицуулалттай арга хэлбэрүүдийг хайж байгаа;
- Оролцогч талуудын хоорондын зохицуулалт дутмаг;
- БЖДБ эрхлэгчид чанартай сургалтыг төлбөртэй авах хүсэлтэй.

## 2. БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн загварчлалд оруулах саналууд:

- Оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах;
- Удирдах байгууллага болон зохицуулах нэгж (оролцогч талуудын хурал/хороо)-ийг нэр дэвшүүлж тодорхойлох;
- Оролцогч талуудыг зохион байгуулалтанд оруулах (тогтмол хурал, хамтарсан төлөвлөлт, хамтарсан дүн шинжилгээ гэх мэт);
- Оролцогч талуудын “давуу тал”-уудыг ашиглах (ажил хэргийн сүлжээ, сургалт/ноу-хауг ашиглах);
- БЖДБ-үүдэд зориулсан эхний хөтөлбөрийг 5 жилээр тодорхойлох, дунд нь үнэлгээ хийж, шаардлагатай бол өөрчлөлт оруулах;
- Эхний ээлжинд бизнес болон бичил бизнесүүд (эдгээр нь Монгол Улсын нийт бизнесийн ихэнх хувийг бүрдүүлдэг)-д төвлөрсөн үйл ажиллагаа явуулах;
- 5 зорилтот бүлэг (тэргүүлэх чиглэл)-ээр арга хэмжээ авах;
- Өмнө нь боловсруулагдсан төсөл санаачлага, материалуудыг нэгтгэх;
- Зорилтот бүлгүүдэд хүрэхийн тулд олон сувгийг ашиглах.

2021 оны 03 дугаар сарын 22-нд зохион байгуулагдсан хагас өдрийн үндэсний хуралд дотоод, гадаадын оролцогч талуудын өндөр албан тушаалын хүмүүс оролцож, төслийн үр дүнг хэлэлцэж, МУ-ын БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн загварчлалыг танилцуулсан.

## Хайрцаг 1

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр олон улсын туршлага

Энэхүү төсөл хэрэгжиж дууссаны дараа ч Зөвлөх багийн зүгээс Монголбанктэй холбоотой байж, олон улсын сайн туршлага, харьцуулж болохуйц жишээнүүдийн талаар мэдээлэл солилцох болно. Зөвлөх багийн бусад улсуудад ажилласан туршлага, German Sparkassenstiftung-ийн OECD-INFE группийн үйл ажиллагаанд оролцож ирсэн туршлагад тулгуурлан Зөвлөх багаас Гүрж, Австри, Австрали, Канад болон Их Британи зэрэг улсуудын санхүүгийн боловсролын үндэсний стратегиудыг судалж үзэхийг Монголбанкинд зөвлөсөн. Ялангуяа Гүрж Улсад санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бүх төрлийн үйл ажиллагаанд БЖДБ эрхлэгчдийг оролцуулахад чухал ач холбогдол өгдөг. OECD-ийн гишүүн улсуудад БЖДБ-үүдэд тусгайлан зориулсан санхүүгийн мэдлэгийн стратегиудыг хэрэгжүүлж эхлээгүй байгаа боловч санхүүгийн мэдлэгийн үндэсний стратегитэй нийт улсуудын 54.1 хувь нь өөрийн стратегид БЖДБ-үүдэд онцгой ач холбогдол өгсөн байдаг. БЖДБ болон боломжит бизнес эрхлэгчидтэй холбоотойгоор санхүүгийн боловсролыг тодорхойлохдоо санхүүгийн боловсролын хөтөлбөрүүдийн агуулгыг зааж өгдөггүй бөгөөд агуулгыг тухайн улсын боловсролын байгууллагууд болон бодлого тодорхойлогчид боловсруулдаг. Санхүүгийн боловсролын агуулга нь үндсэндээ хоёр үндсэн чиглэлтэй байдаг: санхүүгийн ерөнхий мэдлэгтэй холбоотой сэдвүүд болон бизнесийн санхүүгээ удирдах, санхүүгийн бүртгэл тайлан хөтлөх, эрсдэлийг удирдах болон зээлдүүлэгч/хөрөнгө оруулагчидтай харилцах гэх мэт тодорхой бизнест зориулсан сэдвүүд. Тодорхой бизнест тусгайлан зориулсан сэдвүүд нь маш өргөн хүрээтэй байдаг. Жишээ нь, санхүүгийн боловсрол олгогч олон байгууллагууд БЖДБ эрхлэгчид болон боломжит бизнес эрхлэгчдэд зориулсан төрөл бүрийн төсөл, хөтөлбөрүүдэд ордог нийтлэг сэдэв болох даатгалын бүтээгдэхүүнүүд болон эрсдэлийн удирдлагын талаар боловсрол олгох шаардлагатай байгаа талаар ярьдаг.

Ази тивийн хэмжээнд санхүүгийн ерөнхий мэдлэгтэй холбоотой сэдвүүдийг сайн хамарсан байдаг бол тодорхой бизнест зориулсан сэдвүүдийн хамрах хүрээ болон зорилтот бүлгүүд нь Бангладеш, Индонез болон Япон Улсуудад харилцан адилгүй байдаг. Эдгээр сэдвүүд нь бичил, жижиг, дунд хэмжээтэй бизнесүүдийг бүгдийг хамарсан байдаггүй бөгөөд боломжит бизнес эрхлэгчдээс илүүтэй үйл ажиллагаа нь явагдаж байгаа БЖДБ-үүдэд чиглэдэг.

Индонез Улс дахь санхүүгийн боловсролын хөтөлбөрийн агуулга нь харьцангуй өргөн бөгөөд санхүүгийн ерөнхий мэдлэг болон бизнесийн мэдлэгийн категориудыг бүрэн хамарсан сэдвүүдийг багтаасан байдаг. Энэхүү агуулга дотроос илүү томоохон бизнесүүдэд зориулагдсан бизнес, санхүү болон эдийн засгийн орчны судалгаатай холбоотой хэсгээс бусад бүх материалуудыг бүх төрөл, хэмжээтэй бизнесүүдэд зааж болно.

Бангладеш Улсын санхүүгийн боловсролын хөтөлбөр нь мөн бүх төрөл, хэмжээтэй бизнесүүдэд зориулсан сэдвүүдийг хамарсан байдаг.

Хятад Улсад санхүүгийн ерөнхий мэдлэгийг багтаасан агуулгыг бүх төрөл хэмжээтэй бизнесүүдэд заадаг бол тодорхой бизнест тусгайлан зориулсан сэдвүүдэд өөрөөр ханддаг. Санхүүгийн боломжууд бий болгох, зээлдэгчид болон хөрөнгө оруулагчдын шаардлагыг хангах гэх мэт сэдвүүдийг том хэмжээтэй бизнесүүдэд ордог бол бизнесийн санхүүгээ төлөвлөх болон удирдах, санхүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг сэдвүүдийг боломжит бизнесүүд болон бизнес эрхлэгчдэд ордог.

Энэтхэг Улсад санхүүгийн боловсрол нь бүх төрлийн хэмжээтэй бизнесүүдэд санхүүгийн ерөнхий мэдлэг олгох гэсэн ойлголт байдаг бол тодорхой бизнест зориулсан агуулга нь бүх төрлийн хэмжээтэй бизнесүүдэд зориулагдсан байдаг. Харин Япон Улсад санхүүгийн ерөнхий мэдлэг боловсрол нь боломжит бизнес эрхлэгчдэд үндсэндээ зориулагдсан байдаг бол санхүүгийн эрсдэлийн удирдлага болон хувийн болон бизнесийн санхүүгээ ялгах хоёроос бусад тодорхой бизнест зориулсан ихэнх сэдвүүд нь бичил, жижиг, дунд хэмжээтэй бизнесүүдэд зориулагдсан байдаг.





Зураг 1 – Төслийн хэрэгжилтийн үе шатууд

## 2 Хэрэгжилт ба үр дүн

### 2.1 1-р үе шат – Санхүүгийн мэдлэгийн хэрэгцээ шаардлагын үнэлгээ

Монгол Улс дахь БЖДБ-үүдэд зориулан хэрэгжүүлсэн санхүүгийн мэдлэг, боловсролын төсөл, хөтөлбөрүүд, тэдгээрийн зорилго, ашигласан сургалтын материалууд, сургалтын хэлбэр, үр дүнгийн судалгааг 2020 оны 10 дугаар сарын 05-аас 12-ны хооронд хийсэн.

Энэхүү даалгаврын хүрээнд хөтөлбөрийн зүгээс тодорхойлох шаардлагатай болсон гол зүйлсийн нэг нь БЖДБ-үүдийн зорилтот бүлгийн албан ёсны тодорхойлолт байсан.

#### 2.1.1 БЖДБ-ийн тодорхойлолт

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай Монгол Улсын хуулинд “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг” хэлнэ гэж заасан байдаг. Мөн тус хуулинд бичил, жижиг, дунд бизнесүүдийг ангилахдаа:

## Хайрцаг 2

- “Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг (2019 оны 12 дугаар сарын 31-ний ханшаар 101,963 евротой тэнцэнэ);
- “Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг (2019 оны 12 дугаар сарын 31-ний ханшаар 339,877 евротой тэнцэнэ);
- “Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0--2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг 2019 оны 12 дугаар сарын 31-ний ханшаар 849,693 евротой тэнцэнэ);
- Боломжит бизнес эрхлэгч гэж зах зээлд гарахад ойрхон бизнесийн санаа бүхий хувь хүмүүсийг тус тус хэлнэ.

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд хэрэглэсэн тодорхойлолтонд бизнес эрхлэгчид болон бизнесүүдийг хамруулаагүй бөгөөд хувь хүмүүсийн болон бизнесүүдийн санхүүгийн асуудлуудад төвлөрсөн байдаг. Тиймээс БЖДБ эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрийн хүрээнд энэхүү тодорхойлолтыг боловсруулах нь чухал юм. Зөвлөх багийн зүгээс OECD International Network of Financial Education (INFE)-ийн БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн үндсэн чадваруудыг тодорхойлолтонд тулгуурлан БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дараах байдлаар тодорхойлсон:

## Хайрцаг 3

- ... БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэг гэдэг нь бизнес эхлүүлэх, явуулах, тогтвортой байдал, өсөлтийг хангах үр дүнтэй санхүүгийн шийдвэрүүд гаргадаг болохын тулд бизнес эрхлэгч, бичил, жижиг эсвэл дунд бизнесийн эзэн, менежерүүдийн эзэмшсэн байвал зохих ойлголт, мэдлэг, чадвар, хандлага болон зан төлөвийн хослолыг хэлнэ.

### 2.1.2 Судалгааны үр дүнд хийсэн шинжилгээ

БЖДБ-үүдтэй холбоотой олон судалгааны тайлан байгаа боловч санхүүгийн мэдлэгийг онцлон хийсэн судалгааны тайлан байхгүй, ихэнх арилжааны банкууд, МҮХАҮТ, зарим ТББ-ууд санхүүгийн мэдлэгийн сургалт санал болгодог боловч санхүүгийн мэдлэгийн талаар бодитой мэдээлэл маш бага байна. Түүнчлэн эдгээр сургалтуудад хэдэн БЖДБ эрхлэгчид бодитоор хамрагдан талаар найдвартай тоо баримт байхгүй.

Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Монголын даатгагчдын холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, санхүүгийн секторт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон холбогдох бусад холбоод, их дээд сургуулиуд хамтран Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021-ийг дараах 4 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
3. Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох (Монголбанк 2016)

Хөтөлбөрийн зорилт нь:

- Иргэдийн хувийн санхүүгээ зохистой удирдах чадварыг дээшлүүлэх;
- Иргэдийг санхүүгийн залилангаас өөрийгөө хамгаалах чадвартай болгох;
- Урт хугацаатай хадгалам, санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх;
- Банкны системд итгэх итгэлийг нэмэгдүүлэх;
- Монгол Улсын урт хугацааны, тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжих.

Энэхүү хөтөлбөр нь бизнес эрхлэгчид, бизнесийн менежерүүд болон бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа хувь хүмүүсийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой байсан. Хувь хүний санхүүгийн мэдлэг нь санхүүгийн ерөнхий мэдлэгийн салшгүй хэсэг бөгөөд бизнесийн санхүүгийн мэдлэг, чадварын суурь нь болж байдаг.

Зах зээлд томоохон байр суурь эзэлдэг зарим банкууд БЖДБ эрхлэгчдийн бизнесийн networking болон санхүүгийн ноу-хауг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бус үйлчилгээнүүдийг санал болгож байна. Эдгээрээс хүмүүст илүү хүрсэн нь:

- Тухайн салбарын бизнес эрхлэгчдэд networking хийх боломжийг олгодог жил тутмын уулзалт, хурал, үзэсгэлэн яармаг;
- Сургалт, мэдээлэл хуваалцах, networking хийх арга хэмжээнүүдийг сонгосон салбаруудаар зохион байгуулах;
- Бизнесийн зөвлөх үйлчилгээнүүд үзүүлэх;
- Санхүүгийн мэдлэг олгох сургалтуудыг хөдөө орон нутаг болон хотод зохион байгуулах.

Монголын БЖДБ эрхлэгчид албан ёсны санхүүжилт авахын тулд үнэ, зээлийн бүтэц ба барьцаа хөрөнгө зэрэг чиглэлээр саад тотгортой тулгарч байдаг. Санхүүгийн мэдлэг сайжирсанаар БЖДБ эрхлэгчдэд санхүүгийн байгууллагуудыг бүтээгдэхүүнүүдийг илүү сайн ойлгодог болж, энэ нь хэт их өр зээлтэй болохоос сэргийлэхээс гадна бүтээгдэхүүнүүдээ шинэчлэн гаргах дарамтаас санхүүгийн байгууллагуудыг ангижруулна. Түүнчлэн санхүүгийн мэдлэг сайжирсанаар БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн бүртгэл тайлан, баримт бичиг бүрдүүлэлтэнд эерэгээр нөлөөлж, энэ нь эргээд санхүүгийн байгууллагуудад бизнесийн ойлгомжтой байдлыг нэмэгдүүлсэнээр санхүүжилт авах магадлалыг өсгөнө.

Санхүүгийн мэдлэг, ялангуяа бизнесийн санхүүгийн мэдлэг дутмаг байгаа нь үйл ажиллагаа явагдаж буй бизнесүүдийн талаар арилжааны банкуудын хувьд хүлээн зөвшөөрөхүйц үнэн бодит өгөгдөл дутмаг байдалд хүргэж байна.

БЖДБ-үүдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж, спонсорлож буй хэд хэдэн байгууллага, төсөл хөтөлбөрүүд байна. Тэдгээрийн үйл ажиллагаа үр дүн нь өөр өөр байгаагаас амжилттай хэрэгжсэн жишээг дурьдвал:

Зөвлөх багаас USAID REACH төслийн үр дүнг дараах байдлаар дүгнэсэн:

- 2 жил хэрэгжих хугацаанд REACH төсөл нь Зээлийн батлан даалтын сан, ЖДБ-ийн хөгжлийн сан болон арилжааны банкуудтай стратегийн түншлэл бий болгосны үр дүнд үндсэн зорилгуудаа биелүүлсэн.
- REACH төслийн хүрээнд хэдэн зуун БЖДБ эрхлэгчдэд бизнесийн төлөвлөлт, зээлийн мэдлэг болон нягтлан бодох бүртгэлийн удирдлагын чиглэлээр сургалтанд хамрагдсан.
- Төсөл эхэлсэнээс хойш БЖДБ-үүдийн 7,600 ажилтан нийт 68 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэ цэнэ бүхий бизнесийн сургалтанд хамрагдсан.
- Эдгээр ЖДБ-үүдийн орлого 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 611 шинэ ажлын байр бий болгосон.

Монгол Улсын БЖДБ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгоход чиглэсэн үйл ажиллагаануудын талаар дэлгэрэнгүй мэдээллийн ЕСБХБ болон Монголбанкинд хүргүүлсэн хагас жилийн тайланд оруулсан болно.

### 2.1.3 Судалгаа

Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үндсэн ажлуудын нэг нь санхүүгийн мэдлэгтэй холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгцээ шаардлага, БЖДБ эрхлэгчдийн дундах хүлээлтийг тодорхойлох судалгааг 100 БЖДБ эрхлэгчээс авах байсан. Зөвлөх баг 30 асуулт бүхий санал асуулга (Хавсралт 1)-ыг боловсруулж, утсаар тус бүр нь 20 минутын хугацаатай ярилцлагуудыг хийж өөр өөр бүс нутгийн, өөр өөр хэмжээтэй 101 БЖДБ –үүдээс судалгаа авсан.

Судалгаанд хамрагдах БЖДБ-үүдийг Монголбанк, МҮХАҮТ, ЕСБХБ-ны зөвлөх үйлчилгээ болон орон нутгийн зөвлөхүүд сонгосон. БЖДБ-үүдийг сонгохдоо Монгол Улсын бүх бүс нутгийг хамруулахыг хичээсэн бөгөөд хөдөө орон нутгийн БЖДБ-үүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулахын тулд 50 хувийг нь хөдөө, орон нутгийн БЖДБ-үүдээс сонгосон. Судалгаанд хамрагдсан БЖДБ-үүд нь борлуулалтын орлого, бизнесийн төрөл болон ажилтнуудын тооны хувьд (Хавсралт 2-ыг хар) харилцан адилгүй байсан. Судалгааны үр дүнд хийсэн дэлгэрэнгүй шинжилгээг Хавсралт 3-аас харж болно.

Судалгаанаас гарсан гол үр дүнгүүд нь:

- Судалгаанд хамрагдсан 101 БЖДБ эрхлэгчээс 68 нь ямар нэгэн төрлийн санхүүгийн мэдлэгийн сургалтанд хамрагдаж байгаагүй гэж хариулсан. Үлдсэн 33-ын хувьд бизнес, санхүү, нягтлан бодох бүртгэл болон бусад чиглэлээр сургалтанд хамрагдсан байсан.
- Судалгаанд хамрагдсан 101 БЖДБ эрхлэгчийн 1/3 (32,7%) нь 9 өөр сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан байсан. Энэ нь 2 талаараа анхаарал татаж байгаа юм. Нэгдүгээрт, энэ чиглэлийн сургалт санал болгож буй нилээд хэдэн байгууллага байна. Хоёрдугаарт, судалгаанд оролцсон БЖДБ-үүдийн 1/3 нь санхүүгийн мэдлэгтэй холбоотой сэдвүүдээр ямар нэгэн сургалтанд хамрагдсан нь анхаарал татсан.
- БЖДБ эрхлэгчид энэ чиглэлээр сургалтанд хамрагдах сонирхолтой байсан: Судалгаа авах үеэр 24 БЖДБ эрхлэгч төсөв төлөвлөлттэй холбоотой сургалтанд хамрагдсан байсан боловч бүгд Монгол Улсын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтанд дахин хамрагдах хүсэлтэй байсан. Сургалтыг онлайн явуулах тохиолдолд сургалтын программ хангамж дээр хэрхэн ажиллах талаар тэдэнд зааж өгсөн,

программ хангамж нь Монгол хэл дээр байвал илүү үр дүнтэй гэсэн хариулт олон байсан. Мөн өмнөх сургалтуудад харилцан туршлага солилцох боломжоор бага хангасан нь сургалтын үр дүнд нөлөөлсөн гэж олон оролцогч үзсэн.

Судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгч/бизнесүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн олон сургалт, төсөл хөтөлбөрүүд хэрэгждэг боловч харилцан уялдаагүй, Монгол Улсын болон тодорхой зорилтот бүлгийн өвөрмөц онцлогт нийцүүлээгүй, ихэвчлэн өөр үйл ажиллагаатай хослуулан зохион байгуулагддаг байна.

Зөвлөх багийн зүгээс судалгаа болон санал асуулгын үр дүнгээс гадна цар тахлын улмаас тулгарч буй асуудлуудад тулгуурлан өмнөх төсөл хөтөлбөрүүдээр хамраагүй, нүүр тулсан болон онлайн хэлбэрээр зохион байгуулах сургалтын агуулгуудыг боловсруулсан. Эдгээр агуулгыг багтаасан сургалтыг цар тахлын нөхцөл байдлаас хамааран зөвхөн онлайн хэлбэрээр явуулсан. Санхүүгийн мэдлэг олгох сургалтын үргэлжлэх хугацааны хувьд оролцогчдын талаас илүү нь (69) “хэд хоног дараалан (хагас өдрөөр)” болон “урт хугацаанд үргэлжилсэн сургалт” гэсэн сонголтыг сонгосон байсан. Бүх оролцогч сургалтанд Улаанбаатар хотод, олон хоногоор үргэлжлүүлэн (1-2 долоо хоног) суух сонирхолтой байсан.

## **2.2 2-р үе шат – Зөвлөлдөх**

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн шинжилгээнээс дараах дүгнэлтүүдийг гаргаж, Монголбанк болон ЕСБХБ-нд бичгээр болон онлайн хурлын үеэр танилцуулсан болно. Үүнд:

### **2.2.1 БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулах**

Судалгаанаас харахад хамгийн гол асуудал төсөл хөтөлбөрүүдийн харилцан уялдаа байна. БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр системтэйгээр, илүү тогтвортой хэлбэрээр хэрэгжүүлэх нь мөн чухал байна. Зөвлөх багийн дүгнэснээр БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн чиглэлээр хэрэгжиж буй бүх төсөл, хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдлагаар хангах нэгж байгуулах нь хамгийн чухал юм. Үндэсний хэмжээний санхүүгийн мэдлэгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг Монголбанк хангаж буй учир Зөвлөх багийн зүгээс энэхүү үйл ажиллагааг зохицуулалтаар хангах нь зүйтэй гэж үзэж байна.

Залуучууд болон сургуулийн сурагчдад зориулсан санхүүгийн мэдлэгийн хөтөлбөр амжилттай хэрэгжсэн нэг шалтгаан нь бүх оролцогч талуудын хоорондын нягт харилцан уялдаатай ажиллагаа байсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Монголын банкны холбоо, Хөдөлмөрийн яам, Сангийн яам болон Deutsche Sparkassenstiftung-ийн төлөөллүүдийн идэвхитэй оролцоо бүхий залуучуудын санхүүгийн боловсролын байнгын хороо байгуулж, олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор сонин, сэтгүүл, телевизээр олон улсын сайн туршлагауудыг сурталчлан таниулж байсан нь амжилтын үндэс болсон.

Оролцогч талуудын хурал (хороо/байнгын хороо) байгуулж Монголбанкыг зохицуулагч талаар томилохын тулд бусад талуудтай зөвшилцөх, шаардлагатай эх үүсвэрүүдийг шийдэж өгөх асуудал тулгарна. Бусад оролцогч талуудын хувьд өөрт байгаа материалуудаар хангах, төлөвлөсөн үйл ажиллагаануудтайгаа уялдуулах шаардлагатай бөгөөд үр дүнд нь энэ сэдвээр боловсруулагдсан материалуудын нэгдсэн сан бий болж үйл ажиллагааны давхардал арилна.

## 2.2.2 Олон нийттэй харилцах

Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах нь үр дүнтэй болох нь харагдсан тул Зөвлөх багаас [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn) вэб хуудсыг ашиглан БЖДБ эрхлэгчдэд хүрэх нь зүйтэй гэсэн дүгнэлт хийсэн. Үндсэн вэб хуудасны дотор БЖДБ эрхлэгчдэд зориулсан дэд хуудсыг хөгжүүлж, вэб хуудасны ашиглалтыг сайжруулахын тулд санхүүгийн мэдлэгийг илэрхийлсэн илүү богино нэртэй болгох эсвэл одоогийн нэрээр сурталчилгааг сайн явуулах нь зүйтэй гэж Зөвлөх баг үзсэн.

Одоогийн байдлаар боловсруулагдсан сургалтын материалууд, курс хичээлүүд, гарын авлага болон хэрэглүүрүүдээс (дээр дурьдсан вэб хуудаснаас үнэгүй авах боломжтой) дараах хэсгүүдийг авч ашиглах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

БАГШ, СУРГАГЧ БАГШ НАРТ – Татаж авах боломжтой PDF гарын авлага, хэвлэлүүд

- Мөнгөө хэрхэн удирдах;
- Хадгаламж;
- Зээл;
- Үнийн өсөлт ба ханшийн өөрчлөлт;
- Хөрөнгө оруулалт;
- Эрсдэл ба хэрэглэгчийг хамгаалах;
- Даатгал;
- Татвар таны амьдралд;
- Бизнес гэж юу вэ;
- Бизнесийн төлөвлөлт;
- Бизнесийн ёс зүй;
- Нэр томъёо;
- Бизнесийн судалгаанууд.

### ЗӨВЛӨМЖҮҮД

- Төсөв төлөвлөгчийн гарын авлага;
- Санхүүгийн бүртгэл хөтлөлт, дансны хуулга шалгах;
- Орлого болон зарлага бүртгэх;
- Ирээдүйдээ зориулж хадгалах, хадгаламж яагаад чухал вэ, хадгаламжийн төлөвлөгөө;
- Сайн ба муу өр, өөрт хамгийн тохиромжтой зээлийг сонгох, муу өрөөс зайлсхийх;
- Тогтмол болон хувирах хүү;
- Зээлийн төрлүүд, гадаад вальютаар зээл авах;
- Даатгал, тэтгэврийн даатгал, тэтгэвэр тооцоолох;
- Бизнесээ эхлүүлэх, төсөв төлөвлөлт, татвар, хөрөнгө оруулалт, эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшин.

### ХЭРЭГЛЭГДЭХҮҮНҮҮД – Хэрэглэгдэхүүн/Программ хангамж

- Төсвийн хэрэглэгдэхүүн;
- Банкны хадгаламжийн хэрэглэгдэхүүн;
- Өр зээлийн хэрэглэгдэхүүн;
- Моргажийн хэрэглэгдэхүүн;
- Хадгаламжийн зорилгоо тодорхойлох хэрэглүүр.

## ЗААВАЛ УНШИХ

- Монгол Улсад санхүүгийн мэдлэгийн чиглэлээр гарч буй сүүлийн үеийн өөрчлөлтүүд;
- Үр ашигтай мэдээ, мэдээллүүд;
- Видео, зурган болон текстэн мэдээ, мэдээлэл.

Одоо байгаа материалууд (UNHCR болон OECD/INFE-ийн стандарт, зөвлөмжийн дагуу олон улсын байгууллагууд, донор байгууллагуудтай хамтран боловсруулсан багш, сургагч багшийн гарын авлагууд) нь өндөр чанартай бөгөөд санхүүгийн мэдлэгийн үндсэн сэдвүүдээр шинэ материал боловсруулах нь илүүц гэж Зөвлөх баг үзсэн.

### **2.2.3 БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийн санал болгож буй бүтэц**

Зөвлөх багийн зүгээс үндэсний стратегийн бүтцэд тулгуурлан Монгол Улсад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн загварчлалыг Монголбанкинд зориулан боловсруулсан. Энэхүү үлгэрчилсэн загварчлал нь үндэсний стратегид нэмэлт болж, түүнтэй нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор боловсруулагдсан бөгөөд OECD/INFE-ээс боловсруулсан High-level Principles on National Strategies for Financial Education-ийн зарчмуудыг үндэс болгон ашигласан. Монголбанк нь OECD-ийн боловсролын олон улсын сүлжээний байнгын гишүүн болсон учир дунд хугацааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн төсөл хувилбарт эдгээр зарчмуудыг ашиглах нь илүү тохиромжтой гэж Зөвлөх баг үзсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн загварчлал болон ур чадварын үндсэн шаардлагуудыг энэхүү тайлангийн Хавсралт 4-т хавсаргасан.

### **2.3 3-р үе шат - Сургалтын сэдэв болон хэрэглэгдэхүүнүүдийг эцэслэн батлах**

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд (ер нь аливаа санхүүгийн мэдлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд) авах арга хэмжээнүүд, түүний дотроос сургалт зохион байгуулах чадамж бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Тиймээс сургагч багш нарын сургалтыг зохион байгуулахад ихээхэн анхаарал хандуулсан. Зөвлөх багийн зүгээс төслийн хүрээнд Монголбанкны 20 сургагч багшийг бэлтгэж, төслийн эхнээс дуусах хүртэл сургагч багш нарын үндсэн цөмийг бүрдүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр сургагч багш нар нь эцсийн зорилтот бүлэг (БЖДБ-үүд)-т туршилтын сургалтуудыг явуулахад идэвхитэй үүрэг гүйцэтгэнэ гэж бидний зүгээс тооцоолсон. 2020 оны 11 дүгээр сарын эхэнд Монголбанктай харилцан зөвшилцсөний үндсэн дээр төслийн хүрээнд бусад оролцогч талын 10 сургагч багшийг нэмж бэлтгэхээр тохиролцсоноор эхний төлөвлөгөөнд өөрчлөлт орж, туршилтын сургалт болон сургалтын материалуудын туршилтыг Зөвлөх баг гүйцэтгэхээр болсон. Төслийн төгсгөл шат гэхэд төлөвлөснөөс олон буюу 32 сургагч багшийг бэлтгэсэн.

## 2.3.1 БЖДБ эрхлэгчдэд зориулсан туршилтын сургалтууд

### 2.3.1.1 “Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага” сэдэвт цахим сургалт

“Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага” сэдвээр нийт 9 цагийн, 2 тал өдрийн сургалтыг орон нутгийн зөвлөх багийн сургагч багш Д.Оюунцэцэг, П.Баянсан нар зохион байгууллаа.

- 2021/01/27-ны өдөр 17:00-17:30 цаг хүртэл техникийн туршилтыг хийж, Zoom программ дээр туршсан.
- 2021/01/28-ны өдөр 13:00-17:30 цаг хүртэл 4.5 цагийн сургалт.
- 2021/01/29-ний өдөр 09:00-13:30 цаг хүртэл 4.5 цагийн сургалтыг хийсэн.

Оролцогчдыг цахим сургалтанд бүрэн хамруулахын тулд багш нарын зүгээс “Бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих хөтөлбөр-1” гэх Facebook бүлэг, “Эрсдэл-Цахим сургалт” гэх Мессенжер чат бүлэг үүсгэж оролцогчдыг сургалттай холбоотой нэгдсэн мэдээлэл, сургалтын материалаар хангаж ажилласан. Холбогдох мэдээллийг хавсаргав.

Сургалтад 6 аймгийн БЖДБЭ нийт 37 хүн бүртгүүлснээс сургалтын эхний өдөр 25, сүүлийн өдөр 20 хүн оролцсон. Сургалтанд оролцогчдийн мэдээлэл, ирцийн мэдээллийг энэхүү тайланд хавсаргав.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг Монголын орчин нөхцөлд тохируулан, холбогдох тоо мэдээлэл, эрх зүй, эдийн засгийн баримт бичгүүдээр баяжуулан сургагч багш нарын зүгээс засаж сайжруулсан. Нийт 145 орчим слайд бүхий танилцуулга, MS Excel дээр бэлтгэсэн тооцооллын хүснэгтүүдийг бэлтгэн сургалтанд ашигласан.

Сургалтад оролцогчдыг багаар болон хувиараа оролцох боломжийг хангаж, оролцогчдын оролцоог дэмжиж ажилласан. Сургалтын оролцогчдоор дараах дасгал, кейс, хэлэлцүүлгүүдийг гүйцэтгүүлсэн. Үүнд:

- Хямралын үед авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.
- Бичил, жижиг, дунд бизнесүүдэд тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд-Оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэв.
- Эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө-Багийн ажил.
- Зээлийн төлбөрийн тооцоолол, зээл төлөлтийн хуваарь гаргах-Багаар гүйцэтгэх.
- Банкуудын цахим хуудсан дахь зээлийн тооцоолуур ашиглан зээл төлөлтийн график гаргах, харьцуулах, дүгнэлт гаргах.
- Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн сүүлийн 2 жилийн санхүүгийн тайланд хялбар шинжилгээ хийж хүндрэл бэрхшээлийг тодорхойлох дасгал.

Сургалтын 2 өдрийн бичлэгийг Zoom программаар хийж видео, аудио, текст хэлбэрээр татаж авч архивласан. Сургалтын үйл явцыг төслийн багийн ахлагч Mattias, төслийн ажилтан Буянбат нар хянаж ажилласан.. Сургалтыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.



## Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих төслийн сургалтын хөтөлбөр

2021.01.27.

### Нэг. Сургалтын зорилго:

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгын хүрээнд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хямралын үед эрсдэлийг удирдах, эрсдэлийг давж туулах, санхүүгээ удирдах мэдлэг олгоход оршино.

### Хоёр. Сургалтын зохион байгуулалт

- 2.1. Нийслэл болон орон нутгийн БЖДБ эрхлэгчд 25 оролцогчид зориулсан цахим сургалтыг Zoom программыг ашиглан, хагас өдрөөр зохион байгуулна.
- 2.2. 2021.01.28-ны өдөр 13.00 – 17.30  
2021.01.29-ний өдөр 9.20 – 13.30 цагийн хооронд явуулна.
- 2.3. Оролцогчид тухайн өдрийн сургалтын төгсгөлд сургалтын үнэлгээний хуудсыг бөглөж [yalquulaqch\\_xzx@yahoo.com](mailto:yalquulaqch_xzx@yahoo.com) мэйл хаяг эсвэл Oyuntsetseg Dorjpalam фэйсбүүк хаягаар ирүүлнэ.

### Гурав. Сургалтын хэрэглэгдэхүүн

- 3.1. PPT Лекц
- 3.2. Видео шторк
- 3.3. Зөөврийн болон суурин компьютер, чихэвч, микрофон
- 3.4. Шаардлагатай цахим холбоос
- 3.5. Тэмдэглэлийн дэвтэр, үзэг, бал, тооны машин
- 3.6. Холбогдох цахим тооцоолуур
- 3.7. Кейс дасгал ажиллах EXCEL файл
- 3.8. Өөрийн компанийн сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан

### Дөрөв. Сургалтын үр дүн


Сургалтад оролцогчид энэхүү сургалтад хамрагдсанаар дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

1. Хямралын нөхцөл байдлыг тодорхойлж, бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах мэдлэг олж авна.
2. Эрсдэлээ тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх аргыг сонгож хэрэгжүүлэх талаар мэдлэгтэй болно.
3. Эрсдэлийн удирдлагын загварыг өөрийн бизнесийн онцлогт тохируулж хэрэгжүүлэх эрмэлзэлтэй болно.
4. Санхүүгийн тайланг унших, хялбар шинжилгээ хийх замаар санхүүгийн нөхцөл байдлаа үнэлэх мэдлэгт суралцана.
5. Дээрх сэдвүүдтэй холбоотой хялбар тооцоолуудыг хийж, шийдвэр гаргах чадвартай болно.


### Тав. Сургалтын үед баримтлах дэг

1. Сургалтын туршид микрофоноо хаалттай байлгаж, асуулт асуух болон хариулах үедээ нээнэ.
2. Сургалтын туршид камерийг байнга нээлттэй байлгана.
3. Өөрийн овог, нэрийг бүтнээр бичнэ.
4. Сургалтын явцад асуух асуултаа чат хариуцсан багш руу бичнэ.
5. Сургалтын цагийг чанд баримтална.
6. Сургалтад идэвхтэй оролцож, мэдлэг олж авах, харилцан туршлага солилцохыг эрмэлзэнэ.


## V. Facebook Group дэх сэтгэгдлүүд




ЗУРАГ 2 – ХӨТӨЛБӨРИЙН ХААЛТТАЙ FACEBOOK GROUP



ЗУРАГ 3 – ТУРШИЛТЫН СУРГАЛТУУДЫН CHAT GROUP



ЗУРАГ 4 – SCREENSHOT – 1 ДЭХ ӨДӨР, 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 28



ЗУРАГ 5 – SCREENSHOT – 2 ДАХ ӨДӨР, 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29

## VI. Сургалтын үнэлгээ

### Хүснэгт 1- Сургалтын үнэлгээ – “Хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдлага”

	Маш сайн / Бүрэн санал нийлж байна	Сайн /Санал нийлж байна	Хангалттай / Өөр саналгүй	Хангалтгүй / Санал нийлэхгүй
[Сургалтын агуулга практик амьдралтай холбоотой]	20	4	0	0
[Сургалтаар олж авсан мэдлэг...]	17	6	1	0
[Онлайн сургалтын арга ...]	19	3	2	0
[Багшийн үнэлгээ ...]	22	1	1	0
[Онлайн сургалтын зохион байгуулалт ...]	17	6	1	
[Сургалт миний хүлээлт / хэрэгцээнд нийцсэн ...]	20	3	1	
[Сургалтын талаар төрсөн сэтгэгдэл ...]	21	2	1	
[Сургалтын агуулга надад хамааралтай, хэрэгцээтэй байсан]	23	0	1	

1. Сургалтаас хамгийн их таалагдсан зүйл.
  - Зээлийн төсөвлөлт
  - Эрсдэлийн үнэлгээ
  - Суралцагсдад өгөх мэдлэг
  - Кейс тооцоолол
  - Банкны хүү бодох арга, эрсдэлийн төлөвлөгөө
  - Банкны зээлийн нөхцөл
  - Кейс дээр ажиллах маш өгөөжтэй байлаа
  - Тооцоолуурууд, загвар, дүн шинжилгээний файлууд нь хэрэгтэй байлаа
  - Зээлийн төлөлт
  - Дадлага ажил
  - Эрсдлийн менежментийн талаар цогц ойлголттой боллоо
  - Санхүүгийн тайлан болон эрсдэл бүгд таалагдсан.
  - Санхүүгийн нөөцтэй болох эрсдэлийн төлөвлөгөө хийх шаардлагатайг мэдсэн
  - Эрсдэлийн хэсэг
  - Бух юм тааламжтай байсан
  - Эрсдэлийн удирдлага, санхүү зээлийн тооцоолол
  - Сургалтын арга барил, багш нарын чадвар, кейс дасгал
  - Хичээл ойлгомжтой өгөөжтэй байсан.
  - Амьдралд ойр дөхөм сургалт
2. Сургалтаас сурсан хамгийн чухал зүйл.
  - Эрсдэлийн сан байгуулах

- Байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагааг удирдах
  - Эрсдэлийг удирдах
  - Хуримтлалт, төлөвлөлт, бүртгэл хөтлөл
  - Ersdliin tuluvluguu, hurimtlal zaaval uusgeh
  - Тооцоололууд санхүүгийн
  - Санхүүгийн тайлангаа дүгнэх
  - Эрсдэлийн талаар бодож үзлээ айх сандрах биш боломжуудыг харлаа
  - Balansaa shinjlex
  - Sanhуu shinjilgee, zeeliin tootsoolol
  - Цахим сургалтын ач холбогдол өндөр юмаа гэртээ ажил дээрээ зардалгүй маш их мэдээлэл авах боломжтойг харууллаа
  - Ersdelees hamgaalax shingjilgee hih zeeliin tololt
  - Хямралын үед бизнесээ хэрхэн удирдах
  - Tailan
  - Эрсдэлийг даван туулах чадвар, мэдлэг
  - Хямралаас урдчилан сэргийлэх зээлийн хуваарь
  - Зээлийн төлбөрийн тооцоолол, зээл төлөлтийн хуваарь, эрсдэлийн төлөвлөлт, тооцоолол
  - Huleej haij sudalj bсан zuilsee bureн hemjend mdej avlaa
  - Хямарлын үеийн эрсдэлийг тооцоолох
  - Эрсдэлийн нөөц сан хямарлаас урьдчилан сэргийлэх
3. Сургалтанд нэмж оруулах шаардлагатай сэдэв/асуудал
- Хямралыг давсан сайн туршлага
  - Бусад байгууллагын туршлагаас
  - Санхүүжилтийн бусад боломж
  - Санхүүгийн бүртгэл хөтлөлт, аудит шалгалтанд бэлтгэх, хуулийн мэдээлэл
  - Tsаgаа nemegduuleh
  - Сургалт бүхэлдээ маш их таалагдлаа
  - Өөрсдийн аж ахуй дээр дүн шинжилгээ хийх санаа өгч айдасыг даван туулах боломж олгох тал дээр
  - Sanxvvgiin tuluvluguu
  - Sanhуu hotloh
  - Цахим бизнесийн сургалт
  - Zeel болон tusul bicih orон nutgiin ulsuudad zeel yj avdag talaар yaj tosold hamragdax talaар surgaltnd hamragdmaar bnaa
  - Baihgvi
  - Байхгүй
  - Туршлага харилцан солилцох
  - Харилцан туршлага соллоцох, компанийн үнэлгээ, санхүүгийн шинжилгээ
  - Саналгүй
  - Санхүүгийн шинжилгээ үнэлгээ төсөв төлөвлөлт

### 2.3.1.2 “Цахим худалдаа” сэдэвт цахим сургалт

“Цахим худалдаа” сэдвээр С.Оюунчимэг, Э. Уянга нар тус бүр нийт 9 цагийн, 2 хагас өдрийн сургалтыг зохион байгууллаа.

- 2021/01/27-ны өдөр 17:00-17:30 цаг хүртэл нэгдсэн техникийн туршилтыг хийж, Zoom программ дээр туршсан.
- 2021/01/28-ны өдөр 13:00-17:30 цаг хүртэл 4.5 цагийн сургалт,
- 2021/01/29-ний өдөр 09:00-13:30 цаг хүртэл 4.5 цагийн сургалтыг хийсэн.

Оролцогчдыг цахим сургалтанд бүрэн хамруулахын тулд багш нарын зүгээс “Бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих хөтөлбөр-1” гэх Facebook бүлэг, “Цахим худалдаа” гэх Мессенжер чат бүлэг үүсгэж оролцогчдыг сургалттай холбоотой нэгдсэн мэдээлэл, сургалтын материалаар хангаж ажилласан. Холбогдох мэдээллийг хавсаргав.

“Цахим худалдаа” сургалтад 6 аймаг, Улаанбаатар хотын БЖДБЭ нийт 27 хүн бүртгүүлснээс сургалтын эхний өдөр 25, сүүлийн өдөр 23 хүн оролцсон. Сургалтанд оролцогчдийн мэдээлэл, ирцийн мэдээллийг энэхүү тайланд хавсаргав.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг Монголын орчин нөхцөлд тохируулан, холбогдох тоо мэдээлэл, эрх зүй, эдийн засгийн баримт бичгүүдээр баяжуулан сургагч багш нарын зүгээс засаж сайжруулсан. Тухайн хоёр сэдвээр тус бүр нийт 145 орчим слайд бүхий танилцуулга, MS Excel дээр бэлтгэсэн тооцооллын хүснэгтүүдийг бэлтгэн сургалтанд ашигласан.


Сургалтад оролцогчдыг багаар болон хувиараа оролцох боломжийг хангаж, оролцогчдын оролцоог дэмжиж ажилласан. Сургалтын оролцогчдоор дараах дасгал, кейс, хэлэлцүүлгүүдийг гүйцэтгүүлсэн. Үүнд:

- Цахим худалдааг тодорхойлох тохиолдлын шинжилгээ, хэлэлцүүлэг
- Монгол улс дахь цахим худалдааны хэрэглэгчийн чиг хандлага хэлэлцүүлэг
- Онлайн төлбөр тооцооны хэрэгслийн төрөл, хэрэглээ БЖДБЭ-д тулгарч буй хүндрэл бэрхшээл түүнийг хэрхэн шийдэх талаар хэлэлцүүлэг
- Хэрэглэгчийн бүлэг тодорхойлох дасгал
- Нярайн дэлгүүрийн зорилтот үйлчлүүлэгчийг тодорхойлох хэлэлцүүлэг
- Өөрсдийн бизнесийн харилцагчийн персонаг тодорхойлох дасгал- Багийн ажил
- Тохиолдлын шинжилгээ – Холбоосоор орж онлайн дэлгүүртэй танилцах, түүний бүтэц, үйл ажиллагааг судлах
- Тусгай дугаарыг хэрхэн цахим худалдааны борлуулалтад хэрэглэх талаар хэлэлцүүлэг
- Цахим худалдааны санхүүгийн аюулгүй байдалтүүнийг хэрхэн баталгаажуулах, анхаарах асуудлын талаар багийн хэлэлцүүлэг


Сургалтын 2 өдрийн бичлэгийг Zoom программаар хийж видео, аудио, текст хэлбэрээр татаж авч архивласан. Сургалтын үйл явцыг төслийн багийн ахлагч Mattias, төслийн ажилтан Буянбат нар хянаж ажилласан. Сургалтыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.

### 2.3.1.2.1 Сургалт

## I. Сэтгэгдлүүд



ЗУРАГ 7 – SCREENSHOT – 1 ДЭХ ӨДӨР, 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 28



ЗУРАГ 8 – SCREENSHOT – 1 ДЭХ ӨДӨР, 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29

## II. Сургалтын үнэлгээ

## Хүснэгт 2 - Сургалтын үнэлгээ – “Цахим худалдаа”

Үнэлгээ	Маш сайн / Бүрэн санал нийлж байна	Сайн / Санал нийлж байна	Хангалттай / Өөр саналгүй	Хангалтгүй / Санал нийлэхгүй
Сургалтын агуулга надад хамааралтай, хэрэгцээтэй байсан	25	9	-	-
Сургалтын агуулга практик амьдралтай холбоотой	18	16	-	-
Сургалтаар олж авсан мэдлэг...	15	17	2	-
Онлайн сургалтын арга ...	19	14	1	-
Багшийн үнэлгээ ...	24	8	2	-
Онлайн сургалтын зохион байгуулалт ...	22	12	-	-
Сургалт миний хүлээлт / хэрэгцээнд нийцсэн ...	18	16	-	-
Сургалтын талаар төрсөн сэтгэгдэл ...	18	14	2	-

Сургалтаас хамгийн их таалагдсан зүйлс юу вэ?

- Зохион байгуулалт, агуулга
- Бүгд
- Сэдэв
- Багш нарын ур чадвар
- Багийн ажиллагаа
- Хэрэглэгчийн персонаг тодорхойлох
- Цахим худалдааны платформ дээр худалдаа хийх
- Хэлэлцүүлгүүд
- Дасгалууд
- Хэрэглэгчийн итгэлийг олж авах талаар мэдээлэл
- Ашигласан жишээнүүд
- Цахим худалдаа 3 том платформын ялгааг ойлгосон
- Сургалтын арга
- Бизнесийн утастай байх
- Сургалтын сэдэв цаг үеэе олсон



- Бизнес тээ хэрэгжүүлэх санаанууд авсан
- Цахим худалдааны маркетинг
- Оюунчимэг багшийн хичээлүүд

Энэхүү сургалтаас таны сурсан хамгийн чухал зүйл юу вэ?

- Онлайн төлбөр
- Цахим худалдааны платформууд
- Персона дээр тулгуурлан зорилтот бүлгийг тогтоох
- Кибер аюулгүй байдал
- Цахим худалдаа 3 том платформын ялгаа
- Цахим худалдааны давуу талууд
- Хэрэглэгчтэй харилцахын ач холбогдол
- Цахим худалдааны бүтээгдэхүүнийг эргүүлж өгөх
- website ба webstore-ийн ач холбогдол
- webstore, marketplace ба олон нийтийн сүлжээний ялгаа
- Цахим худалдааны талаар мэдэхийг хүссэн бүхнээ мэдсэн
- Бизнесийн утастай болох

Сургалтанд нэмж оруулбал зүйтэй ямар сэдэв / асуудал байна вэ?

- Дижитал маркетинг
- Хэрэглэгчийн худалдан авалтын цикл
- Сургалтын агуулгын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл
- Facebook дээр boost хийх дасгал
- Сургалтын материалыг оролцогчдод тараах
- Англи үг ашиглахгүй байх
- Дасгал, группээр ажиллах

## 2.4 4-р үе шат – Хэрэгжүүлэлт

### 2.4.1 Сургагч багш бэлтгэх сургалт

Сургалтыг 2021.02.09-10-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтын 2 өдрийн бичлэгийг Zoom программаар хийж видео, аудио, текст хэлбэрээр татаж авч архивласан. Сургалтад нийт 32 хүн хамрагдсан. Сургалтын удирдамжийг Хавсралт 1-д, сургалтад оролцогчдийн мэдээлэл, ирцийн мэдээллийг харуулав.

Сургалтын хүрээнд дараах 2 модулыг 4 сургагч багш удирдан заасан байна. Үүнд:

- Цахим худалдаа – С.Оюунчимэг, Э.Уянга
- Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага – Д.Оюунцэцэг, П.Баянсан

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг БЖДБ бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтад оролцогчдоос ирүүлсэн саналыг үндэслэн засаж сайжруулсан. 2 модулийн хүрээнд нийт 260 гаруй хуудас слайд бэлтгэсэн. Нийт 7 дасгал ажлыг тохиолдол шинжлэх, судалгаа хийх, тооцоолол хийх, хэлэлцүүлэг хийх зэрэг сургалтын аргыг хэрэглэн зохион байгуулсан.

Сургалтын үр дүнг үнэлэх санал, асуулгыг Google Form ашиглан бэлтгэж, линкийг оролцогчдод хүргүүлж саналыг авч нэгтгэсэн. Үнэлгээг 2 өдрийн давхардсан тоогоор 35 хүн бөглөсөн.

#### 2.4.1.2.1 Сургагч багш бэлтгэх сургалтын удирдамж

### Нэг. Сургалтын зорилго:

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих зорилгын хүрээнд

- бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хямралын үед эрсдэлийг удирдах, эрсдэлийг давж туулах, санхүүгээ удирдах
- бизнесийн борлуулалтаа цахим хэлбэрт шилжүүлэх, цахим худалдаагаар дамжуулах бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах

зэрэг мэдлэг, чадвар олгох сургагч багш бэлтгэхэд оршино.

### Хоёр. Сургалтын зохион байгуулалт

Сургагч багш нарт зориулсан цахим сургалтыг Zoom программыг ашиглан зохион байгуулна.

- 2021.02.09-ний өдөр 9.00 – 17.00
- 2021.02.10-ны өдөр 9.00 – 17.00 цагийн хооронд явуулна.

Оролцогчид сургалтын төгсгөлд сургалтын үнэлгээний хуудсыг бөглөнө.

### Гурав. Сургалтын хэрэглэгдэхүүн

- PPT Лекц
- Видео шторк
- Зөөврийн болон суурин компьютер, чихэвч, микрофон
- Шаардлагатай цахим холбоос
- Тэмдэглэлийн дэвтэр, үзэг, бал, тооны машин
- Холбогдох цахим тооцоолуур
- Кейс дасгал ажиллах EXCEL файл

### Дөрөв. Сургалтын үр дүн

Сургагч багш энэхүү сургалтад хамрагдсанаар дараах мэдлэгийн хүрээнд, БЖДБ эрхлэгчдэд санхүүгийн боловсролын сургалт зохион байгуулах чадвар, арга зүйг эзэмшинэ.

Хямралын үед эрсдэлийг удирдах сэдвийн хүрээнд:

1. Хямралын нөхцөл байдлыг тодорхойлж, бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах мэдлэг олж авна.
2. Эрсдэлээ тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх аргыг сонгож хэрэгжүүлэх талаар мэдлэгтэй болно.
3. Эрсдэлийн удирдлагын загварыг өөрийн бизнесийн онцлогт тохируулж хэрэгжүүлэх эрмэлзэлтэй болно.
4. Санхүүгийн тайланг унших, хялбар шинжилгээ хийх замаар санхүүгийн нөхцөл байдлаа үнэлэх мэдлэгт суралцана.
5. Дээрх сэдвүүдтэй холбоотой хялбар тооцоолуудыг хийж, шийдвэр гаргах чадвартай болно.

Цахим худалдаа сэдвийн хүрээнд:


1. Цахим худалдааны дэлхийн болон МУ-ын чиг хандлага, хэрэглэгчийн зан төлөвтэй танилцах, зорилтот хэрэглэгч буюу персона тодорхойлох
2. Цахим худалдаа гэж юу болох түүний төрөлтэй танилцах, онцлогыг мэдэх
3. Цахим худалдааны төрлийг хэрхэн өөрийн бизнес, бүтээгдэхүүнд тохируулан сонгох, анхаарах зүйл
4. Цахим худалдааны төлбөр тооцоо, түүний төрөл онцлог, хэрхэн хэрэглэх зэрэг

5. Цахим худалдааны аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангах арга зэрэг мэдлэгтэй болно


### Тав. Сургалтын үед баримтлах дэг

1. Сургалтын туршид микрофоноо хаалттай байлгаж, асуулт асуух болон хариулах үедээ нээнэ.
2. Сургалтын туршид камерийг байнга нээлттэй байлгана.
3. Өөрийн овог, нэрийг бүтнээр бичнэ.
4. Сургалтын явцад асуух асуултаа чат хариуцсан багш руу бичнэ.
5. Сургалтын цагийг чанд баримтална.
6. Сургалтад идэвхтэй оролцож, мэдлэг олж авах, харилцан туршлага солилцохыг эрмэлзэнэ.

### VI. Сэтгэгдлүүд



ЗУРАГ 9 – SCREENSHOT – 1 ДЭХ ӨДӨР



**ЗУРАГ 10 – SCREENSHOT – 2 ДАХ ӨДӨР**

## VII. Сургалтын үнэлгээ

### Хүснэгт 3 – Сургалтын үнэлгээ – “Сургагч багшийн сургалт”

Сургалтын үр дүнг оролцогчид дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

Асуулт	Бүрэн санал нийлж байна, хувиар	Санал нийлж байна, хувиар	Дундаж, хувиар	Санал нийлэхгүй хувиар
Сургалтын агуулга цаашид бизнес эрхлэгчдэд заахад хэрэгтэй	71.4	25.7	2.9	0
Сургалтын агуулгыг бизнес эрхлэгчид амьдрал, бизнестээ шууд ашиглаж болохуйц байна.	45.7	51.4	2.9	0
Сургалтаар олж авсан мэдлэг	28.6	45.7	25.7	0
Онлайн сургалтын арга барил	34.3	54.3	11.4	0
Багшийн ур чадвар	55.9	29.4	14.7	0
Онлайн сургалтын зохион байгуулалт	57.1	37.1	5.8	0
Сургалт миний хүлээлт / хэрэгцээнд нийцсэн	41.2	50	8.8	0
Сургалтын талаар миний сэтгэгдэл	42.9	48.6	8.6	0

1. Сургалтаас хамгийн их таалагдсан зүйл.

№	Сургалтаас хамгийн их таалагдсан зүйл	Оролцогчдын саналын тоо, давхардсан тоогоор
1.	Зээл төлөлтийн хуваарийн бодолт	4
2.	Багийн ажил	4
3.	Багшийн тайлбар	2
4.	Багш нарын мэдлэг	1
5.	Мэдлэгийн зогсоол	1
6.	Онлайн бизнес	2
7.	Багш нарын үйл ажиллагаа	1
8.	Бүх зүйл	4
9.	Санхүүгийн тооцоолол	1
10.	Цахим худалдаа хийх боломж	1
11.	Эрсдэлийн төлөвлөгөө	1
12.	Эрсдэлийн удирдлага	3
13.	Персона тодорхойлох	2
14.	Сургалтын арга барил	2
15.	Мэдээ, мэдээлэл	1
16.	Харилцан санал солилцох, хамтран ажиллах	1

2. Сургалтаас сурсан хамгийн чухал зүйл

№	Сургалтаас сурсан хамгийн чухал зүйл	Оролцогчдын саналын тоо, давхардсан тоогоор
1	Зээл төлөлтийн хуваарийн бодолт	3
2	Тохиолдлын шинжилгээ	2
3	Онлайн борлуулалт хийх боломж	1
4	Санхүүгийн шинжилгээ, тооцоолол	4
5	Цахим худалдаа	9
6	Эрсдэл ба хямралаас урьдчилан сэргийлэх	1
7	Эрсдэлийн удирдлага	7
8	Эрсдэлийн матриц	1
9	Персона тодорхойлох	3
10	Хэрэгцээтэй мэдээлэл	2
11	Компанийн сайтууд	1

3. Сургалтанд нэмж оруулах шаардлагатай сэдэв/асуудал

№	Сургалтаас сурсан хамгийн чухал зүйл	Оролцогчдын саналын тоо, давхардсан тоогоор
1.	Эрсдэлийг үнэлэх арга зүй	2
2.	Сэдвийн бодит жишээ, кейс	1
3.	Суралцагчдыг идэвхижүүлэх шинэлэг арга барил	1
4.	Хичээл бүрийн дараа багийн ажил хийлгэх	1
5.	Тухайн байгууллагын одоогийн бизнесийн нөхцөл байдлыг сургалтын дараах ямар түвшинтэй харьцуулсан судалгаа хийх	1

6.	Санхүүгийн үйл ажиллагааг хэрхэн зохистой явуулах	1
7.	Эрсдэлийн удирдлагын модуль гаргах	1
8.	Борлуулалт нэмэгдүүлэх	1
9.	Хөрөнгийн зах зээлийн мэдээлэл	1
10.	Санхүүгийн шинжилгээний хүснэгт графикийн хамт гардаг байх	1
11.	Зарим зүйлийг хасах	1
12.	Санхүүгийн тайланг унших, шинжилгээ хийх	1
13.	Санхүүгийн тайлангийн шинжилгээ, зээл төлөлтийн хуваарь зэргийг хангалттай цагаар орох	1

Сургалтад оролцогчдын дээрх саналд үндэслэн сургалтын слайдыг дахин сайжруулж, өөрчлөлт хийсэн.

#### 2.4.2 Эцсийн зорилтот бүлэг (БЖДБ-үүд)-ийн сургалт

Туршилтын сургалтууд болон сургагч багш нарын сургалтын үр дүнд тулгуурлан сургалтын материалуудад дахин дүн шинжилгээ хийж, оролцогч, сургагч багш нарын санал, зөвлөмжүүдийг тусгасан. Ийнхүү тусгахдаа сургалтын материалыг жижиг хэсгүүдэд хувааж, жишээнүүдийг илүү энгийн болгож, “Хямралын үеийн удирдлага болон бизнесийн төлөвлөлт” хэсгийг хуваасан. Эцсийн зорилтот бүлэг (БЖДБ)-ын сургалтыг Монголбанкаас хариуцсан хоёр сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Багш сургагчийн сургалтыг амжилттай дүүргэсэн сургагч багш нар энэхүү хоёр сэдвээр тус тусдаа сургалтуудыг зохион байгуулсан. Бүх сургалт 2021 оны 03 дугаар сард Zoom программаар явагдсан бөгөөд төслийн дотоод зөвлөхүүд сургалтын үйл явцыг ажиглаж оролцсон. Эхний өдөр оролцсон нийт 86 оролцогчоос 67 нь хоёрдахь өдрийн сургалтанд оролцсон.

Монголбанкнаас нэгтгэсэн “Хямралын үеийн удирдлага болон бизнесийн төлөвлөлт” болон “Цахим худалдаа” сургалтуудын дэлгэрэнгүй тайланг Хавсралт 14 болон 15-д оруулсан болно.

#### 2.5 5-р үе шат – Хяналт, үнэлгээ ба үндэсний хэмжээний хурал

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийг танилцуулах үндэсний хурал болон Дэлхийн мөнгөний долоо хоног 2021-ийн нээлт 2021 оны 03 дугаар сарын 22-нд зохион байгуулагдсан. Хурал оролцогчдыг бүртгэл явагдаж дууссаны дараа Улаанбаатарын цагаар 15 цагаас нээж, нийт 92 оролцогчтой явагдаж Улаанбаатарын цагаар 18:10-т өндөрлөсөн.

Хурлыг Монголбанкны Олон нийтийн санхүүгийн боловсролын төвийн ахлах эдийн засагч Н. Батжин удирдан явуулсан бөгөөд хүндэт зочид, төлөөлөгчид хурлыг нээж үг хэлсэн.


##### Нээлтийн үг:

- Монголбанкны дэд ерөнхийлөгч Ноён Энхтайван хурлыг нээж хэлсэн үгэндээ санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр нь БЖДБ-үүдийн

санхүүгийн үйл ажиллагааг сайжруулаад зогсохгүй Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал эерэг нөлөө үзүүлэх учраас Монголбанкны зүгээс БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг бэхжүүлэх талаар онцгойлон анхаарч байгааг онцлон тэмдэглэсэн. Тэрээр мөн энэхүү ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд хамтрагч талуудыг оролцоо чухал гэдгийг онцлоод Европын Холбоо болон ЕСБХБ-ны тусламж дэмжлэгт талархал илэрхийлсэн.

- ЕСБХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгч Ноён Ханнес Такач БЖДБ эрхлэгчдэд тогтвортой бизнесийн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, цаашлаад БЖДБ-үүдийн өрсөлдөх чадвар, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд санхүүгийн боловсролын гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэсэн. Ноён Такач мөн цахим худалдаа болон хямралын үеийн удирдлага, бизнесийн төлөвлөлтийн шинэ сэдвээр сургалтын материал гарсанаар цар тахлын үед БЖДБ эрхлэгчдэд ихээхэн ач холбогдолтой гэдгийг нэмж хэлсэн.
- Европын Холбооны Монгол дахь төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны газрын багийн ахлагч Ноён Пьер Ивэс Лукас хэлсэн үгэндээ БЖДБ-үүд нь ажлын байр бий болгох, эдийн засгийг солонгоруулах, хувийн секторыг хөгжүүлэх хөдөлгөгч хүч болж байдаг учраас БЖДБ-ийн чадамжийг бий болгох, санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлсэнээр тэдний дотоод, гадаадын зах зээлд гарах боломжоор хангах нь чухал болохыг онцолсон. Санхүүгийн мэдлэг нь БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн удирдлагыг сайжруулдаг учраас чухал ач холбогдолтой бөгөөд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг сайжруулахаас гадна хэрэглэгчдийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах шаардлагатай байгааг тэрээр мөн дурьдсан.
- Санхүүгийн боловсролын группийн дэд ерөнхийлөгч Ноён Шон Мунди Монгол Улсад санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгааг дурьдаад, БЖДБ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагыг сайтар тодорхойлох нь чухал бөгөөд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бизнес эрхлэгчдийн хувийн санхүүгийн боловсролд давхар анхаарах шаардлагатай байгааг онцолсон.
- OECD-ийн Хэрэглэгчийн санхүү, даатгал болон тэтгэврийн хэлтсийн дарга, OECD/INFE-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга хатагтай Флор-Анн Месси нээлтийн хэсгийг хааж хэлсэн үгэндээ COVID-19 цар тахлын хор хөнөөлийг хамгийн ихээр мэдэрч буй салбар нь БЖДБ-үүд учраас санхүүгийн боловсролын асуудлыг хөндөх хамгийн тохиромжтой үе нь одоо болохыг дурьдсан. OECD-ийн зүгээс Санхүүгийн боловсролтой холбоо зөвлөмж гаргасан бөгөөд COVID-19-ийн нөлөөгөөр үүссэн хүндрэлүүдийг давж гарахад арга хэрэгсэл нь БЖДБ-үүдийн хувьд санхүүгийн боловсрол гэж үзэж байгааг тэрээр илтгэлдээ сануулсан. Санхүүгийн боловсролтой холбоотой уг зөвлөмжид санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн боловсруулах/хэрэгжүүлэх, үнэлэх хэрэглэгдэхүүн болон санхүүгийн чадамжийг хэрхэн бий болгох талаар зөвлөмжийн материалууд оржээ. Тэрээр OECD-ийн зүгээс БЖДБ-үүдийг дэмжих дараагийн алхамуудыг тодорхойлох зорилгоор өгөгдөл цуглуулж байгааг мэдээлж, дэлхийн 100 гаруй улс оролцож буй Мөнгөний долоо хоногийн талаар онцолсон.

Нээлтийн үгийн дараа оролцогчдын групп зургийг авсан.



### ЗУРАГ 11 – SCREENSHOT ҮНДЭСНИЙ ХУРАЛ

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан Сургагч багш нарын сургалтын үйл явц, уур амьсгалын талаар ойлголт өгөх зорилгоор богино хэмжээний бичлэгийг оролцогчдод сонирхуулсан.

Зөвлөх багийн гишүүд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн талаар дараах танилцуулгуудыг бэлтгэж танилцуулсан. Үүнд:

Дотоодын ахлах зөвлөх **Хатагтай Д.Оюунцэцэг** дотоодын мэргэжилтнүүдийн багийн гүйцэтгэсэн ажлуудын тайланг танилцуулсан. Түүний илтгэлд 101 БЖДБ эрхлэгчээс авсан судалгаа, 52 БЖДБ эрхлэгчдийн дунд явуулсан туршилтын сургалт болон 32 сургагч багшийн дунд зохион байгуулсан Сургагч багш нарын сургалтын үр дүн (Хавсралт 16)-г танилцуулсан.

**German Sparkassenstiftung-ийн Монгол Улс дахь суурин төлөөлөгч Ноён Маркус Лох** Сургагч багш бэлтгэх сургалтын шинэ хандлага, 3 тулгуурт сургалт, суралцагчидтай харилцах шинэ хандлагын талаар сонирхолтой танилцуулга хийсэн (Хавсралт 17).

**IPC GmbH-ийн Төв Ази, Монгол Улсын хариуцсан бүсийн захирал, олон улсын ахлах зөвлөх Хатагтай Марга Шек** БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг Хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлалыг танилцуулсан. Түүний танилцуулгад Зөвлөх багийн хийсэн дүгнэлт, гаргасан зөвлөмжүүд болон хөтөлбөрийн үндсэн бүтэц болон үе шатуудыг хэрхэн тодорхойлсоныг дэлгэрэнгүй тайлбарласан. Хатагтай Шек энэ чиглэлээр



оролцогч талуудын хооронд зохицуулалт хийх шаардлагатай байгааг онцолж, зохицуулагч нэгжийн удирдлага доор оролцогч талуудын уулзалтыг тогтмол хийдэг байх, энэхүү зохицуулагч нэгж нь Монголбанк байх боломжтой талаар илтгэлдээ дурьдсан. Зөвлөх багийн боловсруулсан хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлал нь БЖДБ эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, зорилтот бүлэг бүрт чиглэсэн (үлгэрчилсэн аргачлалд заасан 5 зорилтот бүлэг) сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн байнгын хяналт, үнэлгээг хангахад төвлөрсөн. Хатагтай Шек танилцуулгаа БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хувь хүний санхүүгийн боловсролын нэг хэсэг болгож авч үзэхийн чухлыг онцолж дуусгасан (Хавсралт 18).

Эдгээр танилцуулгуудын араас оролцогч талуудын төлөөлөл болон сургагч багшийн сургалтын оролцогчид санал, дүгнэлтүүд хэлсэн.

### Оролцогч талуудын хийсэн тайлбар:

- **Жижиг, дунд үйлдвэрийн газрын Хатагтай Ундрал** тус газар 68,000 БЖДБ-үүдэд санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ үзүүлсэн талаар дурьдсан. Тэрээр мөн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлж, сургалтын материалуудыг боловсруулж, туршилтын сургалтуудыг явуулсанд талархал илэрхийлсэн.
- **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Ноён Сугарбаяр** БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд тус яамны гүйцэтгэж буй үүргийн талаар дурьдаад яамны зүгээс одоогоор ЖДБ-ийг хөгжлийг дэмжих хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа талаар мэдээлсэн.
- **Санхүүгийн зохицуулах хорооны Хатагтай Д. Дашням** хөтөлбөрт бичил бизнесүүдийг оруулсан нь маш зохимжтой бөгөөд хөтөлбөрийн хүрээнд хамарсан сэдвүүд нь цаг үеэ олсон болохыг онцолсон.
- **Ms Orkhonbayar M., Mongolian Women's Federation (MWF)**, provided information on MWF's participation in the financial literacy programme in training rural area residents. She underlined that the majority of businesses in Mongolia are women-owned or womenrun businesses and that the training topics and timing are optimal. Монголын эмэгтэйчүүдийн холбооны Хатагтай Отгонбаяр

### Үүний дараа явагдсан асуулт хариултын хэсэгт:

**Асуулт:** Mr Matthias Fohs, Consultant Project Manager, Head of Division Europe / Central Asia / Mediterranean, German Sparkassenstiftung-ийн Европ / Төв Ази / Газар дундын тэнгисийн бүсийн хэлтсийн дарга, төслийн зөвлөх менежер Ноён Матиас Фохс санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн дараагийн хөтөлбөр болон БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуулт тавив.

**Хариулт:** Монголбанкны ахлах эдийн засагч Ноён Батжин БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр нь урт хугацаанд хэрэгжинэ гэсэн ойлголттой байгаагаа илэрхийлсэн. Тэрээр мөн Монголбанкны зүгээс оролцогч талуудын ажлын хэсгийг байгуулсанаас гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран илүү олон БЖДБ эрхлэгчдийг сургах дэд хөтөлбөр хэрэгжүүлж эхлэж байгааг мэдээлсэн.

**Асуулт:** Монголбанкны Хатагтай Одонтунгалаг шинээр боловсруулсан сургалтын сэдвүүд цөөн бөгөөд зээл гэх мэт чухал шаардлагатай бусад сэдвээр сургалтын материал боловсруулах нь чухал болохыг онцолсон.

**Хариулт:** German Sparkassenstiftung-ийн Ноён Матиас Фохс энэхүү асуултын хариулт болгож Зөвлөх багийн хийсэн судалгааны үр дүнгээс жишээ авсан. Судалгаанаас харахад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр/сургалтууд олноор боловсруулагдсан бөгөөд шинэ материал боловсруулахаас илүүтэй эдгээрийн хоорондын уялдааг хангах нь чухал болох нь харагдсан. Тиймээс оролцогч талуудын хоорондын зохицуулалтыг хангах үүднээс байнгын үйл ажиллагаатай оролцогч талын хуралыг Монголбанкны удирдлага доор зохион байгуулдаг болох нь чухал. Төслийн хүрээнд боловсруулсан 2 шинэ сэдэв нь Монгол Улсын хэмжээнд өмнө нь боловсруулаагүй сэдвүүд байсан бөгөөд цар тахлын өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой юм.

**Асуулт:** Монголын эмэгтэйчүүдийн холбооны Хатагтай Отгонбаяр БЖДБ эрхлэгчдэд зориулсан сургалттай хослуулан вакум сургалт хийх нь үр дүнтэй байж болох талаар дурьдсан.

**Хариулт:** IPC GmbH-ийн Хатагтай Марга Шек БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр нь олон сувгаар хэрэгжих боломжтой бөгөөд санхүүгийн боловсролын одоогийн вэб хуудсанд БЖДБ-үүдэд зориулсан дэд хуудсыг хөгжүүлж, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх боломжтой талаар хариулт хэлсэн.

Асуулт хариултын хэсгийн дараа **Монголбанкны дэд ерөнхийлөгч Ноён Г. Энхтайван** ЕХ, ЕСБХБ болон Монголбанкны хамтарсан гэрчилгээг сонгогдсон сургагч багш нарт гардуулсан.

Хурлын төгсгөлд **Монголбанкны ахлах эдийн засагч Ноён Батжин** Дэлхийн мөнгөний долоо хоногийн Монгол дахь нээлтийн видеог танилцуулсан. Тэрээр санхүүгийн мэдлэг, боловсролыг дэлгэрүүлэхэд Дэлхийн мөнгөний долоо хоногийн гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэж, 2013 оноос хойш Дэлхийн мөнгөний долоо хоногийн хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар танилцуулсан.

### 3 Дүгнэлтүүд

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт нь хувь хүмүүсийн санхүүгийн боловсролыг орлох биш, түүний нэг хэсэг болж явагдах ёстой. Монгол Улсад хэрэгжиж ирсэн төсөл, хөтөлбөрүүдэд суурилан БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг стратегийн хэмжээнд, урт хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх боломж байна. Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны стратегийн хүрээнд хүлээсэн зохицуулагчийн үүргээрээ дамжуулан Монголбанк нь Монгол Улсын БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн боломжтой. Энэ чиглэлээр оролцогч талуудын үйл ажиллагааны харилцан уялдааг хангахын тулд оролцогч талуудын байнгын ажиллагаатай хурал/хороог байгуулах шаардлагатай. Төслийн багийн зүгээс боловсруулж Монголбанкинд хүлээлгэн өгсөн Хэрэгжүүлэх

үлгэрчилсэн аргачлалыг стратеги болгон ашиглах, Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудын нарийвчилсан чиглэл болгон ашиглах боломжтой. Энэхүү үлгэрчилсэн аргачлалд багтсан хэрэглэгдэхүүнүүд нь БЖДБ эрхлэгчдэд чиглэсэн арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн секторын тогтвортой байдлыг хангах үндэс болно. БЖДБ эрхлэгчид хүн амын ихэнх хувийг эзэлж, ажил эрхлэлт, орлогын хамгийн том хувийг эзэлдэг Монгол Улсын хувьд энэхүү стратеги нь маш чухал ач холбогдолтой юм. Бизнесээ эхлүүлэх төлөвлөж буй, эсвэл хувийн бизнесээ явуулж буй хувь хүмүүсийн хувьд бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэх боломжоо нэмэгдүүлэхийн тулд дор хаяж бизнесийн санхүүгийн анхан шатны мэдлэгтэй байх нь чухал юм. БЖДБ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэгийг ноу-хауг өгсөнөөр илүү амжилттай үйл ажиллагаа явуулах, эргээд энэ нь санхүүгийн байгууллагуудын тогтвортой байдалд нөлөөлөх ач холбогдолтой. Эцэст нь хэлэхэд Монгол Улсын БЖДБ эрхлэгчдэд COVID-19 цар тахал хүндээр нөлөөлсөн бөгөөд энэхүү шуургыг давж гарахад хувь хүн, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг чухал үүрэг гүйцэтгэх болно.

## 4 Хавсралтуудын жагсаалт

Хавсралт 1	Асуулга: Монголын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлага
Хавсралт 2	Монгол Улсын БЖДБ эрхлэгчдийн СБ-ын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд оролцогчдыг сонгосон шалгуурууд
Хавсралт 3	Монголын БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлага
Хавсралт 4	Монгол улсын Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг Хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлал
Хавсралт 5	Арга хэмжээнүүдийг нарийвчлан төлөвлөх хүснэгт
Хавсралт 6	Хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдлага сургалтын үнэлгээ
Хавсралт 7	Хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдлага сургалтын оролцогчдын жагсаалт
Хавсралт 8	Цахим худалдаа сургалтын үнэлгээ
Хавсралт 9	Онлайн сургалт: Онлайн үйл ажиллагаа зохион байгуулах нь танилцуулга
Хавсралт 10	Сургагч багшийн сургалтын хөтөлбөр “Эрсдэлийн удирдлага”
Хавсралт 11	“Эрсдэлийн удирдлага” сургалтын оролцогчдын жагсаалт
Хавсралт 12	Сургагч багшийн сургалтын хөтөлбөр “Цахим худалдаа”
Хавсралт 13	“Цахим худалдаа” сургалтын үнэлгээ
Хавсралт 14	“БЖДБ-ийн цахим худалдаа” сэдэвт сургалтын тайлан
Хавсралт 15	“БЖДБ-ийн хямралын үеийн эрсдэлийн ба санхүүгийн удирдага” сэдэвт сургалтын тайлан
Хавсралт 16	Үндэсний зөвлөх багийн тайлан
Хавсралт 17	Сургагч багш нарыг бэлтгэх шинэ арга танилцуулга
Хавсралт 18	Олон улсын зөвлөх багийн тайлан

# Хавсралт 1



## Асуулга: Монголын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл (БЖДУ) эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлага

Асуулгад оролцогчийн код:			
Огноо:		Цаг:	
Асуулга авсан хүний нэр:			

### Асуулга авагчийн товч танилцуулга

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD), Монголбанкны захиалгаар Шпаркассэ банкны сан болон Ай Пи Си (IPC) компани хамтран бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус хөтөлбөрийн нэг зорилго нь санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үнэлгээ хийж, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг 100 аж ахуйн нэгжийг хамруулах юм. Энэхүү асуулгын үр дүнд бид та бүхний хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг хэрхэн хүргэх нь зүйтэй болохыг тодорхойлох болно.

Судалгааны үр дүнг нэргүй үлдээнэ гэдэгт та бүү эргэлзээрэй.

Уг судалгааг бөглөхөд цаг их зарцуулахгүй. Таны цаг их үнэтэй гэдгийг бид бодолцож, 20 минутаас ихгүй хугацаа зарцуулах асуулга боловсруулсан.

## 1. Асуулгад оролцогчийн мэдээлэл

### 1.1 Хүйс:

Эр	<input type="checkbox"/>
Эм	<input type="checkbox"/>

### 1.2 Нас:

25 хүртэл	<input type="checkbox"/>
25-34	<input type="checkbox"/>
35-44	<input type="checkbox"/>
45-54	<input type="checkbox"/>
55-64	<input type="checkbox"/>
65-аас дээш	<input type="checkbox"/>

### 1.3 Боловсрол:

Бүрэн бус дунд	<input type="checkbox"/>
Бүрэн дунд	<input type="checkbox"/>
Мэргэжлийн боловсрол	<input type="checkbox"/>
Бакалавр	<input type="checkbox"/>
Магистр	<input type="checkbox"/>
Доктор	<input type="checkbox"/>
Мэргэжлийн боловсрол (төгсөөгүй)	<input type="checkbox"/>
Их, дээд сургууль (төгсөөгүй)	<input type="checkbox"/>
Бусад _____	<input type="checkbox"/>

## 2. Бизнесийн мэдээлэл

### 2.1 Бизнесийн чиглэл:

Худалдаа	<input type="checkbox"/>
Үйлчилгээ	<input type="checkbox"/>
Үйлдвэрлэл / гар урлал	<input type="checkbox"/>
ХАА / газар тариалан / мал аж ахуй	<input type="checkbox"/>
Бусад: _____	<input type="checkbox"/>

### 2.2 Ажилтны тоо (НДШ төлдөг):

1-9	<input type="checkbox"/>
10-50	<input type="checkbox"/>
50-200	<input type="checkbox"/>

### 2.3 Танай жилийн борлуулалтын хэмжээ (төгрөгөөр):

300 саяас бага	<input type="checkbox"/>
300 сая - 1 тэрбум	<input type="checkbox"/>
1 тэрбум – 2.5 тэрбум	<input type="checkbox"/>

**Бизнесийн төрөл:** 2.2 болон 2.3-д үндэслэн асуулга авагч бизнесийн төрлийг тодорхойлж, бөглөнө: бичил, жижиг, дунд (энэ хэсгийг ярилцлагын дараа бөглөх боломжтой.)

Бичил  Жижиг  Дунд

### 3. Бизнесийн удирдлагын мэдээлэл

#### 3.1 Та өөрийн бизнесээ тогтмол төлөвлөдөг үү?

Тийм  1 2 4 12 52 365  
Үгүй

#### 3.2 Та бизнесээ явуулахад хамгийн чухал хэрэг болдог зүйлсийг дахин шинээр авах шаардлагатай болсон гэж төсөөлье. Та юу хийх вэ? Доорх үйлдлүүдийн алийг нь хийх байсан бэ?

Бизнес түр хөндрөл үүсэхэд хэрэглэхээр төлөвлөсөн мөнгөө ашиглана.

Даатгалаа ашиглана.

Зээл авна.

Хувийн хуримтлалаа ашиглана.

Гэр бүл эсвэл найз нөхдөөсөө тусламж хүснэ (мөнгө эсвэл бараа/тоног төхөөрөмж).

Бизнесээ түр эсвэл бүр зогсооно.

Мэдэхгүй байна, ийм нөхцөлийн талаар өмнө нь огт бодож байгаагүй.

Бусад \_\_\_\_\_

<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>

#### 3.3 Таны бизнесийн орлого, зарлагыг хэн хөтөлдөг вэ?

Өөрөө

Ойрын хамаатан (эхнэр/нөхөр, ах/эгч/дүү, эцэг эх)

Бусад хамаатан (хадам аав, ээж, хүргэн, бэр)

Ажилтнууд

Гэрээт нягтлан бодогч

Бусад \_\_\_\_\_

<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>

#### 3.4 Бизнесээ төлөвлөхөд тань хэн дэмжлэг үзүүлдэг вэ?

Өөрөө төлөвлөдөг.

Ойрын хамаатан (эхнэр/нөхөр, ах/эгч/дүү, эцэг эх)

Бусад хамаатан (хадам аав, ээж, хүргэн, бэр)

Ажилтнууд

Бизнесийн хамтрагч

<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>
<input type="checkbox"/>

Бусад \_\_\_\_\_

#### 4. Санхүүгийн үйлчилгээний мэдээлэл

##### 4.1 Санхүүгийн ямар үйлчилгээг ашигладаг / ашиглаж байсан бэ? (Олон хариулт боломжтой)

Харилцах данс	<input type="checkbox"/>
Хадгаламж	<input type="checkbox"/>
Мөнгөн гуйвуулга	<input type="checkbox"/>
Хэрэглээний зээл	<input type="checkbox"/>
Бизнесийн зээл	<input type="checkbox"/>
Банкны баталгаа	<input type="checkbox"/>
Бусад: _____	<input type="checkbox"/>

##### 4.2 Санхүүгийн үйлчилгээг ямар хэлбэрээр авдаг вэ?

Банкны салбар	<input type="checkbox"/>
Мобайл банк	<input type="checkbox"/>
Интернэт банк	<input type="checkbox"/>
Карт	<input type="checkbox"/>
Бусад: _____	<input type="checkbox"/>

##### 4.3 Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг ямар байгууллагуудтай та харилцаж байсан бэ? (олон сонголт боломжтой)

Арилжааны банк	<input type="checkbox"/>
Банк бус санхүүгийн байгууллага	<input type="checkbox"/>
ОУ-ын төсөл, хөтөлбөр	<input type="checkbox"/>
ЗГ-ын төсөл, хөтөлбөр	<input type="checkbox"/>
Хадгаламж зээлийн хоршоо	<input type="checkbox"/>
Бусад _____	<input type="checkbox"/>

##### 4.4 Таны бизнест мөнгө/санхүүжилт хэрэгтэй бол та юу хийдэг вэ?

Хуримтлалаа ашигладаг	<input type="checkbox"/>
Гэр бүл, найз нөхдөөсөө зээлдэг	<input type="checkbox"/>
Арилжааны банкнаас зээлдэг	<input type="checkbox"/>
Банк бус санхүүгийн байгууллагаас зээлдэг	<input type="checkbox"/>
Ийм нөхцөлд ашиглах бэлэн мөнгө байнга байлгадаг	<input type="checkbox"/>
Бусад, төрийн санхүүжилт г.м _____	<input type="checkbox"/>



#### 4.5 Та бизнес хийхдээ ямар зориулалтаар мөнгө зээлсэн эсвэл зээлэх бэ?

- |   |                          |
|---|--------------------------|
| Бэлтгэн нийлүүлэгчийн төлбөрийг төлөх                                   | <input type="checkbox"/> |
| Цалин болон түүнтэй адилтгах төлбөрийг төлөх                            | <input type="checkbox"/> |
| Бизнесээ өргөжүүлэхийн тулд нэмэлт түүхий эд,<br>материал худалдан авах | <input type="checkbox"/> |
| Шинээр тоног төхөөрөмж худалдан авах                                    | <input type="checkbox"/> |
| Үл хөдлөх хөрөнгө худалдан авах   | <input type="checkbox"/> |
| Нэмж мал худалдан авахад  | <input type="checkbox"/> |
| Бусад: _____  | <input type="checkbox"/> |

#### 4.3 Та юунд үндэслэн зээлийн нөхцөлийг зөвшөөрдөг вэ?

- |   |                          |
|---|--------------------------|
| Өөр газраас зээл авах боломжгүй тул тавьж буй нөхцөлийг хүлээн зөвшөөрдөг.  | <input type="checkbox"/> |
| Хамгийн бага хүүтэй зээлийг сонгодог.   | <input type="checkbox"/> |
| Түргэн шуурхай олгодог зээлийг сонгодог.  | <input type="checkbox"/> |
| Тухай зээлийн хэмжээ, хугацаа болон эргэн төлөлтийн хуваарь нь миний бизнестийн хэрэгцээтэй тохирч байгаа зээлийг сонгодог. | <input type="checkbox"/> |
| Бусад _____   | <input type="checkbox"/> |

#### 4.4 Банкнаас зээл авахад ямар үндсэн материалууд шаарддаг талаар мэдэх үү?

- |      |                          |
|------|--------------------------|
| Тийм | <input type="checkbox"/> |
| Үгүй | <input type="checkbox"/> |

#### 4.5 Зээл авахад хүүнээс гадна ямар зардал гардгийг тооцоолдог уу? (сонгосон хариултын харгалзах нүдийг бөглөх)

- |      |                          |
|------|--------------------------|
| Тийм | <input type="checkbox"/> |
| Үгүй | <input type="checkbox"/> |

### 5. Санхүүгийн мэдлэгийн хэрэгцээг тодорхойлох асуулт

#### 5.1 Та санхүүгийн мэдлэг олгох ямар нэг сургалтад хамрагдаж байсан уу? (сонгосон хариултын харгалзах нүдийг бөглөх):

- |      |                          |                                     |
|------|--------------------------|-------------------------------------|
| Тийм | <input type="checkbox"/> | Хэрэв тийм бол, ямар ямар:<br>_____ |
|------|--------------------------|-------------------------------------|

Үгүй |  | \_\_\_\_\_

**5.2 Та санхүү, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой ямар сэдвээр мэдлэг олж авахыг хүсэж байна вэ? (олон хариулт боломжтой)**

- |  |                          |
|--|--------------------------|
| Өөрийнхөө бизнесийн төсөв зохиох                 | <input type="checkbox"/> |
| Бизнес төлөвлөгөө боловсруулах                   | <input type="checkbox"/> |
| Орлого, зарлагаа бүртгэх                         | <input type="checkbox"/> |
| Зээлийн бодит зардлыг тооцоолох                  | <input type="checkbox"/> |
| Зээлийн шийдвэр гаргах                           | <input type="checkbox"/> |
| Бизнес тээ зориулж үл хөдлөх хөрөнгийн зээл авах | <input type="checkbox"/> |
| Эрсдэлийг тодорхойлох                            | <input type="checkbox"/> |
| Эрсдэлээс урьдчилан сэргийлэх                    | <input type="checkbox"/> |
| Цахим бизнес, худалдаа эрхлэх / дижиталчлал      | <input type="checkbox"/> |
| Арилжааны банктай хэрхэн харилцах                | <input type="checkbox"/> |
| Бусад _____                                      | <input type="checkbox"/> |

**6. Заавал хариулах шаардлагатай асуултууд**

**6.1 Дээрх сэдвийн дагуу сургалт явуулбал ямар хугацаа зарцуулах боломжтой вэ?**

- |   |                          |
|---|--------------------------|
| 7 хоногт 1 цаг хүртэл                   | <input type="checkbox"/> |
| 7 хоногт 1-2 цаг                        | <input type="checkbox"/> |
| 7 хоногт 2- 5 цаг                       | <input type="checkbox"/> |
| Хэдэн өдөр дараалаад хагас өдрөөр       | <input type="checkbox"/> |
| Урт хугацааны, хэдэн өдрөөр үргэлжилсэн | <input type="checkbox"/> |

**6.2 Та дээрх сургалтыг ямар хэлбэрээр авахыг хүсэж байна вэ? (хамгийн тохиромжтой 3 хэлбэрийг сонгох):**

- |   |                          |
|---|--------------------------|
| Нүүр тулсан буй интерактив багийн сургалт         | <input type="checkbox"/> |
| Гарын авлага                                      | <input type="checkbox"/> |
| Цахим сургалт                                     | <input type="checkbox"/> |
| Сошиал медиа- Олон нийтийн цахим сүлжээ           | <input type="checkbox"/> |
| Гар утасны аппликейшн                             | <input type="checkbox"/> |
| Бизнесийн үйл явцыг загварчилсан симуляци тоглоом | <input type="checkbox"/> |

Радио / телевиз

Өдөр тутмын сонин хэвлэл

Бусад: \_\_\_\_\_

**6.3 Дээрх сэдвээр төлбөртэй сургалт явуулбал та хамрагдах уу?**

Тийм

Үгүй

**7. Санхүүгийн боловсролын талаарх сэдэв болон сургалтын талаар энэхүү асуулгад дурдаагүй таны зүгээс нэмэх хүсэлт болон сэтгэгдэл байна уу?**


**Цаг гарган асуулгад оролцсон танд баярлалаа.**

# Хавсралт 2

 **Finanzgruppe**  
Sparkassenstiftung für  
internationale Kooperation

**Sparkassenstiftung für  
internationale Kooperation e.V.**  
Simrockstraße 4  
53113 Bonn, Germany  
Phone: +49 228 9703-0  
[www.sparkassenstiftung.de](http://www.sparkassenstiftung.de)

## Монгол Улсын БЖДБ эрхлэгчдийн СБ-ын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаанд оролцогчдыг сонгосон шалгуурууд

Монгол улсын Бичил, жижиг, дунд бизнес  
эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг  
дээшлүүлэх хөтөлбөр

 **ipc**  
partner for development

**IPC - Internationale Projekt  
Consult GmbH**  
Voltastraße 31-33  
60486 Frankfurt, Germany  
Phone: +49 69 9050188-0  
[www.ipcgmbh.com](http://www.ipcgmbh.com)

**Баримт бичгийн мэдээлэл**



## Нэр

БЖДБ эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлал

## Монгол Улс дахь хамтрагч

Монголбанк

## Баримт бичгийн хугацаа

15.10.2020

## Үндсэн зөвлөх баг

Матиас Фохс, Төслийн менежер

Д. Оюунцэцэг, Дотоодын ахлах зөвлөх

Марга Шек, Олон улсын ахлах зөвлөх



**European Bank**  
for Reconstruction and Development



This programme is funded  
by the European Union

“Санхүүгийн мэдлэгийн хэрэгцээ шаардлага”-ыг тодорхойлох судалгаанд оролцох БЖДБ-үүдийг сонгохдоо дараах 3 үндсэн зарчмыг баримталсан:

- **Ил тод байдал:** БЖДБ-үүдийг бизнесийн төрөл (бичил, жижиг, дунд) болон бүс нутаг, эдийн засгийн сектороор сонгох тодорхой, ил тод шалгуурууд;
- Эцсийн шатны шалгаруулалтанд оролцсон байгууллагуудад **хэрэгжүүлэхэд хялбар байх;**
- Өөр өөр цаг хугацаанд өгөгдөл цуглуулах тохиолдолд **харьцуулсан үр дүнгээр хангах боломжтой.**

“Санхүүгийн мэдлэгийн эрэлт хэрэгцээ”-г тодорхойлох судалгаанд хамрагдах Монгол Улсын 100 БЖДБ эрхлэгчийг сонгох шалгуурууд:

1. Суурь шаардлагууд:

- 50% нь хөдөө орон нутгаас байх;
- БЖДБ-ийн бүх хэлбэр, төрлийг багтаасан байх;
- Нийт 100 БЖДБ-ыг хамрах.

2. Үндэсний статистикийн хорооны өгөгдлийн санд бүртгэлтэй бизнесүүдийн тоо 75,796 байсан. Үүнийг бүс нутгаар хуваавал:

	Total enterprises		Enterprises surveyed		
	Total number	Percentage	Sample size	Weight	Percentage of total
Arkhangai	1064	1.4%	38	1.8%	3.3%
Bayan-Ulgii	1489	2.0%	44	2.3%	3.0%
Bayankhongor	1025	1.4%	33	1.7%	3.2%
Bulgan	1132	1.5%	33	1.7%	2.9%
Gobi-Altai	811	1.1%	25	1.3%	3.1%
Gobisumber	318	0.4%	22	1.1%	6.9%
Darkhan-Uul	2062	2.7%	71	3.6%	3.4%
Dornogobi	1050	1.4%	42	2.2%	4.0%
Dornod	1416	1.9%	51	2.6%	3.6%
Dundgobi	622	0.8%	31	1.6%	5.0%
Zavkhan	1259	1.7%	37	1.9%	2.9%
Orkhon	2226	2.9%	60	3.1%	2.7%
Uvurkhanga	1283	1.7%	46	2.4%	3.6%
Umnugobi	1385	1.8%	3	0.2%	0.2%
Sukhbaatar	762	1.0%	24	1.2%	3.1%
Selenge	2143	2.8%	62	3.2%	2.9%
Tuv	1254	1.7%	51	2.6%	4.1%
Uvs	1481	2.0%	8	0.4%	0.5%
Ulaanbaatar	48519	64.0%	1116	57.2%	2.3%
Khovd	1854	2.4%	65	3.3%	3.5%
Khuvsgul	1621	2.1%	55	2.8%	3.4%
Khentii	1030	1.4%	36	1.8%	3.5%
<b>Total</b>	<b>75796</b>	<b>100%</b>	<b>1950</b>	<b>100%</b>	<b>2.6%</b>

3. Судалгаанаас харахад БЖДБ-үүдийн 64 хувь нь гэрчилгээтэй, 36 хувь нь гэрчилгээгүй байсан.

Бэлэн байсан мэдээлэлд үндэслэн бидний зүгээс судалгаанд оролцох 100 БЖДБ-ийг сонгохдоо дараах шалгуурыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна:

1. Таван бүс нутаг; хот/хөдөөгийн бүсийн үндсэн үзүүлэлтүүд

*Тэмдэглэл: Сургалтын үйл явцыг илүү үр дүнтэй болгохын тулд эхний үе шатанд бүс нутаг бүрээс 1 аймгийг оролцуулах нь зүйтэй.*

Бүс нутаг бүр өөр өөрийн онцлогтой:

- Зүүн бүс: аж үйлдвэр, аялал жуулчлал (Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг)
- Говийн бүс: Уул уурхай, өндөр технологи (нано болон биотехнологи), үйлчилгээ, аялал жуулчлал (Говь-Сүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймагУ)
- Алтайн бүс: аялал жуулчлал (эрүүл мэнд, олон улсын аялал жуулчлалын цогцолбор), болон ногоон хөгжил (Говь Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймаг)
- Баруун бүс: Алтайн соёл, байгалийн баялаг, ногоон хөгжил (Ховд, Баян-Өлгий, Увс аймаг)
- Хангайн бүс: эрчимжүүлсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал (Сэлэнгэ, Дархан Уул, Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Завхан аймаг)
- Төвийн бүс: Шинжлэх ухаан, технологийн олон улсын төв, тээврийн зангилаа төв, өндөр технологийн аж үйлдвэр (Төв аймаг, Улаанбаатар хот)

2. Бүс нутаг бүрээс 15 БЖДБ (Нийт 75), Улаанбаатар хотоос 25 БЖДБ эрхлэгч судалгаанд оролцсон.

*Тэмдэглэл: Судалгааны үр дүнд гэрчилгээгүй БЖДБ-үүдийг оролцуулах нь үр дүнтэй бөгөөд нийт БЖДБ-үүдийг 1/3 нь гэрчилгээгүй байсан.*

3. Бүс нутаг бүрээс сонгогдсон 15 БЖДБ-ээс нийлээд 8 БЖДБ нь эмэгтэй эзэнтэй байсан

4. MSMEs Улаанбаатар хотоос сонгогдсон 25 БЖДБ-ээс 13 нь эмэгтэй эзэнтэй байсан.

5. Оролцогчдыг бичил, жижиг, дунд бизнесээр хуваахдаа ажилчдын тоо болон бүс нутаг бүрээр/Улаанбаатар хотоор жилийн орлогыг дүгнэхдээ:

- 1-9 ажилтантай, жилийн орлого нь 300 саяаас бага 10/21;
- 10-49 ажилтантай, жилийн орлого нь 300 саяаас 1 тэрбум 4/3;
- 50-аас дээш ажилтантай, жилийн орлого нь 1 тэрбумаас 2.5 тэрбум 1/1.

6. By main business activity (by sector) in each region / Ulaanbaatar

- Жижиглэн ба худалдаа = 3 / 3
- Үйлчилгээ = 3 / 5
- Аж үйлдвэр = 3 / 11
- Ферм/ХАА/Мал аж ахуй = 5 / 4
- Бусад = 1 / 2

Сонгон шалгаруулах шалгууруудыг тогтоох эцсийн шийдвэр нь Монголбанк болон МҮХАҮТ-аас цуглуулах өгөгдлүүдээс хамаарна. COVID-19-ийн үед БЖДБ-үүдтэй холбогдох утасны дугаар болон эзэмшигчийн нэр, хаягийн мэдээлэл чухал ач холбогдолтой.



# Хавсралт 3

26.11.2020

Microsoft Forms

Монголын бичил, жижиг, дунд үйлд...



Монголын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ шаардла

101

Answers

12:31

Average time to complete the survey

Active

Status

1. Огноо:

101

Answers

Latest answers

"25.11.2020"

"25.11.2020"

"25.11.2020"

2. Асуулга авсан хүний нэр:

101

Answers

Latest answers

"Oyunchimeg Siisel"

"Bayansan Purev"

"Bayansan Purev"

3. Асуулгад оролцогчийн код:

101

Answers

Latest answers

"06025"

"06017"

"06016"

4. Хүйс:

Эм

50

Эр

51



5. Нас

25 хүртэлх

0

25-34

10

35-44

30

45-54


36

55-64

21


65-аас дээш

4



6. Боловсрол:

Бүрэн бус дунд	1
Бүрэн дунд	19
Мэргэжлийн боловсрол	7
Бакалавр	52
Магистр	22
Доктор	0
Мэргэжлийн боловсрол (төг...	0
Их, дээд сургууль (төгсөөгүй)	0
Other	0



7. Бизнесийн чиглэл:

Худалдаа	17
Үйлчилгээ	15
Үйлдвэрлэл/гар урлал	33
ХАА/газар тариалан/мал аж ...	28
Other	8



8. Ажилтны тоо (НДШ төлдөг):

1-9	62
10-49	33
50-200	6



9. Танай жилийн борлуулалтын хэмжээ (төгрөгөөр):

300 саяас бага	62
300 сая – 1 тэрбум	29
1 тэрбум – 2.5 тэрбум	10



10. Та өөрийн бизнесээ тогтмол төлөвлөдөг үү?

Тийм	69
Үгүй	32




11. Хэрвээ тийм бол давтамж бичнэ үү \_\_

69  
answers

Latest answers  
"Жил"


12. Та бизнесээ явуулахад хамгийн чухал хэрэг болдог зүйлсийг дахин шинээр авах шаардлагатай болсон гэж төсөөлье. Та юу хийх вэ? Доорх үйлдлүүдийн алийг нь хийх байсан бэ?

Бизнес хүндрэл үүсэхэд хэрэг...	16
Даатгалаа ашиглана.	2
Эзэл авна.	55
Хувийн хуримтлалаа ашигла...	16
Гэр бүл эсвэл найз нөхдөөсө...	7
Бизнесээ түр эсвэл бүр зогсо...	1
Мэдэхгүй байна, ийм нөхцөл...	4
Other	0




13. Таны бизнесийн орлого, зарлагыг хэн хөтөлдөг вэ?

Өөрөө	40
Ойрын хамаатан (эхнэр/нөхө...	19
Бусад хамаатан (хадам аав, э...	0
Ажилтнууд	23
Гараат нягтлан бодогч	11
Other	8




14. Бизнесээ төлөвлөхөд тань хэн дэмжлэг үзүүлдэг вэ?


Өөрөө төлөвлөдөг.	44
Ойрын хамаатан (эхнэр/нөхө...	28
Бусад хамаатан (хадам аав, э...	0
Ажилтнууд	12
Бизнесийн хамтрагч	12
Other	5




15. Санхүүгийн ямар үйлчилгээг ашигладаг/ашиглаж байсан бэ? (Олон хариулт боломжтой)




16. Санхүүгийн үйлчилгээг ямар хэлбэрээр авдаг вэ?



17. Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг ямар байгууллагуудтай та харилцаж байсан бэ? (олон сонголт боломжтой)



18. Таны бизнест мөнгө/санхүүжилт хэрэгтэй бол та юу хийдэг вэ?




19. Та бизнес хийхдээ ямар зориулалтаар мөнгө зээлсэн эсвэл зээлэх бэ?



20. Та юунд үндэслэн зээлийн нөхцөлийг зөвшөөрдөг вэ?



21. Банкнаас зээл авахад ямар үндсэн материалууд шаарддаг талаар мэдэх үү ?



22. Зээл авахад хүүнээс гадна ямар зардал гардгийг тооцоолдог уу? (сонгосон хариултын харгалзах нүдийг бөглөх)




23. Та санхүүгийн мэдлэг олгох ямар нэг сургалтад хамрагдаж байсан уу? (сонгосон хариултын харгалзах нүдийг бөглөх):



24. Хэрэв тийм бол, ямар ямар:

25. Та санхүү, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой ямар сэдвээр мэдлэг олж авахыг хүсэж байна вэ? (олон хариулт боломжтой)

Өөрийнхөө бизнесийн төсөв...	57
Бизнес төлөвлөгөө боловсру...	72
Орлого, зарлагаа бүртгэх	52
Зээлийн бодит зардлыг тооц...	32
Зээлийн шийдвэр гаргах	25
Бизнесээ зориулж үл хөдлө...	26
Эрсдэлийг тодорхойлох	69
Эрсдэлээс урьдчилан сэргий...	71
Цахим бизнес, худалдаа эрхл...	60
Арилжааны банктэй хэрхэн х...	43
Other	20




26. Дээрх сэдвийн дагуу сургалт явуулбал ямар хугацаа зарцуулах боломжтой вэ?

7 хоногт 1 цаг хүртэл	1
7 хоногт 1-2 цаг	10
7 хоногт 2- 5 цаг	21
Хэдн өдөр дараалаад хагас ...	41
Урт хугацааны, хэдн өдрөөр...	28



27. Та дээрх сургалтыг ямар хэлбэрээр авахыг хүсэж байна вэ? (хамгийн тохиромжтой 3 хэлбэрийг сонгох):

Нүүр тулсан буй интерактив ...	92
Гарын авлага	53
Цахим сургалт	48
Сошиал медиа- Олон нийти...	17
Гар утасны аппликейшн	31
Бизнесийн үйл явцыг загвар...	42
Радио / телевиз	1
Өдөр тутмын сонин хэвлэл	0
Other	6



28. Дээрх сэдвээр төлбөртэй сургалт явуулбал та хамрагдах уу?

Тийм	85
Үгүй	16



29. Санхүүгийн боловсролын талаарх сэдэв болон сургалтын талаар энэхүү асуулгад дурдаагүй таны зүгээс нэмэх хүсэлт болон сэтгэгдэл байна уу?

# Хавсралт 4



 **Finanzgruppe**  
Sparkassenstiftung für  
internationale Kooperation

**Sparkassenstiftung für  
internationale Kooperation e.V.**  
Simrockstraße 4  
53113 Bonn, Germany  
Phone: +49 228 9703-0  
[www.sparkassenstiftung.de](http://www.sparkassenstiftung.de)

 **ipc**  
partner for development

**IPC - Internationale Projekt  
Consult GmbH**  
Voltastraße 31-33  
60486 Frankfurt, Germany  
Phone: +49 69 9050188-0  
[www.ipcgmbh.com](http://www.ipcgmbh.com)

Монгол улсын Бичил, жижиг, дунд бизнес  
эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг  
дээшлүүлэх хөтөлбөр

## Хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлал

EBRD Гэрээний дугаар C45599/6547/50930  
2021 оны 02 дугаар сар



## Баримт бичгийн мэдээлэл

### Нэр

БЖДБ эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлгэрчилсэн аргачлал

### Монгол Улс дахь хамтрагч

Монголбанк

### Үндсэн зөвлөх баг

Матиас Фохс, Төслийн менежер

Д. Оюунцэцэг, Дотоодын ахлах зөвлөх

Марга Шек, Олон улсын ахлах зөвлөх

### Огноо

2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр



**European Bank**  
for Reconstruction and Development



This programme is funded  
by the European Union

## Өмнөх үг

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Монголбанк, Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран боловсруулж, 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл баталсан байдаг. Хөтөлбөрийг сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох, залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох гэсэн дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2016 оноос хойш хэрэгжүүлж байна.

Тэгвэл хувиараа бизнес эрхлэгчид, бичил, жижиг, дунд бизнесүүдэд чиглэсэн санхүүгийн боловсролын энэхүү шинэ хөтөлбөрийн зорилго нь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын давхардлыг арилгаж харилцан уялдааг хангах, үр дүнг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтвортой байдал, хөгжилд хувь нэмэр оруулах юм. Хөтөлбөрийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр, Монголбанк удирдан хэрэгжүүлж, Санхүүгийн зохицуулах хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, Зээлийн батлан даалтын сан болон Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим гэсэн оролцогч талуудыг багтаасан байнгын хороо бүрдүүлээд байна.

## Агуулга

### 1 БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС (БЖДБ) ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ FEHLER! TEXTMARKE NICHT DEFINIERT.

- 1.1 Хөтөлбөрийн танилцуулга ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.2 БЖДБ-үүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага .... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.3 БЖДБ-үүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, дэлхий нийтийн чиг хандлага  
**Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.4 БЖДБ-ийн санхүүгийн мэдлэгийн тодорхойлолт ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.5 Хөтөлбөрийн үр өгөөж..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.6 Хөтөлбөрийн алсын хараа, зорилт..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 1.8 Тэргүүлэх чиглэл (зорилтот бүлэг) ..... 4
- 1.9 БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрөөр хамрах сэдвүүд **Fehler! Textmarke nicht definiert.**

### 2 БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТАЙЛАН, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН СУВАГ, УДИРДЛАГЫН БҮТЭЦ ..... FEHLER! TEXTMARKE NICHT DEFINIERT.

- 2.1 Бүтэц, зохион байгуулалт, үнэлгээ ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.2 Хэрэгжүүлэх хугацаа ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.3 Тайлан ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.4 Хэрэгжүүлэх үндсэн суваг ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.5 Хүлээж буй үр дүн ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.6 Хөтөлбөрийн санхүүжилт ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
  - 2.6.1 Санхүүжилтийн эх сурвалж ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
  - 2.6.2 Зарчим ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 2.7 Хяналт, шинжилгээ, үнэлгээ ..... **Fehler! Textmarke nicht definiert.**

### 3 ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА .. FEHLER! TEXTMARKE NICHT DEFINIERT.

- 3.1 Үндсэн үйл ажиллагаа ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 3.2 Тэргүүлэх чиглэл 1: Хувиараа бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ..... 12
  - 3.2.1 Үндэслэл ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
  - 3.2.2 Үйл ажиллагаа ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 3.3 Тэргүүлэх чиглэл 2: Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ..... 13
  - 3.3.1 Үндэслэл ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
  - 3.3.2 Үйл ажиллагаа ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
- 3.4 Тэргүүлэх чиглэл 3: Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ..... 13
  - 3.4.1 Үндэслэл ..... **Fehler! Textmarke nicht definiert.**
  - 3.4.2 Үйл ажиллагаа ..... **Fehler! Textmarke nicht definiert.**

3.5	Тэргүүлэх чиглэл 4: Дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх .....	14
3.5.1	Үндэслэл .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
3.5.2	Үйл ажиллагаа .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
3.6	Тэргүүлэх чиглэл 5: Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-ийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх....	15
3.6.1	Үндэслэл .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
3.6.2	Үйл ажиллагаа .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
<b>4</b>	<b>ХЭРЭГЖҮҮЛЭЛТ .....</b>	<b>FEHLER! TEXTMARKE NICHT DEFINIERT.</b>
4.1	Санал болгосон сэдвүүд .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
4.1.1	1 дүгээр үе шат: .....	17
4.1.2	2 дугаар үе шат: .....	17
4.1.3	Санхүү, даатгалын үйлчилгээ эрхэлдэг БЖДБ-үүд: .....	18
4.2	OECD/INFE-ийн шалгуураар тодорхойлсон санхүүгийн мэдлэгийн үндсэн чадварууд	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>
4.3	Хэрэгжүүлэх үйл явц / ашигласан материал .....	<b>Fehler! Textmarke nicht definiert.</b>

## Хүснэгт

Хүснэгт 1	Оролцогч талуудаас ирүүлсэн мэдээлэл .....	20
-----------	--	----

## Товчлол

МБ	Монголбанк
ЗБ	Зөвлөх баг
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЕХ	Европын Холбоо
СБ	Санхүүгийн боловсрол
СЗХ	Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ILO	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
INFE	Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ
IPC	Internationale Projekt Consult GmbH
KOICA	Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
БЖБ	Бичил, жижиг бизнес
БЖДБ	Бичил, жижиг, дунд бизнес
ТББ	Төрийн бус байгууллага
OECD	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЖДБ	Жижиг, дунд бизнес

## **1 Бичил, жижиг, дунд бизнес (БЖДБ) эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл**

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр нь дараах ач холбогдолтой. Үүнд: олон өөр оролцогч талын үйл ажиллагааны уялдааг хангах, ажлын шаардлагагүй давхардлыг арилгах, нэн тэргүүнд хийх шаардлагатай арга хэмжээнүүдэд төвлөрч ажиллахад туслах. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр хувиараа бизнес эрхлэгч, бичил, жижиг, дунд бизнесийн эзэн, менежерүүдийн санхүүгийн ноу-хау болон сахилга бат сайжирч, бизнесийнхээ санхүү, хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргах чадвар нь нэмэгдсэнээр орлогоо нэмэгдүүлж, шинэ ажлын байрууд бий болгоно. Энэ нь санхүүгийн салбарын хөгжлийг хурдасгаж Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын урт хугацааны, тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулах юм.

### **1.1 Хөтөлбөрийн танилцуулга**

Тус хөтөлбөрийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны дэмжлэгтэйгээр Монголбанкнаас боловсруулж байгаа бөгөөд Монголбанкны удирдлагын доор БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн оролцогч талуудын байнгын хорооны хурлаас удирлага, зохион байгуулалтаар хангана.

Голлох оролцогч талууд: Санхүүгийн зохицуулах хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, Зээлийн батлан даалтын сан болон Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим.

Хөтөлбөрийн зорилго, зорилт болон төлөвлөгөөг олон улсын сайн туршлага, сүүлийн үеийн чиг хандлага, Монгол Улсын өвөрмөц онцлог, БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн өнөөгийн түвшинд тулгуурлан боловсруулсан.

### **1.2 БЖДБ-үүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөрийг боловсруулах эхний үе шатанд Монголбанкнаас БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн өнөөгийн түвшинг тодорхойлох зорилгоор 300 гаруй БЖДБ эрхлэгч (нийт 500 БЖДБ эрхлэгчтэй холбоо барьсанаас 352 нь хариулсан)-ээс судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийх ажлууд их байгаа гэж бизнес эрхлэгчид өөрсдөө дүгнэсэн байна. Монголбанк болон ЕСБХБ-ны өмнөөс Sparkassenstiftung болон IPC-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх баг 2020 оны 10 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл хугацаанд хийсэн судалгаанаас харахад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэд хэдэн байгууллага нилээд хэдэн төслийг хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж буй (Хавсралт 1 ба 2-ыг харна уу) боловч тэдгээр нь харилцан уялдаагүй явж иржээ.

Түүнчлэн Зөвлөх баг сургалт явуулахад хамгийн хэрэгцээтэй сэдэв, тохиромжтой суваг болон аргуудыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын хэмжээгээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч 100 гаруй (101) хүнээс судалгаа авсан. Судалгаанд оролцогчид хамгийн шаардлагатай сэдвээр бизнесийн төлөвлөлт (мөн төсөв), эрсдэлийн удирдлага (эрсдэлийг

тодорхойлох, асуудал тулгарахад хэрхэн ажиллах) болон цахим худалдааг нэрлэсэн.<sup>1</sup> Нилээд хэдэн оролцогч өмнө нь энэ чиглэлээр нэг буюу түүнээс дээш сургалтанд хамрагдсан боловч дахин сургалтанд хамрагдах хүсэлтэй байсан нь сонирхол татаж байна. Үүний шалтгааныг лавлахад өмнөх сургалтууд ерөнхий, онолын, бусад сургалттай уялдаагүй, практик амьдралд тулгуурлаагүй байсан гэсэн хариултууд ирсэн. Энэ нь Монгол Улсад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр ашиг, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

### **1.3 БЖДБ-үүдэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага, дэлхий нийтийн чиг хандлага**

Санхүүгийн мэдлэгийг түгээснээр эдийн засаг, санхүүгийн тогтвортой хөгжлийн урьдчилсан нөхцөл болохоос гадна олон улс, дотоодын хэмжээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг. Санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал нь хувь хүмүүсийн түвшинд шийдвэр гаргалттай шууд холбогддог бол цаашлаад эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжилд хөтөлж байдаг. Дэлхий даяар санхүүгийн мэдлэгийн түвшин дээшлэх нь улс орнуудын хоорондох нийгэм-эдийн засгийг ялгаа, тэгш бус байдлын багасгахад хувь нэмэр оруулдаг гэж үздэг.

Тиймээс Монголын эдийн засгийн тоглогчид, ялангуяа хувиараа бизнес эрхлэгч, БЖДБ-ийн эзэн, менежерүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь хувийн бизнес болон санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбар/байгалийн баялгын экспортоос ихээхэн хамааралтай хэвээр байна. Эдийн засгийн үндсэн тулгуур болсон БЖДБ-ийн салбар нь Дотоодын нийт бүтээгдэхүүний ¼-ийг бүтээж, нийт ажлын байрны 50 гаруй хувийг бүрдүүлж байна.<sup>2</sup> Эдийн засгийг солонгоруулж, байгалийн баялгийн экспортоос хамаарах хамаарлыг багасгах, санхүүгийн салбарыг бэхжүүлэх чухал шаардлагатай байна.

1.2-т дурдсаны дагуу БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлага тулгараад байгаа. Хөтөлбөрийн хүрээнд мөн бичил зээл, даатгал гэх мэт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг нэмж оруулсан бөгөөд хөтөлбөрийн ерөнхий зорилго нь Монгол Улсын санхүүгийн салбарыг бэхжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, эдийн засгийн чадамжуулах байна.

Санхүүгийн мэдлэгтэй бизнес эрхлэгчид илүү сайн бизнесийн болон санхүүгийн шийдвэр гаргаж, өөрийн бизнесийн тогтвортой байдал, хөгжлийг хурдасгадаг. Бизнес эрхлэгчдийн санхүүгийн шийдвэр гаргалт сайжирч, өөрийн хэрэгцээнд нийцсэн санхүүгийн байгууллага, үйлчилгээг хэрхэн сонгох, санхүүгийн ямар хэрэгслийг хэрхэн ашиглахаа илүү мэддэг болсоноор санхүүгийн салбарт нийтэд нь эерэг нөлөө авчирдаг. Илүү мэдлэгтэй, чадвартай банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, даатгалын компаниуд нь энэ салбарын тогтвортой байдал, өсөлтийг дэмжиж, үр дүнд нь Монгол улсын эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулна.

<sup>1</sup> COVID-19 болон түүний Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө нь эрсдэлийг ойлгох, удирдах мэдлэгээ дээшлүүлэх, нүүр тулж харилцахгүйгээр бизнесээ үргэлжлүүлэхийн тулд цахим худалдааг нэвтрүүлэх сонирхолыг нэмэгдүүлсэн.

<sup>2</sup> OECD. Eurasia Peer Review Note Enhancing Access to Finance for Micro, Small and Medium-sized Enterprises in Mongolia. 24 November, 2016. p. 11.



## 1.4 БЖДБ-ийн санхүүгийн мэдлэгийн тодорхойлолт

2016-2021 оны хооронд хэрэгжүүлсэн “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүгийн мэдлэг гэдэг нь *‘иргэн тухайн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд тохируулан өөрийн санхүүг зөв удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй байхыг хэлнэ’* гэж тодорхойлсон.<sup>3</sup> Мэдлэг нь өөрийн хувийн санхүүгээ мэдэх, ойлгох, чадвар нь өөрийн хувийн санхүүгээ удирдах мэдлэгээ ашиглах чадвар, итгэл үнэмшил нь санхүүгийн зөв шийдвэр гаргах чадвартаа итгэхийг хэлнэ. Энэхүү тодорхойлолтонд санхүүгийн мэдлэгийг бизнес эрхлэгчийн талаас бус, хувь хүн, өрхийн санхүүгийн талаас тодорхойлоход илүү төвлөрсөн байдаг.

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд энэхүү тодорхойлолтыг дараах байдлаар шинэчлэх шаардлагатай:

***БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэг гэдэг нь бизнес эхлүүлэх, явуулах, тогтвортой байдал, өсөлтийг хангах үр дүнтэй санхүүгийн шийдвэрүүд гаргадаг болохын тулд бизнес эрхлэгч, бичил, жижиг эсвэл дунд бизнесийн эзэн, менежерүүдийн эзэмшсэн байвал зохих ойлголт, мэдлэг, чадвар, хандлага болон зан төлөвийн хослолыг хэлнэ.***

Хувийн санхүүгээ удирдах хувь хүний чадвар болон бизнес эрхлэгчийн санхүүгийн удирдлагын ур чадвар нь нэг нэгнээсээ хамааралтай бөгөөд хувийн санхүүгээ удирдах чадвар сайжирсанаар бизнесийн санхүүгээ удирдах чадвар сайжирч байдаг. Тиймээс хувь хүмүүс болон өөрийн бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж буй хувь хүмүүсийн талаар авах арга хэмжээг БЖДБ-ийн талаар авах арга хэмжээнүүдээс тусад нь авч үзэж болохгүй юм.

## 1.5 Хөтөлбөрийн үр өгөөж

БЖДБ-үүд болон санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдийн эзэн, менежерүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь эдийн засгийг сэргээх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, цаашлаад санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Харилцан уялдаа, зохицуулалт сайтай хөтөлбөрт оролцогч талууд хэд хэдэн хэлбэрээр хувь нэмрээ оруулдаг:

- Банкны баталгааны схем, зөвлөх үйлчилгээ гэх мэт зээл, тусламж, дэмжлэгийн хөтөлбөрүүдийн талаар мэдлэг, мэдээллийг түгээхэд хөтөлбөрийг ашиглаж болно;
- Одоо хэрэгжиж буй төслүүдийг эрчимжүүлэхэд хөтөлбөрийг ашиглах боломжтой. Жишээ нь, СЗХ-той хамтран санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдийн ноу-хауг сайжруулах, МҮХАҮТ гэх мэт оролцогч талын одоогийн хамтын ажиллагааны сүлжээг ашиглан сургалтын оролцогчдыг олох гэх мэт;
- Төрийн байгууллагууд, оролцогч талуудын дэд бүтцийг ашиглан хөдөө, орон нутагт хүрч ажиллах, төрийн байгууллагууд болон бусад сонирхогч талуудтай хамтран сургалт зохион байгуулах.

## 1.6 Хөтөлбөрийн алсын хараа, зорилт

Хөтөлбөрийн **алсын хараа** нь бизнесийн санхүүгийн үйл ажиллагаагаа үр дүнтэй удирдах, бизнесийн өсөлтийг бий болгох, цаашлаад бизнесийн тогтвортой байдлаа хангахад хэрэгцээтэй мэдлэгийг байнга хүртэх боломжоор Монголын хувиараа бизнес эрхлэгчид, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хангах юм.

<sup>3</sup> “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр” 2016 – 2021. Хуудас 7.

Хөтөлбөрийн үндсэн **зорилтууд** нь:

- Бичил, жижиг, дунд бизнесийн эзэн, менежерүүдийн бизнесийн санхүүгээ удирдах чадварыг дээшлүүлэх.
- Бичил, жижиг, дунд бизнесийн эзэн, менежерүүдийн санхүүгийн гэмт хэргээс сэргийлэх чадварыг дээшлүүлэх.
- Бичил, жижиг, дунд бизнесийн эзэн, менежерүүдийн санхүүгийн зөв шийдвэр гаргах чадвар (санхүүгийн байгууллага, үйлчилгээ, үйлчилгээний нөхцлийг сонгох)-ыг дээшлүүлэх.

## 1.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дараах зарчмуудыг баримталбал зохино. Үүнд:

- Төслийн нөлөөг нэмэгдүүлэх үүднээс оролцогч талуудын хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээлэл солилцоог хангах.
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг үр ашигтай, зардал хэмнэлттэй хэлбэрээр хэрэгжүүлэх.
- Санхүүгийн суурь мэдлэг олгох үндэсний хөтөлбөрийн салшгүй нэг хэсэг байх.
- Эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжлийн чиглэлээр холбогдох бодлого, дүрмүүдэд нийцсэн байх.
- Жендерийн тэгш байдлыг хангах, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх.
- Олон нийтийн болон төрийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах.
- Олон улсын туршлагыг нэвтрүүлэх.
- Хэрэгжүүлэх олон арга хэлбэрээс хамгийн үр дүнтэй, үр ашигтайг сонгох, зардал-үр ашгийн харьцааг чухалчлах.
- Саад болж болзошгүй үндсэн чиглэлүүдийг эрэмбэлэх.
- “Сургалт шаардлагатай” буюу бизнесээ эхлүүлэхээр төлөвлөж байгаа, бизнесийнхээ эхэн үед туслалцаа хүссэн, хил дамнан бизнес эрхлэх гэж байгаа эсвэл шинэ хүндрэлтэй тулгарсан (албан ёсны нийлүүлэгч болохоор ажиллаж байгаа гэх мэт) үеийг ашиглах.
- Өмнөх үйл явц, үйл ажиллагаанд тулгуурлах, илүү сайжруулах.
- Эхлэхээс өмнө туршилт явуулах.

## 1.8 Тэргүүлэх чиглэл (зорилтот бүлэг)

Олон улсын туршлагад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн маш олон төрлийн үйл ажиллагаа байдаг. Гэвч тэдгээрт зарцуулах хөрөнгө хязгаарлагдмал тул дотор нь ач холбогдлоор нь эрэмбэлэх шаардлага гардаг.

Тус хөтөлбөрийн хувьд дараах тэргүүлэх чиглэл (зорилтот бүлэг)-үүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Хувиараа бизнес эрхлэгч (эмэгтэй бизнес эрхлэгчдийг оролцуулан)-дийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа;
2. Бичил болон бизнесийн бүтэц, зохион байгуулалт, загвар, хэмжээ зэргээрээ бичил бизнестэй төстэй жижиг бизнесийн эзэн, менежерүүд (эмэгтэй эзэн, менежерүүдийг оролцуулан)-ийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа;
3. Жижиг болон дунд бизнесийн эзэн, менежерүүдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа;

4. Дунд бизнесийн эзэн, менежерүүдэд тусгайлан чиглэсэн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа;
5. Санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдэд зориулсан нэмэлт үйл ажиллагаа.

Тэргүүлэх чиглэлүүдийг тогтоохдоо олон төрлийн БЖДБ-ийн байгууллагуудын хэрэгцээ шаардлагад үндэслэсэн. Монгол Улсын БЖДБ-үүдийн ихэнх нь маш жижиг (бичил) бизнес буюу нэг бизнес эрхлэгч эсвэл түүний гэр бүл удирдан явуулдаг, маш цөөн ажилтантай эсвэл огт ажилтангүй байдаг. Тооны хувьд жижиг бизнесүүд дараагийн байрт ордог. Дунд хэмжээтэй бизнесийн хувьд Монгол Улсын БЖДБ-ийн тоонд маш бага хувийг бүрдүүлдэг боловч Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, ажил эрхлэлт, татвар бүрдүүлэлтэнд харьцангуй өндөр хувь нэмэр оруулдаг. Жижиг бизнес нь бичил эсвэл дунд бизнестэй харьцуулахад маш өргөн хүрээтэй ойлголт болсон бөгөөд зарим жижиг бизнес нь бизнесийн бүтэц, удирдлага, үйл ажиллагааны хувьд бичил бизнестэй илүү төстэй, зарим нь дунд бизнестэй илүү төстэй, харин үлдсэн нь бичил, дунд бизнесийн аль алинтай нь төсгүй байгаа нь ажиглагдсан. Тиймээс бидний хувьд тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохдоо уян хатан хандаж, албан ёсны тодорхойлолтод хамаарахгүй учраас хөтөлбөрт хамрагдахгүй үлдэхээс сэргийлэхийг хүссэн.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүд бизнестэй холбоотой санхүүгийн мэдлэгийн стандартийг хэрэгжүүлэхээс гадна зохицуулалтын орчин, зээлийн багцийн удирдлага, зээлдэгч/даатгуулагчийн үнэлгээ, хөрөнгийн үнэлгээ гэх мэт санхүүгийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт сургалт/ноу-хаугийн сургалт авах шаардлагатай байдаг.

### **1.9 БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрөөр хамрах сэдвүүд**

Хөтөлбөрөөр дараах үндсэн сэдвийг хамрана. Үүнд:

- Орлого, зарлагаа тооцоолох (нягтлан бодох бүртгэлийн үндэс);
- Төсөв ба төлөвлөгөө, бизнесийн ба төслийн төлөвлөлт;
- Татвар;
- Эрсдэлийн удирдлага (эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах)
- Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн талаар ойлголт (зээл, даатгалын олон төрлүүд, зээлийн батлан даалт, банкны баталгаа, гадаад валют, үндэсний валютаар зээл авахын ялгаа гэх мэт);
- Аль бүтээгдэхүүнийг сонгох, ашиглахаа хэрхэн шийдэх (зээлийн зардлын тооцоолол гэх мэт);
- Санхүүгийн байгууллагатай хэрхэн ярилцах;
- Бизнесийн дэмжлэг, туслалцааны хөтөлбөрүүдийн мэдээлэл (баталгаа, зөвлөх үйлчилгээ, татварын схем);
- Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага;
- Цахим худалдаа.

Монголын бизнесийн эзэн, менежерүүд COVID-19 цар тахлаас үүдсэн хямралын шууд нөлөөг бизнес дээрээ мэдэрч, тодорхой бус цаг хугацаатай нүүр тулж буй учраас эрсдэлийн удирдлага болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөлтийг тусдаа сургалт болгох нь зүйтэй гэж үзэж байна. Судалгааны дүнгээс харахад олон бизнес эрхлэгчид эрсдэл, ер бусын нөхцөл байдлын үед хэрхэн ажиллах талаар суралцах шаардлагатай гэж хариулсан байсан.

Тиймээс энэ чиглэлийн сургалтыг тогтмол сургалт болгох саналтай байна. Эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны тасралтгүй байдлын сургалт нь илүү суурь мэдлэгт төвлөрч, санхүүгийн мэдлэг олгох суурь сургалтын хэд хэдэн сэдвийг өөр өөр өнцгөөс хэрэгжүүлэх юм: орлого, зарлагын талаар ойлголт өнгөрсөн болон одоогийн орлого, зарлагаа мөшгих, задлан шинжлэхээс гадна ирээдүйн орлого, зарлагаа тооцоолох чадвартай байхыг хэлдэг буюу нягтлан бодох бүртгэл, төсвөөс эхэлдэг.

Гарч болзошгүй орлого, зарлагыг тооцоолох нь ялангуяа хямралын үед маш чухал болдог. Бизнесүүдийн хувьд энэ нь тогтворгүй орчинд хөрвөх чадвар, ашиг орлогоо удирдах, хямрал эсвэл нөхцөл байдлын гэнэтийн өөрчлөлтийг даван туулахын тулд бизнесийн үйл ажиллагаандаа тохирох өөрчлөлтийг хийх үндэс суурь болдог. Тиймээс нягтлан бодох бүртгэл, төсөвтэй холбоотой стандарт сургалтын материалуудаас энэ хөтөлбөрийн ялгаатай нь эдгээр сэдвүүдийг тогтворгүй орчинд бизнес эрхлэх талаас нь боловсруулсан юм. Энэхүү сургалт нь мөн л бизнесээ урт хугацаанд хөгжүүлэхээр зорьж буй бизнес эрхлэгчийн хувьд чухал ноу-хау учир “стандарт” сургалтын нэг хэсэг болгох саналтай байна.

Улам бүр дижиталчлагдаж буй өнөөгийн нөхцөлд жижиг бизнесийн цахим худалдааны салбар эрчимтэй хөгжиж байгаа учир цахим худалдааг тусдаа сургалт болгох саналтай байна. Энэхүү сургалтын ноу-хау нь байнга өөрчлөгдөж буй эрэлт / худалдан авалтын зан төлөвт дасан зохицох, гадаадын, томоохон цахим худалдааны бизнесүүдтэй өрсөлдөх шаардлагатай болж буй жижиг, дунд бизнесүүдэд чухал ач холбогдолтой болж байна. Цахим худалдаа нь санхүүгийн боловсролын сонгодог сэдэв биш боловч дижитал дэлхий ертөнцөд цахим худалдааны ноу-хау улам бүр чухал болж, санхүүгийн боловсролын үндсэн хэсгүүдийн нэг болох нь тодорхой байна.

Дээрх хоёр сэдвийг орлого, зарлагаа тооцоолох, бизнесийн болон хөрвөх чадварын суурь төлөвлөлт хийх хэмжээний санхүүгийн суурь боловсролтой БЖДБ эрхлэгчдэд санал болгох нь зүйтэй.

Эмэгтэйчүүдийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг ихээхэн нэмэгдэх төлөв харагдаж байгаа тул бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд чиглэсэн бусад төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран тусгай сургалтын курс, сургалтуудыг санал болгох нь зүйтэй.

Зорилтот бүлгүүдэд ашиглах суурь сургалтын материал нь ижил / төстэй байх бөгөөд илүү түвэгтэй ЖДБ-ийн жишээ авах, бичил болон илүү жижиг бизнест зориулсан ноу-хауг илүү дэлгэрүүлэн танилцуулах (зээлийн батлан даалтын захиа гэх мэт арга хэрэгслүүд) гэх мэтээр өөр өөр зорилтот сегментэд зориулан өөрчлөлт оруулах боломжтой.

Түүнчлэн, санхүү, даатгал гэх мэт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдэд тусгайлан зориулсан дараах сэдвүүдийг санал болгох нь зүйтэй. Үүнд:

- Зохицуулалт / хууль эрх зүйн орчны мэдээлэл;
- Зээлийн багцийн удирдлага;
- Зээлдэгч (даатгуулагч)-ийн эрсдэлийн үнэлгээ болон багцийн сегментчлэл / сегментүүд;
- Хөрөнгийн үнэлгээ.

Байгаа нөөц болон оролцогч талын хамтын ажиллагаанаас хамаарч эдгээр сэдвүүдийг өөрчлөх, тохируулах боломжтой.

## **2 Бүтэц, зохион байгуулалт, хэрэгжүүлэх хугацаа, тайлан, хэрэгжүүлэх үндсэн суваг, удирдлагын бүтэц**

### **2.1 Бүтэц, зохион байгуулалт, үнэлгээ**

Монгол банк нь санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Мэдээллийг цаг тухайд нь солилцох, оролцогч талуудын үр ашигтай, үр дүнтэй хамтын ажиллагааг хангахын тулд Монгол банкны удирдлага доор оролцогч талуудын байнгын хороо байгуулж, улиралд нэгээс доошгүй удаа уулзалт хийж байх нь зүйтэй. Хороо нь сургалтын жилийн төлөвлөгөө болон БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой бусад үйл ажиллагааг батлах, хөтөлбөрийн хэрэгжилтийн төлөвлөлтийг сайжруулах, төлөвлөгөө / арга хэмжээний хэрэгжүүлэлт болон үр дүнг хянах, хэрэгжүүлэлтийн явцад суралцсан зүйлс, сайн туршлагад үндэслэн дараагийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг гүйцэтгэх үүрэгтэй байна.

Хорооны гишүүдийг Монгол Улсад БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чин хүсэл сонирхолтой байгууллагуудаас сонгох нь зүйтэй. Сонирголоо илэрхийлсэн байдал, оруулах боломжтой хувь нэмэрээс нь хамааран дараах байгууллагуудаас гишүүн сонгох боломжтой: Санхүүгийн зохицуулах хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, Зээлийн батлан даалтын сан болон Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим.

Хорооны хурлаар хэрэгжүүлж буй / шинэ үйл ажиллагаа, хэрэгжүүлж дууссан үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөнд оруулах аливаа өөрчлөлт, хэрэгжилт, дараагийн улирлын төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг асуудлыг хэлэлцдэг байна.

Илүү тодорхой хэлбэл, оролцогч талууд дараах хэлбэрээр хамтран ажиллана. Үүнд:

- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах, санхүүжилт авах боломжийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор авах санхүүжилтийн арга хэмжээнүүдийг хянах;
- Судалгаа, шинжилгээ явуулах, техникийн туслалцаа үзүүлэх (сургагч багш эсвэл сургалт материал, анги танхим гэх мэт);
- Чадамж нэмэгдүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөг хамтран зохион байгуулах, төлөвлөх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг хамтран хянах, үнэлэх, шаардлагатай өөрчлөлтүүдийг тохиролцох;
- Өгөгдөл болон нөөцийг үр дүнтэй хуваалцах;
- Бусад байгууллагыг хөтөлбөрийн оролцогч талаар урих, оролцуулах.

### **2.2 Хэрэгжүүлэх хугацаа**

Сургалтын хөтөлбөрийн төслийг 2021 оны эхэнд боловсруулж туршилтын сургалтыг явуулсан. Сургалтын үр дүнг төслийн үндэсний хурал дээр танилцуулна. Туршилтын сургалтын үр дүнд тулгуурлан сургалтын хөтөлбөрүүдэд зохих сайжруулалтыг хийсэн бөгөөд хэрэгжүүлэх явцад дахин сайжруулалтуудыг хийж явна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт хугацааг одоогоор таван жил гэж төлөвлөж байна. 1 дүгээр үе шатанд үндсэн материалуудыг боловсруулж, БЖДБ эрхлэгчдийн ихэнх хэсгийг эзэлдэг бичил болон жижиг бизнесүүдэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Харин 2 дугаар үе

шатанд илүү том хэмжээтэй жижиг болон дунд бизнесүүдэд төвлөрч ажиллана. 1 дүгээр үе шат эхэлсэний дараа санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдэд чиглэсэн тусгай сургалтыг БЖДБ-үүдэд чиглэсэн үндсэн үйл ажиллагаатай зэрэгцэн боловсруулж, зохион байгуулна.

## 2.3 Тайлан

БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн оролцогч талуудын байнгын хорооны өмнөөс Монголбанк нь Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд жил тутамд тайлан хүргүүлнэ.

## 2.4 Хэрэгжүүлэх үндсэн суваг

Олон сувгийг ашиглана. Судалгаанд оролцогчид нүүр тулсан сургалт болон товхимол / гарын авлагыг илүүд үзсэн байсан боловч дижитал сувгууд / олон нийтийн мэдээллийн хэрэгслийг мөн ашиглана. Үндсэн дижитал суваг нь одоогийн санхүүгийн боловсролын вэб хуудсанд БЖДБ эрхлэгчдэд зориулсан дэд хуудас нээж, санхүүгийн боловсролтой холбоотой гол асуудлуудыг оруулж байна (татаж авах ном, товхимол, видео, хөтөлбөрүүдийн мэдээлэл гэх мэт). Түүнчлэн телевиз, радиогийн нэвтрүүлэгт орох, сонинд нийтлүүлэх нь олон нийтийн дунд мэдээлэл тараах, хөдөө орон нутагт хүргэхээс гадна БЖДБ-үүдийг ноу-хауг дамжуулах дижитал сувгуудыг идэвхитэй ашиглахад уриалах юм. Нүүр нүүрээ харсан сургалтуудыг Улаанбаатар хотоос гадна оролцогч талуудаас санал болгосон дэд бүтцийг ашиглан хөдөө орон нутгуудад явуулна.

## 2.5 Хүлээж буй үр дүн

Хөтөлбөрийн хүрээнд дараах үр дүнг хүлээж байна. Үүнд:

- Төсөв, төлөвлөлт, эрсдэлийн удирдлагын үндэс, санхүүгийн арга хэрэгслүүд, тэдгээрийн өвөрмөц онцлог, давуу ба сул талууд гэх мэт үндсэн сэдвүүдээр цаасаар болон татаж авах боломжтой электрон товхимол / гарын авлагууд бэлтгэгдсэн байна. Эдгээрийг Монголбанк болон оролцогч талуудын сүлжээгээр тараана.
- Үндсэн сэдвүүдээр бэлтгэсэн видеонуудыг интернэтээр тараана.
- Хөдөө, орон нутгуудад нүүр нүүрээ харсан сургалтуудыг хийх байнгын төлөвлөгөө (жил тутам төлөвлөж, хэвлэгддэг) гаргана.
- Сонгосон сэдвүүдээр БЖДБ эрхлэгчдэд сургалт явуулах эрхтэй 30 орчим сургагчийг эхний ээлжинд бэлтгэнэ.
- Хөдөө орон нутагт илүү олон хүнд хүргэх, сургалтын сэдвүүдийг баяжуулах нэмэлт сургагч нарыг тогтмол бэлтгэх эрхтэй, чадвартай сургагч багш бэлтгэгч нар бий болно.
- Сургалт болон сургалтын материалуудыг олон нийтэд хүргэх, тодорхой сэдвүүдээр (Зээлийн батлан даалтын сан гэх мэт тодорхой байгууллагын тухай баримтат кино гэх мэт) илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгч суурь мэдлэг олгох зорилгоор сурталчилгааны төлөвлөгөө (маркетингийн төлөвлөгөө; жил тутам төлөвлөж, хэрэгжүүлдэг) боловсруулна.

## 2.6 Хөтөлбөрийн санхүүжилт

### 2.6.1 Санхүүжилтийн эх сурвалж

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг улсын төсөв болон олон улсын зээл тусламж, мөн бусад эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ.

Монголбанк нь бусад оролцогч талтай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтэнд шаардлагатай санхүүжилтийг босгох чиглэлээр ажиллана.

## 2.6.2 Зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зардал-үр дүн болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг эрхэмлэнэ.

Тэргүүлэх чиглэлүүдээр хэрэгжүүлэх үйл ажиллагаануудад одоогийн ижил төстэй үйл ажиллагааг хүндэтгэж, өмнөх буюу одоогийн үйл ажиллагаанд тулгуурлана. Монголбанкны удирдлага доор оролцогч талуудын байнгын хороо байгуулж үйл ажиллагааны харилцан уялдааг хангах замаар шаардлагагүй давхардлаас аль болох зайлсхийнэ.

Оролцогч талууд БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх төлөвлөлт, зохицуулалт, хяналт, үнэлгээ хийх зорилготой Монголбанкны доор байгуулагдсан БЖДБ эрхлэгчийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх байнгын хороогоор дамжуулан харилцана.

## 2.7 Хяналт, шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байнгын хорооноос хяналт, үнэлгээ, тайлан гаргахаас гадна Монголбанкнаас хөтөлбөрийн нөлөөллийг илүү гүнзгийрүүлсэн түвшинд хянана. Олгох боломжтой төсвөөс хамааран Монголбанкны зүгээс судалгааны институт, төрийн бус байгууллага гэх мэт гуравдагч талыг оролцуулж болно.

Хөтөлбөрийн үнэлгээ нь дараах зүйлсэд төвлөрнө. Үүнд:

- Зорилтот бүлэг(үүд)-т хүрсэн байдал, зорилтот бүлэг(үүд)-ийн санхүүгийн мэдлэг дээшилсэн байдал;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарсан зардлуудыг үр дүнтэй зарцуулсан байдал.

Үнэлгээний үр дүнд тулгуурлан хөтөлбөрт сайжруулалт хийх (дараагийн үйл ажиллагаанууд болон санхүүжилт хуваарилалтын талаар шийдвэр гаргах) мөн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллагууд дараагийн үйл ажиллагаануудаа сайжруулах боломжтой болно.

Хөтөлбөр боловсруулах эхний үе шатны нэг хэсэг болох туршилтын сургалтын үнэлгээнээс гадна дахин нэг үнэлгээг хоёр үе шатны төгсгөл хэсэгт хийнэ:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн эхний хоёр жилд сүүлийн улиралд;
2. Дараагийн төлөвлөгөө гаргахын тулд хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусахаас өмнөх зургаан сарын хугацаанд.

Хөтөлбөрийн зорилт бүрээр, шалгуур үзүүлэлтийг урьдчилан тодорхойлж, тухайн зорилтын биелэлтийг үнэлэхэд ашиглана.

Хөтөлбөрийн үр дүнг нарийн хэмжихэд хүндрэлтэй байдаг учир холбогдох өгөгдлүүдийг цуглуулах, харьцуулахад дараах аргыг ашиглахыг санал болгож байна:

Монголбанкнаас 2020 онд БЖДБ-үүдийн дунд явуулсан санхүүгийн мэдлэгийн судалгааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрийн төгсгөлд дахин явуулна. Энэ нь гарсан өөрчлөлтийг хянах, дараагийн / хоёрдахь үе шатанд хийх сайжруулалтыг төлөвлөх боломж олгоно.

Түүнчлэн Монголбанк болон оролцогч талууд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн стратегийн үйл ажиллагаа бүрийн үр дүнг үнэлнэ.

Монголбанк болон оролцогч талууд нь мөн БЖДБ-үүдийн тоо, гүйцэтгэл, санхүүгийн үйлчилгээ авсан байдал, санхүүгийн байгууллагын зээлийн багцийн үзүүлэлт болон санхүүгийн ба БЖДБ-ийн сектороос гарсан аливаа хоёрдогч өгөгдөл, холбогдох судалгаануудад задлан шинжилгээ хийнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш ойролцоогоор хоёр болон таван жилийн дараа нөлөөллийн бие даасан нэмэлт үнэлгээг төвийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага эсвэл гуравдагч талаар хийлгэж болно.



### 3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хэд хэдэн тэргүүлэх чиглэлд хуваасан боловч хэрэгжүүлэх арга хэмжээ, материалууд нь нэг нэгэндээ тулгуурласан бөгөөд 2 дугаар үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь 1 дүгээр үе шатны үргэлжлэл болно. Сонирхсон бүх БЖДБ эрхлэгч 2 үе шатны материалуудтай танилцах боломжтой.

#### Алсын хараа:

Бизнесийн санхүүгийн үйл ажиллагаагаа үр дүнтэй удирдахад хэрэгцээтэй мэдлэгийг байнга хүртэх боломжоор хангах

#### Зорилт:

- Төслийн нөлөөг нэмэгдүүлэх үүднээс оролцогч талуудын хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээлэл солилцоог хангах;
  - Санхүүгийн мэдлэгийг үр ашигтай, зардал хэмнэлттэй хэлбэрээр дээшлүүлэх;
- Үүний үр дүнд:
- Бизнес эрхлэгч/жижиг бизнес эрхлэгчдийн бизнесийн санхүүгээ удирдах чадварыг дээшлүүлэх;
  - Бизнес эрхлэгч/жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн гэмт хэргээс сэргийлэх чадварыг дээшлүүлэх;
  - Бизнес эрхлэгч/жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх.

Тэргүүлэх чиглэл 1:  
Хувиараа бизнес эрхлэгч

Тэргүүлэх чиглэл 2:  
Бичил, жижиг бизнес

Тэргүүлэх чиглэл 3:  
Жижиг, дунд бизнес

Тэргүүлэх чиглэл 4:  
Дунд бизнес

Тэргүүлэх чиглэл 5:  
Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч БЖДБ

Үйл ажиллагаа:  
- Сургалтын товхимол боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Видео боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Багш бэлдэгчийг сургах  
- Бүс нутгуудаас багш бэлдэх  
- Хуваарь, хэвлэлийн төлөвлөгөө гаргах  
- Бизнес эрхлэгчдэд зориулсан вэб сайтын булан гаргах

Үйл ажиллагаа:  
- Сургалтын товхимол боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Видео боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Багш бэлдэгчийг сургах  
- Бүс нутгуудаас багш бэлдэх  
- Хуваарь, хэвлэлийн төлөвлөгөө гаргах  
- Бичил, жижиг бизнест зориулсан вэб сайтын булан гаргах (хувиараа бизнес эрхлэгчдийн булантай хавсаргах)

Үйл ажиллагаа:  
- Сургалтын товхимол боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Видео боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Багш бэлдэгчийг сургах  
- Бүс нутгуудаас багш бэлдэх  
- Хуваарь, хэвлэлийн төлөвлөгөө гаргах  
- Жижиг бизнест зориулсан вэб сайтын булан гаргах

Үйл ажиллагаа:  
- Сургалтын товхимол боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Видео боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Багш бэлдэгчийг сургах  
- Бүс нутгуудаас багш бэлдэх  
- Хуваарь, хэвлэлийн төлөвлөгөө гаргах  
- Тусгай сэдвүүдээр вэб сайтын булан гаргах, энэ нь ихэнхдээ дунд бизнест зориулсан байх

Үйл ажиллагаа:  
- Сургалтын товхимол боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Видео боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулах  
- Багш бэлдэгчийг сургах  
- Бүс нутгуудаас багш бэлдэх  
- Хуваарь, хэвлэлийн төлөвлөгөө гаргах

#### Шалгуур:

- Тараасан эсвэл татсан товхимолын тоо
- Вэб сайтад зочилсон тоо
- Нүүр нүүрээ харсан сургалтанд хамрагдсан хүний тоо
- Бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн түвшин

#### Шалгуур:

- Тараасан эсвэл татсан товхимолын тоо
- Вэб сайтад зочилсон тоо
- Нүүр нүүрээ харсан сургалтанд хамрагдсан хүний тоо
- Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн түвшин

#### Шалгуур:

- Тараасан эсвэл татсан товхимолын тоо
- Вэб сайтад зочилсон тоо
- Нүүр нүүрээ харсан сургалтанд хамрагдсан хүний тоо
- Жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн түвшин

#### Шалгуур:

- Тараасан эсвэл татсан товхимолын тоо
- Вэб сайтад зочилсон тоо
- Нүүр нүүрээ харсан сургалтанд хамрагдсан хүний тоо
- Дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн түвшин

#### Шалгуур:

- Тараасан эсвэл татсан товхимолын тоо
- Вэб сайтад зочилсон тоо
- Нүүр нүүрээ харж зөвлөгөө өгсөн тоо
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч БЖДБ-ийн санхүүгийн мэдлэгийн түвшин

### 3.1 Үндсэн үйл ажиллагаа

Тэргүүлэх чиглэл / дэд сегментүүдийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- Нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан хийх арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудас бий болгох, уг хуудсанд сургалттай холбоотой мэдээллийг тогтмол оруулах;
- Заавал биш: Ахлах сургууль болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт холбогдох сэдвүүдийг оруулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамыг дэмжин ажиллах;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд стратеги/төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

Суурь материалыг боловсруулах / олж авах / тохируулах болон ашиглахад голлон анхаарна. Дараа нь эдгээр материалыг хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл (зорилтот бүлэг)-үүдэд тохируулан өөр жишээ ашиглах, сэдвийг илүү гүнзгий хэлбэрээр танилцуулах, зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн илүү тодорхой сэдэв оруулах гэх мэтээр өөрчилж ашиглана. Санал болгож буй сэдвүүдийг 4 дэх хэсэгт оруулсан болно.

### 3.2 Тэргүүлэх чиглэл 1: Хувиараа бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх

#### 3.2.1 Үндэслэл

Маш цөөн ажилтантай буюу ажилтангүй хувиараа бизнес эрхлэгч / бичил бизнес болон маш жижиг бизнесүүд Монгол Улсын бизнесүүдийн ихэнх хэсгийг бүрдүүлж, олон өрх гэрийн амьдралыг залгуулж байдаг. Тэдний санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь өөрөө нийт эдийн засагт нөлөөлнө.

Хөдөө орон нутагт илүү өргөн хүрээтэй хүрч ажиллахын тулд интернэт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэл төвлөрсөн арга хэлбэр (гэртээ, интернэтээр бие даан судлах боломжтой) болон асуулт асууж, биечлэн дэмжлэг авах боломжтой нүүр нүүрээ харсан үйл ажиллагаа (улс орон даяар өөр өөр газруудад хийх)-г хослуулах нь зүйтэй.

Бизнесийн удирдлага болон бизнесийн санхүүжилтийн сэдвүүдийг их дээд сургууль болон дунд сургуулийн ахлах ангийн сургалтын хөтөлбөрт оруулах нь одоогийн ба ирээдүйн бизнесийн соёл, бизнестэй холбоотой санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

#### 3.2.2 Үйл ажиллагаа

Дээр дурдсаны дагуу, илүү өргөн хүрээнд түгээхийн тулд үйл ажиллагаануудыг олон сувгаар түгээх нь зүйтэй.

- Хувиараа бизнес эрхлэгчидтэй нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Хувиараа бизнес эрхлэгчдийг сургах сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- Хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудсанд хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээллүүдийг оруулж байх;
- Заавал биш: Ахлах сургууль болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт холбогдох сэдвүүдийг оруулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамыг дэмжин ажиллах;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд стратеги/төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

### **3.3 Тэргүүлэх чиглэл 2: Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх**

#### **3.3.1 Үндэслэл**

Зарчмын хувьд, хувиараа бизнес эрхлэгчийн үндэслэл болон үйл ажиллагаа нь бараг нэг ойлголт юм. Тиймээс хувиараа бизнес эрхлэгчдэд төдийлөн хамааралгүй, хуулийн дагуу бүртгүүлсэн аж ахуйн нэгжид зориулсан компанийн бүртгэлийн төрлүүд, хил дамнасан үйл ажиллагааг үр дүнтэй удирдах гэх мэт тодорхой хэсгүүдийг ялангуяа нүүр нүүрээ харсан сургалтын хувьд нарийвчлан тодорхойлоход анхаарах нь зүйтэй.

#### **3.3.2 Үйл ажиллагаа**

- Бичил, жижиг бизнес эрхлэгчидтэй нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг сургах сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудсанд бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээллүүдийг оруулж байх;
- Заавал биш: Ахлах сургууль болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт холбогдох сэдвүүдийг оруулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамыг дэмжин ажиллах;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;

- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны бичил, жижиг бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд стратеги/төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

### **3.4 Тэргүүлэх чиглэл 3: Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх**

#### **3.4.1 Үндэслэл**

БЖДБ-ийн салбар нь нэг биш гурван сегмент (групп)-ээс бүрддэг салбар юм: энгийн зохион байгуулалттай жижиг бизнесийн үйл ажиллагаа (хувиараа бизнес эрхлэгч, бичил бизнес болон зарим жижиг бизнес), үүнээс арай илүү нарийн түвэгтэй бизнесийн үйл ажиллагаа (жижиг болон дунд бизнес), эцэст нь зохион байгуулалт, удирдлагын хэрэгцээний хувьд компани, корпорациудтай илүү төстэй дунд бизнес. Эдгээр сегмент бүрийн санхүүгийн мэдлэгийн хэрэгцээ шаардлага өөр өөр байдаг.

Тодорхой хэмжээнд хүрч өргөжсөний дараа аливаа бизнес цаашид илүү өргөжих, тогтвортой хөгжихийн тулд хэрхэн үйл ажиллагаа явуулахаа тодорхойлж, ажиллах арга хэлбэрээ өөрчлөх шаардлага тулгардаг. Энэхүү өөрчлөлт нь бизнесийн зохион байгуулалт, баримт бичиг, бизнесийн үр дүнг удирдах, нийлүүлэгч ба худалдан авагчтай харилцах чиглэлээр ихэвчлэн хийгддэг. Энгийн үгээр хэлбэл хувиараа бизнес эрхлэгчид нарийн түвэгтэй биш, албан ёсны санхүү, тайлангүй бизнесийг амжилттай удирдан авч явдаг хэдий ч тухайн бизнесийн үйл ажиллагаа илүү нарийн түвэгтэй болж, цаг тухайд нь, бүрэн дүүрэн, ойлгомжтой хэлбэрээр явуулах шаардлага тулгарах тусам тусламж хэрэгтэй болдог. Бизнесийн гүйлгээнүүдийн хэмжээ их болох тусам илүү нарийн хөрвөх чадварын удирдлагыг хэрэгжүүлэх хэрэгтэй болдог. Тиймээс нарийн түвэгтэй санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр хэмжээний хувьд илүү том бизнесүүдэд зориулсан сургалтыг хөгжүүлэх нь зүйтэй.

#### **3.4.2 Үйл ажиллагаа**

Зарчмын хувьд, бичил болон жижиг бизнест ашиглах суваг, үндсэн үйл ажиллагаанууд төстэй. Сэдвүүдийн хувьд хамгийн том ялгаа нь ашиглах жишээнүүд юм. Энэ зорилтот бүлгийн хувьд нийтлэг сэдвүүд нь хөрвөх чадварын удирдлага, баримтжуулах үйл ажиллагааны олон хэлбэр, гадаад валют, үл хөдлөх хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалт байна.

- Жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг сургах сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудсанд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээллүүдийг оруулж байх;

- Заавал биш: Ахлах сургууль болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт холбогдох сэдвүүдийг оруулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамыг дэмжин ажиллах;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд стратеги/төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

### **3.5 Тэргүүлэх чиглэл 4: Дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх**

#### **3.5.1 Үндэслэл**

Дунд бизнесүүд нь ирээдүйд байгууллагын бизнес болох магадлалтай учир тусгайлан анхаарах нь чухал. Дунд бизнесийн дотоодын нийт бүтээгдэхүүн болон ажил эрхлэлтийн түвшинд оруулах хувь нэмэр нь бичил, жижиг бизнестэй харьцуулахад өндөр байна.

#### **3.5.2 Үйл ажиллагаа**

Зарчмын хувьд, ашиглах суваг болон үндсэн үйл ажиллагаанууд нь жижиг, дунд бизнесийн сегменттэй төстэй. Энэ зорилтот бүлгийн хувьд нийтлэг сэдвүүд нь баримтжуулах үйл ажиллагааны олон хэлбэр, гадаад валют, төслийн төлөвлөлт ба санхүүжилт байна.

- Дунд бизнес эрхлэгчидтэй нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Дунд бизнес эрхлэгчдэд зориулсан товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Дунд бизнес эрхлэгчдийг сургах сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- Дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудсанд дунд бизнес эрхлэгчдэд зориулсан мэдээллүүдийг оруулж байх;
- Заавал биш: Ахлах сургууль болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт холбогдох сэдвүүдийг оруулах чиглэлээр Боловсрол, шинжлэх ухааны яамыг дэмжин ажиллах;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай тохиолдолд стратеги/төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.

### **3.6 Тэргүүлэх чиглэл 5: Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-ийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх**

#### **3.6.1 Үндэслэл**

Санхүүгийн салбарыг бэхжүүлэх нь Монгол Улсын хувьд чухал ач холбогдолтой хэвээр байна. Энэ нь бичил санхүүгийн байгууллага, даатгалын компани, банк бус санхүүгийн

байгууллагуудад мөн хамаарна. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлнэ.

### 3.6.2 Үйл ажиллагаа

Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй БЖДБ-үүдэд санхүүгийн боловсролын бусад төрлийн сургалтуудад хамрагдахаас гадна санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулахад туслах тусгай сургалт шаардлагатай байдаг. Энэ нь голлон зохицуулалтын орчны мэдээллийг хаанаас авах, зээлийн багцийн үнэлгээ ба удирдлагын ноу-хаутай байх, зээлдэгч, даатгуулагчийн эрсдэлийн үнэлгээ хийх, хөрөнгөө зөв үнэлэх зэрэг байдаг.

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй нүүр нүүрээ харсан сургалтын материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан товхимол, видео хийх материал боловсруулах, цуглуулах, тохируулж авах;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг сургах сургагч багш, сургагч багш бэлдэгч нарыг тодорхойлж, сургах;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтын дэлгэрэнгүй хуваарь гаргах;
- БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой дэд цахим хуудсанд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан мэдээллүүдийг оруулж байх эсвэл СЗХ-ны цахим хуудас руу линк хийж өгөх;
- Шаардлагатай санхүүжилтийг босгоход оролцогч талууд хамтран ажиллах;
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид, банк бус санхүүгийн байгууллагуудад үзүүлж буй нөлөөг хянах, үнэлэх.

## 4 Хэрэгжүүлэлт

1 дүгээр үе шатыг 2 - 2.5 жил байхаар, сургагч багш нарыг сургах, үндсэн материал боловсруулах, хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах болон хувиараа бизнес эрхлэгч, бичил болон дунд бизнесүүдэд голлон чиглэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1 дүгээр үе шаттай зэрэгцээд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдэд зориулсан сургалтын материал, үйл ажиллагаануудыг зарим оролцогч талууд боловсруулж эхлэнэ. Эдгээр үйл ажиллагааг хөтөлбөр эхэлсэнээс хойш ойролцоогоор 9-12 сарын хугацаанд гүйцэтгэнэ. Ингэснээр санхүү, даатгалын үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүд үндсэн сургалтанд хамрагдах боломж бий болно.

1 дүгээр үе шатны төгсгөл хэсэгт хөтөлбөрийг сайжруулах, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БЖДБ-үүдэд зориулсан дараагийн үйл ажиллагаануудыг төлөвлөх зорилгоор үнэлгээ хийнэ. Энэ нь мөн 2 дугаар үе шатны төлөвлөлт, хэрэгжүүлэлтэнд ашиглагдана.

2 дугаар үе шатанд боловсруулсан материалуудыг сайжруулах, жижиг, дунд бизнесүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад анхаарал илүү төвлөрүүлнэ. Хэрэгжүүлэлтийн төлөвлөлтийн загварыг Хавсралт 3-аас харна уу.

2 дугаар үе шатны төгсгөл хэсэгт дараагийн хөтөлбөрийг тодорхойлох зорилгоор үнэлгээ хийгдэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн туршид оролцогч талуудын байнгын хороо төлөвлөлт, хэрэгжилтийг хянаж, үр дүнтэй байдал, өртөг үр дүнг нэмэгдүүлэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийнэ.

#### 4.1 Санал болгосон сэдвүүд

2 үе шатаар хамрах сэдвүүдийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ (INFE)-ийн зөвлөмжийн дагуу сонгосон.<sup>4</sup>

##### 4.1.1 Нэгдүгээр үе шат:

- Орлого, зарлагаа тооцоолох (нягтлан бодох бүртгэлийн үндэс);
- Төсөв ба төлөвлөгөө, бизнесийн ба төслийн төлөвлөлт;
- Татварын үндсэн ойлголт;
- Эрсдэлийн удирдлагын үндсэн ойлголт (эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах)
- Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн талаар үндсэн ойлголт (зээл, даатгалын олон төрлүүд гэх мэт);
- Аль бүтээгдэхүүнийг сонгох, ашиглахаа хэрхэн шийдэх (зээлийн зардлын тооцоолол гэх мэт);
- Санхүүгийн байгууллагатай хэрхэн ярилцах;
- Цахим худалдаа, онлайн аар бизнес хийх үндсэн зарчмуудыг ойлгох;
- Бизнесийн дэмжлэг, туслалцааны хөтөлбөрүүдийн мэдээлэл (баталгаа, зөвлөх үйлчилгээ, татварын схем);
- Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага (үндсэн сургалт);
- Магадгүй, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт;
- Цахим худалдааны талаар үндсэн ойлголт.

##### 4.1.2 Хоёрдугаар үе шат:

Хувиараа бизнес эрхлэгч, бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд чиглэсэн үйл ажиллагаанууд үргэлжилнэ. Төлөвлөлтийг 1 дүгээр үе шатанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын үнэлгээ, оролцогчдын дүгнэлтэнд тулгуурлан хийнэ. Гэхдээ 2 дугаар үе шатанд дараах сэдвүүдэд голлон төвлөрнө. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайланг нэгтгэх;
- Бизнесийн бүртгэлийн олон хэлбэр;
- Татвар;
- Нарийн түвэгтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг ойлгох (хөрөнгө оруулалт, даатгал, баримтжуулалт, гадаад валют, дотоод валютын нөлөө гэх мэт);
- Эрсдэлийн удирдлага;
- Хямралын удирдлага, үйл ажиллагааны тасралтгүй төлөвлөлт;
- Төслийн төлөвлөлт;
- Зээл, тусламжийн хөтөлбөрүүдийн мэдээлэл;
- Магадгүй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан сургалт;
- Гүнзгий түвшний цахим худалдаа.

<sup>4</sup> OECD (2018), OECD/INFE Core competencies framework on financial literacy for MSMEs

#### 4.1.3 Санхүү, даатгалын үйлчилгээ эрхэлдэг БЖДБ-үүд:

- Хууль эрх зүй, зохицуулалтын орчны мэдээлэл;
- Зээлийн багцийн удирдлага;
- Зээлдэгч (даатгуулагч) болон зээлийн багцийн сегментчлэл/сегментийн эрсдэлийн үнэлгээ;
- Хөрөнгийн үнэлгээ;
- Жендерт мэдрэмтгий сургалт.

Оролцогч тал / засгийн газрын зорилгоор хамааран хэрэглэгчийг хамгаалах, жижиг бизнесийг хамгаалахтай холбоотой асуудлууд, зээл тусламжийн хөтөлбөрүүд, Монголд байгаа даатгалын төрлүүд болон БЖДБ ба санхүүгийн салбарын хөгжлийн чиглэлээр бусад сэдвүүдийг нэмэх боломжтой.

#### 4.2 OECD/INFE-ийн шалгуураар тодорхойлсон санхүүгийн мэдлэгийн үндсэн чадварууд

OECD/INFE-ээс *ур чадварын төрөл* (санхүүгийн үйлчилгээ сонгож ашиглах, санхүүгийн болон бизнесийн удирдлага ба төлөвлөлт, эрсдэл ба даатгал), *санхүүгийн боловсролын хэмжээс* (ойлголт, мэдлэг, чадвар, зан төлөв, хандлага), болон *байгууллагын хөгжил* (үндсэн/албан бус, старт-ап/албан ёсны болж буй, өргөжиж буй болон хааж буй) зэргийг тодорхойлж өгсөн байдаг нь бизнесийн хөгжлийн өөр өөр түвшин, БЖДБ-ийн хэмжээнд тохируулан санхүүгийн боловсролын өөр өөр түвшинг тодорхойлох боломж олгодог.

Хавсралт 4-ийг харна уу.

Санал болгож буй сэдвүүд нь OECD/INFE-ээс зөвлөмж болгосон ихэнх хүчин зүйлүүдийг хамарсан. 4.1-д заасан сэдвүүдийг санхүүгийн суурь мэдлэгийн каталог болгон ашиглах бөгөөд нэмж баяжуулж болно. Одоогоор байгаа мэдээллээс харахад ихэнх сэдвээр тодорхой материалуудыг тодорхой эх сурвалжуудаас цуглуулах боломжтой.

- Хадгаламжийн банкны олон улсын сан (Sparkassenstiftung)-аар дамжуулан Монголбанкнаас:

Бизнесийн удирдлага болон санхүүгийн үйлчилгээг ашиглахтай холбоотой сэдвүүд:

- Урьдчилан тооцоолох / Төлөвлөх;
- Харилцагчаа таних;
- Нийлүүлэгчийн менежмент;
- Бүтээгдэхүүн/Бүтээгдэхүүний хослол;
- Ажилтнууд;
- Технологи/Үйлдвэрлэлийн үйл явц;
- Өрсөлдөөн;
- Зээл авах;
- Хадгалам;
- Тохирох санхүүгийн байгууллагаа хэрхэн сонгох вэ?

- USAID REACH-ээс:

Бизнесийн төлөвлөлт болон гаднаас санхүүжилт (зээл) авахтай холбоотой сэдвүүд:

- Зээлийн бичиг баримт бүрдүүлэлт;
- Бизнесийн төлөвлөлт;
- Нягтлан бодох бүртгэл.



- USAID BEST Programme (Business Excellence for Sustainability and Transparency (BEST)-аас:

Бизнесийн удирдлага (бизнесийн бүтэц), төслийн төлөвлөлт, санхүүжилт авах болон дижитал сувгуудыг ашиглах талаар материал:

- Бизнесийн загвар;
- Олон нийтийн сүлжээний маркетинг;
- Facebook Chatbot
- Төслийн санал хөгжүүлэх;
- Саналаа танилцуулах;
- Бизнесийн зээл хэрхэн авах вэ?

Энэхүү материал нь боловсруулалт шатанд байгаа.

- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв (Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-тай хамтран боловсруулсан)-өөс:

Хувь хүний бизнесийн санхүүтэй холбоотой материал:

- Хувийн орлого, зарлагаа хэрхэн тооцоолох вэ?
- Банкнаас зээл хэрхэн авах вэ?
- Төслийн санхүүжилт гэж юу вэ? Хэд хэдэн банкнаас төслийн санхүүжилтийн зээл хэрхэн авах вэ? (аль банк төслийн санхүүжилтийн зээл олгож байна? Зээлийн шаардлага, нөхцлүүд нь юу вэ?)
- Нягтлан бодох бүртгэлийн үндэс.
- Хувийн болон бизнесийн хуримтлал. Хуримтлуулах зуршлыг хэрхэн бий болгох вэ?
- Санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүнүүдийг суурь мэдлэг.

COVID-19-ийн шалтгаалан нэмэгдсэн:

- Санхүүгийн мэдлэг;
- Дижитал шилжилт (дижитал болохтой холбоотой бүх сэдвүүд).

### 4.3 Хэрэгжүүлэх үйл явц / ашигласан материал

Хөтөлбөрийн хүрээнд өөр өөрийн оруулах хувь нэмрийн талаар оролцогч талуудаас мэдээллүүд ирүүлсэн. Дараах хүснэгтэнд дурьдсанчлан энэхүү хувь нэмэр нь орон нутгуудын сургалтын байраар хангах, сургалтанд хамрагдах БЖДБ эрхлэгчдийг олоход туслахаас эхлээд сургалтын зарим функцуудыг хариуцан явуулах хүртэл олон хэлбэртэй байсан.

Table 1 Оролцогч талуудаас ирүүлсэн мэдээлэл

Асуулт	СЗХ	Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Зээлийн батлан даалтын сан	Жижиг, дунд үйлдвэрийн газар	МҮХАҮТ /Бизнесийн академи/
<p><b>БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр танай байгууллага ямар үүрэг гүйцэтгэнэ гэж харж байна?</b></p> <p><b>Танай байгууллага ас ямар хувь нэмэр оруулж чадах вэ? (өөрийн төсөв, эх сурвалж эсвэл төлөвлөсөн төсөв/эх сурвалж)</b></p>	<p>Хөтөлбөр батлагдвал СЗХ-оос аль болох сайн оролцоно. Манай сургалтын нэгж СЗХ-ний өмнөөс зохион байгуулалтын үйл ажиллагаануудад оролцож, шаардлагатай бол сургалтын танхимаар хангана. Гэвч одоогоор санхүүгийн боловсролд зориулан тавигдсан төсөв байхгүй байгаа.</p>	<p>Хэрвээ боломжтой бол, хамтарсан ажлын хэсэгт орж ажиллах, БЖДБ эрхлэгчдэд сургалт зохион байгуулах, нэгдсэн байдлаар мэдээллээр хангах зэргээр оролцоно. Шаардлагатай бол сургалтын танхимаар хангаж, хамтарсан сургалт хийх боломжтой.</p>	<p>Жижиг, дунд үйлдвэрийн хэлтэс нь 39 ажилтантай, аймаг бүрт Хөдөө аж ахуйн хэлтэст ЖДБ-ийн мэргэжилтэнтэй. Тиймээс сургалт явуулах, мэдээлэл түгээх хүний нөөц сайтай. Санхүүжилтийн хувьд 2021 оны төсөвт тодорхой туссан зүйл байхгүй боловч хамтран ажилладаг олон улсын байгууллага, төслүүдэд танилцуулах боломж бий.</p>	<p>Сангийн дотоод нэгж бүрт сургалт, хамтын ажиллагаа хариуцсан 1 мэргэжилтэн байдаг. Эдгээр мэргэжилтнүүд сургалт зохион байгуулах үүрэгтэй. Сан нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг учир сургалтын танхимаар хангах боломжгүй. Харин сургалтын тоног төхөөрөмж, хамтын ажиллагаа, хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх боломжтой.</p>	<p>Хөтөлбөр батлагдвал Жижиг, дунд үйлдвэрийн газар БЖДБ-үүдэд сургалтын зар тарааж, тэдний оролцоог хангах боломжтой. Мөн тодорхой хуваарийн дагуу сургалтын өрөөгөөр хангаж чадна.</p>	
<p><b>Танай байгууллага ямар сэдвээр сургалт явуулдаг / ойрын хугацаанд явуулахаар төлөвлөсөн бэ? (бүх сэдвийн жагсаалтыг агуулга, хугацаа, хэлбэрийг тодруулж ирүүлнэ үү)?</b></p>	<p>Германы GIZ төсөлтэй хамтран СЗХ-оос ЖДБ-ийн даатгалын сургалт явуулсан.</p>	<p>Манай байгууллага Төсөл бичих аргачлал, Үйлдвэрлэл ба үйл ажиллагааны удирдлага, маркетингийн удирдлага гэсэн сургалтуудыг явуулдаг.</p>	<p>Яамны зүгээс шууд бие даан хийдэг сургалт байхгүй. Сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулдаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөл бичих талаар сургалт</li> <li>• Зээлийн баталгаа гэж юу болох, хэрхэн хүсэлт гаргах талаар банк, банк бус санхүүгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт</li> <li>• ЖДБ-ийн зээлийн баталгаа, түүнийг хэрхэн авах тухай сургалт</li> <li>• Азийн хөгжлийн банкны зөөлөн, баталгаат зээл хэрхэн авах сургалт</li> </ul>	<p>Агентлагийн зүгээс салбарын эрхзүйн орчин болон төсөл боловсруулах аргачлалын сургалтууд явуулдаг. Мөн USAID-BEST хөтөлбөр, EBRD болон JICA-ийн хамтаар БЖДБ-үүдэд зориулсан сургалт явуулдаг.</p>	<p>Бизнесийн академи нь санхүүгийн менежерүүдэд зориулсан урт хугацааны сургалт зохион байгуулдаг. Ирээдүйд санхүүгийн мэдээллийн шинжилгээ, санхүүгийн удирдлага, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтын сургалтууд хийхээр төлөвлөсөн.</p>

<p><b>Танайд байгаа сургагч нар (мөн тэдний заадаг сэдэв), сургагч болгохоор сургалтанд хамруулах хүсэлтэй нэр дэвшигчийн жагсаалтыг гаргаж өгнө үү.</b></p>	<p>Сэдвээс хамааран СЗХ сургалтыг явуулах эсвэл санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн холбоодтой хамтран сургалт явуулдаг.</p>	<p>Сургалт хариуцсан 2 багшийг сургалтанд хамруулах боломжтой.</p>	<p>Яаманд сургалт явуулах боломжтой хэлтэс, нэгжүүд бий. Жишээ нь, хөнгөн үйлдвэр, хүнсний чиглэлийн ихэнх хэлтэс ЖДБ дээр анхаарч байгаа. Тэдгээр хэлтсийн холбогдох ажилтныг ашиглах боломжтой.</p>	<p>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын сургалтанд суусан 2 багш бий. 2 багшаас гадна баталгаа, эрсдэлийн 4 мэргэжилтэн сургалт явуулах боломжтой.</p>	<p>Бодлого, зохицуулалтын хэлтэс, Зээлийн төслийн хэлтэс, Бүртгэл, мэдээлэл, нэг цэгийн үйлчилгээний хэлтсийн нийт 15 ажилтан сургалт хийх боломжтой.</p>
<p><b>БЖДБ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрөөс танай байгууллагын хувьд ямар үр дүн хүлээж байна вэ?</b></p>	<p>БЖДБ-үүд санхүүгийн зах зээлд хэрхэн оролцох, үр ашгийг нь хүртэх, эрсдэл гаргахаа мэддэггүй тул бидний зүгээс хийх энэ судалгаа, шинжилгээ, мэдлэг, мэдээлэл нь санхүүгийн зах зээлд чухал ач холбогдолтой.</p>	<p>Хөтөлбөр батлагдвал нийслэл хот дахь БЖДБ эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн мэдлэг дээшлүүлэх сургалтанд хамруулах чиглэлээр хамтран ажиллах хүлээлтэй байна.</p>	<p>Маш чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Учир нь БЖДБ-үүд үйлдвэрлэлдээ ихэнх анхаарлаа хандуулаад санхүү, төлөвлөлтөө хаядаг. Энэ хөтөлбөрийн онцлог нь гадны хүмүүсээр бичүүлдэг, төлөвлүүлдэг байдлыг өөрчлөнө гэж үзэж байна.</p>	<p>- БЖДБ-ийн зээлийн баталгааны талаар ойлголтыг нэмэгдүүлнэ - Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслүүдэд хэрхэн оролцох талаар БЖДБ-үүдийн мэдлэг сайжрана. - Зээлийн батлан даалтын сангаас хийдэг сургалтын материалыг энэ хөтөлбөрийн сургалтын агуулгад оруулж өгнө. - Санхүүгийн удирдлагын чадамжаа бэхжүүлэхэд БЖДБ-үүдэд туслана.</p>	<p>Хөтөлбөр батлагдвал БЖДБ-үүд санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, капиталын менежментээр дамжуулан санхүүгийн боловсролоо нэмэгдүүлэх боломжтой.</p>

Эх сурвалж: Зөвлөх багийн өмнөөс Монголбанкны цуглуулсан мэдээлэл; Зөвлөх багийн орчуулсан мэдээлэл.

Зохицуулах байгууллага болон удирдах институтыг сонгосон / үүсгэн байгуулсаны дараа доор дурьдсан зүйлсийг дахин нягтлан үзэх нь зүйтэй:

- Бэлэн байгаа материалууд;
- Бэлтгэгдсэн сургагч, багш нар;
- БЖДБ эрхлэгчдийг сургалтанд оролцуулахад ашиглах боломжит сувгууд;
- Бэлэн байгаа сургалтын өрөө, талбай;
- Сургалт явуулдаг бусад байгууллага.

Хавсралт 5-аас үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд ашиглах загварыг харна уу.

**Additional information on international/national projects in Mongolia for improvement of financial/economic literacy of MSMEs**

(as far as information could be obtained by CT)

Donor	Beneficiary	Target group	Modules (elements)	Contents	Implementation period	still in place	Components is still in use	Delivery channels	Comments of the CT
The Asia Foundation funded by Korea International Cooperation Agency (KOICA)	Municipality of Ulaanbaatar, Mongolian National Chamber of Commerce and Industry, Golomt Bank	Women SMEs, mostly start-up's	The main programme activity is <ul style="list-style-type: none"> <li>incubator programmes for start-ups.</li> <li>comprehensive Business Training</li> <li>Consulting Services</li> <li>Networking events</li> <li>Financial literacy training.</li> <li>create ICT training content.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>How to write a project proposal.</li> <li>Project financing proposal.</li> <li>Product development, packaging.</li> <li>Financial training in Business planning and start Up.</li> <li>computer literacy, using of online marketplaces.</li> <li>Channels are online as well as classroom training</li> </ul>	2016 until 2018 7,500 participants, second phase no evaluation (2018-2020) 2020-2024-funding from the Government of Canada within WEE project is insured.	Women's Business Center and Incubator – programme is in the closing stage	WBC's main partner was Development Solutions NGO.  For incubation programmes, usually they invited different specialists from Chamber of Commerce, Golomt Bank, local Universities to conduct training for participants.  Partnership with Golomt Bank is ended.	<ul style="list-style-type: none"> <li>Online courses</li> <li>Class-room trainings</li> <li>online platform</li> <li>online marketplace</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Topics are useful.</li> <li>Include Municipality of UB into stakeholders</li> <li>Access to the material should be organised via BoM</li> <li>The WBC itself doesn't have any trainers. Center contracts different trainers and organisations to conduct trainings.</li> <li>New focus area: financial literacy and digital transformation (main requirement: simple language, understandable for start-ups with no financial education background)</li> </ul>
USAID REACH: To improve SME access to credit	Governmental Contract	SMEs in Ulaanbaatar, Dundgovi, Selenge, Bayan-Olgii and Dornod aimags (provinces).	<ul style="list-style-type: none"> <li>Strengthen SMEs' capacity to qualify for loan requirements.</li> <li>Facilitate SME loan value through forging partnerships.</li> <li>Facilitate the awarding of 500 hundred loans worth 25 million USD to SMEs with improved borrowing capacity</li> <li>Launch operations centers in five target areas to identify SMEs credit access needs</li> <li>Implement effective public dissemination of information</li> <li>Achieve financial inclusion for SMEs through behavioural changes and improved financial literacy.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Loan documentation preparation</li> <li>Business planning</li> <li>Accounting</li> <li>Available only for SMEs with following eligibility criteria:                             <ul style="list-style-type: none"> <li>Intention to seek a loan</li> <li>Substantial number of years of business operations</li> <li>Financial Services Institution and/or Credit Guarantee Fund requirements or minimal collateral</li> <li>Reliable financial records and history</li> <li>Demonstrated need for financial and technical support</li> </ul> </li> </ul>	May 2016- April 2018	No, but material available at Development Solutions (NGO) From the <i>Internet research (15.01.2021)</i> based on the reports published by USAID the 5 SME centers still in place	WBC's main partner was Development Solutions NGO.	Through the 5 operation center	<ul style="list-style-type: none"> <li>USAID REACH work worldwide and has standardised material, which is than adopted to special country conditions. The standard material is available in English at <a href="https://www.usaid.gov/mongolia/factsheets/reach-project-small-and-medium-enterprise-access-credit">https://www.usaid.gov/mongolia/factsheets/reach-project-small-and-medium-enterprise-access-credit</a></li> <li>REACH worldwide concentrates on supporting SMEs to get a loan and to support concrete SMEs with business advice.</li> </ul>
Business Excellence for Sustainability and Transparency (BEST) by USAID	In partnership with Mongolian non-governmental organization Development Solutions, will provide technical assistance and training to	SMEs in Ulaanbaatar and 12 provinces, such as Darkhan-Uul, Orkhon, Selenge, Dornogovi, Zavkhan, Dornod.	Business development training (as the program started just in 2020, no systemic approach can be seen in Mongolia yet)	<ul style="list-style-type: none"> <li>Business model</li> <li>Social Media Marketing</li> <li>Facebook Chatbot</li> <li>Project Proposal Development</li> <li>Pitching</li> <li>How to get a business loan (Commercial Banks introduce their products)</li> </ul>	2020-2025 5 years program	Just started in Mongolia, first tranche overall 15 million USD, has been increased in January 2021 to 18 million USD	WBC's main partner was Development Solutions NGO. (The training within the framework of the program are very similar to Women's Business Center)	including easier access to business financing.	<ul style="list-style-type: none"> <li>The BEST programme by USAID works already in several countries. The material is based on the Business continuity lifecycle. The important difference to all other projects is the combination of supply and demand side right from the beginning (very similar to the approach of Sparkassenstiftung) and the combination of training, direct assistance and even grants.</li> </ul>

1. Санхүүгийн үйлчилгээ сонгох	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
1.1 Төлбөр, хадгаламжийн үйлчилгээ (үндсэн)	<ul style="list-style-type: none"> <li>Албан ёсны төлбөр, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг ашиглахын давуу болон сул тал, хязгаарлалтын талаар мэдлэгтэй болно.</li> <li>Бизнесүүдэд үзүүлдэг төлбөр, хадгаламжийн үйлчилгээнүүд болон дижитал үйлчилгээнүүд, тэдгээрийн зардлыг талаар үндсэн ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үнэ, гүйлгээний зардал, чанар, үйлчилгээ, нийлүүлэгч, харилцагчийн сонголт болон бусад хүчин зүйлүүдийг харгалзан бизнесийнхээ хэрэгцээнд нийцсэн, хамгийн тохиромжтой төлбөр, хадгаламжийн үйлчилгээ, дижитал үйлчилгээг сонгох.</li> <li>Ижил төстэй бүтээгдэхүүн дундаас үнэ, чанарыг харгалзан энгийн сонголт хийх чадвартай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийнхээ хэрэгцээ шаардлагын талаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй ярилцахдаа өөртөө итгэлтэй болно.</li> <li>Төлбөр, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн үйлчилгээ авахаар судалгаа хийхдээ өөртөө итгэлтэй болно.</li> </ul>	• 1	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн үндсэн бүтээгдэхүүнүүдийн ойлголт</li> <li>Ямар бүтээгдэхүүнийг ашиглах, ашиглахгүйгээ тодорхойлох</li> <li>Санхүүгийн байгууллагатай хэрхэн ярилцах вэ?</li> </ul>
1.2 Төлбөр, хадгаламжийн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>Харилцагчид үзүүлсэн төлбөрийн үйлчилгээтэй холбоотой хураамжууд (POS машин эсвэл автомат төлбөрийн терминал ашигласны хураамж)-ын үндсэн ойлголттой болно.</li> <li>Валют арилцаа, гадаад валютаар хийх гүйлгээтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон бүтээгдэхүүнүүдэд эс сонголт хийх.</li> <li>Хувийн болон бизнесийн гүйлгээ, төлбөр, хадгаламжийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийнхээ хэрэгцээ шаардлагын талаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй ярилцахдаа өөртөө итгэлтэй болно.</li> </ul>	• 2, 3 болон 4; мөн 5	<ul style="list-style-type: none"> <li>Дээр дурдсан сэдвүүдэд нэвтрэх</li> <li>Нарийн түвэгтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүд (Банкны баталгаа, батлан даалтын захиа гэх мэт)</li> </ul>

1. Санхүүгийн үйлчилгээ сонгох	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
	<p>холбоотой зардлуудын талаар үндсэн ойлголттой болно.</p>	<p>дансуудаа тусад нь нээх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай тохиолдолд бизнесийн гүйлгээгэе гадаад валютаар хийх чадвартай.</li> <li>• Сонгосон гүйлгээ, төлбөр, хадгаламжийн үйлчилгээндээ тогтмол дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол солих.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төлбөр, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн үйлчилгээ авахаар судалгаа хийхдээ өөртөө итгэлтэй болно.</li> <li>• Гадаад валютаар бизнесийн гүйлгээнүүд хийхдээ өөртөө итгэлтэй болно.</li> </ul>		
<p>1.3 Бизнесийг санхүүжүүлэх (үндсэн)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнес эхлүүлж, үйл ажиллагаа явуулдаг болоход хэр зэрэг мөнгө шаардлагатай болдогыг мэддэг болно.</li> <li>• Бизнес эхлүүлэхэд шаардлагатай анхдагч хөрөнгүүдийн хэдэн хувийг гадаад эх үүсвэрээс олох шаардлагатай болдог талаар мэддэг болно.</li> <li>• Гэр бүл, найз нөхөд гэх мэт өөр өөр эх сурвалжаас санхүүжилт авсанаар үүсэх нөхцөл байдлын талаар ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнес эхлүүлэх зардалдаа үнэлгээ хийж, эдгээр зардлыг нөхөх бодитой төлөвлөгөө гаргах.</li> <li>• Бизнесээ санхүүжүүлэх шийдвэрийг гаргахдаа олон сонголтын давуу, сул талуудыг харьцуулж мэдээлэлтэй шийдвэр гаргах.</li> <li>• Санхүүжилт авахдаа олон газрыг харьцуулж үзэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесээ санхүүжүүлэх санхүүгийн төрөл бүрийн бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хайхдаа өөртөө итгэлтэй болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 1 болон 2</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Орлого ба зарлагыг мөшгих (НББ-ын үндэс)</li> <li>• Төсөв, төлөвлөлтийн үндэс</li> </ul>
<p>1.4 Бизнесийг санхүүжүүлэх (ахисан)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнес эхлүүлэх, старт-ап үе шатыг санхүүжүүлэхэд ашиглах санхүүжилтийн боломжууд (гэр бүл дотроо, гадаад эх үүсвэрээс, төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн санхүүжилт, өр ба хөрөнгө)-ын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>• Гаднаас санхүүжилт авахад туслах бүтээгдэхүүнүүд, тэднийг хэрхэн ашиглах, эрсдэл болон давуу талуудын талаар мэддэг болно.</li> <li>• Зээл авахаар хөөцөлдөх үед барьцаа эсвэл баталгаа олгогчийн гүйцэтгэх үүргийн талаар мэддэг болно.</li> <li>• Бизнесийг ямар нэгэн хэлбэрээр өр тавьж санхүүжүүлэх нь бизнесийн эзэмшигчийн хүлээх хариуцлагыг талаар ойлголттой болно.</li> <li>• Банк, хөрөнгө оруулагч болон бусад санхүүжүүлэгчдийн шийдвэр гаргах үйл явц, бизнесийн зээлжих чадвар, хөрөнгө оруулалтыг нэмэх талаар ойлголттой болно.</li> <li>• Санхүүжилтийг олон нийтийн эсвэл ашгийн бус эх сурвалжуудаас авах талаар үндсэн мэдлэгтэй болно.</li> <li>• Бизнесийг санхүүжүүлэх дижитал үйлчилгээ, платформуудын ашиг тус, эрсдэл, зардал болон сул талуудын талаар ойлголттой (краудфандинг, хувь хүмүүс нэгэндээ зээлэх гэх мэт) болно.</li> <li>• Бизнесийн хэмжээ, хөгжлийн түвшингээс хамаарч ямар санхүүгийн бүтээгдэхүүн тохиромжтойг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• MSMEs БЖДБ-ийг дэмжих чиглэлээр улсын хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд өөр өөр түвшинд гарсаан санхүүгийн дэмжлэг, зээлүүдийг судалж олох, авах.</li> <li>• Бизнес эхлүүлэх, старт-ап үе шатанд санхүүжүүлэх хамгийн сайн сонголтуудыг олох.</li> <li>• Засгийн газрын дэмжлэг, өр гэх мэт санхүүжилтийн өөр өөр эх сурвалжуудын дунд тэнцвэртэй сонголт хийх.</li> <li>• Бичиг баримт бэлдэх, бизнесийн үр дүнтэй төлөвлөгөө боловсруулах, капитал босгохын тулд саналаа танилцуулах.</li> <li>• Complying with the requirements of banks and investors Банк болон хөрөнгө оруулагчдын шаардлагыг хангах ("банкинд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Банк, хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч гэх мэт гадаад эх сурвалжаас санхүүжилт авах талаар хандах, ярилцахдаа өөртөө итгэлтэй болно.</li> <li>• Санхүүжилтийн хамгийн тохиромжтой хувилбарыг хайж олохдоо итгэл төгс, шийдэмгийн байна.</li> <li>• Өөрийн бизнес төлөвлөгөөг хамгаалахдаа бусдыг ятган үнэмшүүлэх, өөрийгөө ойлгуулдаг болно.</li> <li>• Санхүүжилтийн зорилгоо биелүүлэхийн төлөө уян хатан, өөдрөг хандлагатай болно.</li> <li>• Хөрөнгө оруулагч, зээлдэгчээс татгалзсан хариу авсан ч өөдрөг, бодитой хандлагаар хандаж, дахин оролдож үзнэ.</li> <li>• Бизнесээ өргөжүүлэхтэй холбоотой гарах санхүүгийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дээр дурдсан сэдвүүдэд нэвтрэх</li> <li>• Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт</li> </ul>

1. Санхүүгийн үйлчилгээ сонгох	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
	<p>талаар ойлголттой болно (бичил бизнест тохиромжгүй).</p> <ul style="list-style-type: none"> <li>Зээлжих зэрэглэлийг хэрхэн ашигладаг, зээлийг үнэлэхэд санхүүгийн талаас ямар нөлөө үзүүлдэг талаар ойлголттой болно (Монголын нөхцөлд таарах бол).</li> <li>Бизнесээ өргөжүүлэхэд аль санхүүжилтийн арга хамгийн тохиромжтойг тодорхойлох талаар ойлголттой болно.</li> <li>Капиталын зах зээл хэрхэн үйл ажиллагаа явуулдаг болон түүнд нэвтрэхэд ямар шаардлагууд тавигддаг талаар ойлголттой болно.</li> </ul>	<p>таалагддаг” эсвэл “хөрөнгө оруулахад бэлэн” байх).</p> <ul style="list-style-type: none"> <li>Нөхөн төлөлтийн үйл явцын нөхцлүүдийг хангах.</li> <li>Банк болон санхүүжилтийн бусад гадаад эх сурвалжуудтай санхүүгийн харилцаа тогтоож, бизнесийнхээ талаар байнга мэдээлэл өгсөнөөр зээл эсвэл хөрөнгө оруулалт авах үйл явцаа сайжруулах.</li> <li>Өөрийн оронд ашигладаг зээлийн зэрэглэл авах алхам хийх.</li> <li>Зээлийн зэрэглэлдээ тогтмол дүн шинжилгээ хийж, сайн үнэлгээгээ хадгалах.</li> <li>Бизнесээ өргөжүүлэхэд хамгийн тохирох санхүүжилтийн боломжийг бизнесийнхээ хөгжлийн үе шат, эрсдэлийн түвшин, санхүүжилтийн хэмжээ зэргээс хамааран сонгох.</li> </ul>	асуудлуудад проактив байдлаар хандана.		

2. Санхүү, бизнесийн удирдлага ба төлөвлөлт	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
2.1 Бүртгэл, татвар болон бусад эрх зүйн шаардлагууд	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсад байдаг бизнесийн төрлүүд, тэдгээрийн хууль, санхүү, эдийн засгийн нөлөөнүүдийн талаар үндсэн ойлголттой болох.</li> <li>Зарим бизнесийн хувьд зээлтэй холбоотой бүх хариуцлагыг бизнесийн эзэн өөрөө хүлээдэг байж болох талаар ойлголттой болох.</li> <li>Бизнесийг албан ёсоор бүртгүүлэх эсвэл албан бус бизнесийг албан ёсны бизнес болгохын давуу болон сул тал, үзүүлэх нөлөөний талаар ойлголттой болно.</li> <li>Бизнес нээх, эзэмшихтэй холбоотой хууль эрх зүйн шаардлагууд (гэрчилгээ, даатгал, бүтээгдэхүүний зохиогчийн эрх, патент, татвар, санхүүгийн тайлан).</li> <li>Бизнесийн татварын шаардлагуудыг хэрхэн хангах талаар ойлголттой болно</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийнхээ хууль зүйн хувьд хамгийн тохиромжтой хэлбэрийг өөрөө эсвэл мэргэжлийн зөвлөлтэй хамтран, бизнесийн хэрэгцээ, зорилгодоо нийцүүлэн сонгох.</li> <li>Гэрчилгээ, санхүүгийн тайлан, лиценз, татвар, даатгал гэх мэт бизнес эхлүүлэх, ажиллуулахтай холбоотой хууль зүйн шаардлагуудыг тухайн бүрд нь биелүүлж байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хууль эрх зүйн холбогдох шаардлагуудыг хүндэтгэж үзэх, биелүүлэх тал дээр анхаарлаа төвлөрүүлдэг болно.</li> <li>Хуулийн үүрэг хариуцлагыг биелүүлэхдээ цаг хугацаанд нь, урагшаа харсан байдлаар хандана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1,2, 3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Татвар</li> <li>Нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн тайлан нэгтгэх</li> <li>Бизнесийн бүртгэлийн өөр өөр маягуудыг ашиглах</li> </ul>

2. Санхүү, бизнесийн удирдлага ба төлөвлөлт	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилгот бүлэг)	Сэдэв
	<p>(Зарим санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах гэх мэт)</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнес хамааралтай татваруудын (орлогын, компанийн, борлуулалтын гэх мэт) болон бизнесийн татвар төлөхтэй холбоотой шаардлагуудын талаар ойлголттой болно.</li> <li>Татварын хөнгөлөлт буюу чөлөөлөлтийн боломжуудын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Ажилтан авах, элсүүлэхтэй холбоотой хүний нөөц, хууль эрх зүйн асуудлууд (цалин, тэтгэвэр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа гэх мэт)-ын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Ажилтнуудын цалин, тэтгэврийн менежментийг зохицуулах аргууд (ажилтны өмнөөс хийх, нягтлан бодогч хөлсөлж/ажилд авч хийлгэх), тэдний давуу ба сул талууд;</li> <li>Нөөц стратегиудтэй холбоотой хууль эрх зүй, санхүүгийн шаардлагуудын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Дампуурлын хууль эрх зүйн талаас үзүүлэх нөлөө, тавигдах шаардлагуудын талаар үндсэн ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шаардлагатай үед татварын шаардлагуудыг биелүүлэх чадвартай байх.</li> <li>Ажилтнуудын цалин, тэтгэвэрийн тохирох шийдлийг сонгох (тохирох хөтөлбөр олох, мэргэжилтэн хөлслөх гэх мэт).</li> <li>Ажилтнуудын цалин, тэтгэвэрт сонгосон шийдэл нь үр дүнтэй байгаа эсэхийг тогтмол үнэлж, шаардлагатай бол солих.</li> <li>Бизнесээс гарах стратегитэй холбоотой татвар, даатгал, лиценз цуцлуулах, ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох гэх мэт үүрэг хуулийн шаардлагуудыг биелүүлэх.</li> </ul>			
<p>2.2 Бүртгэл хөтөлөлт ба нягтлан бодох бүртгэл (үндсэн)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн орлого ба төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд (орлого, ашиг, хөрөнгө, даатгал гэх мэт) тэдний харилцан уялдааны талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесийн бүх төрлийн орлого болон тухайн бизнест байнга гарч болзошгүй зардлуудын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Зарим зардлын өвөрмөц онцлогууд (хувирамтгай эсвэл тогтмол)-ын талаар ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орлого, зардлаа хянах</li> <li>Богино хугацааны бэлэн мөнгөний урсгал болон төсвийн тооцоолол хийх.</li> <li>Assessing if the business is making a profit or losing money</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зардал болон ашгаа хянахдаа шургуу, тэвчээртэй байдлаар хандана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1 болон 2</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орлого, зарлагаа хянах (НББ-ын үндэс)</li> </ul>
<p>2.3 Бүртгэл хөтөлөлт ба нягтлан бодох бүртгэл (гүнзгий)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлан, бэлэн мөнгөний урсгалын тайлан, ашиг, алдагдлын тайлангийн бүтэц, хоорондын ялгааны талаар ойлголттой болно.</li> <li>Нягтлан бодох бүртгэл хөтөлөлтийн боломжит шийдлүүд (ашиглах боломжтой програмууд, мэдрэгжлийн хүн хөлсөлж/ажилд авч хийлгэх гэх мэт), тэдгээрийн давуу ба сул талуудын талаар үндсэн ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн бүх орлого, төлбөр, гэрээүүдийг нягтлан бодох бүртгэл, даатгал, татварын зорилгоор баримтжуулж, бүртгэх.</li> <li>Нягтлан бодох бүртгэл хөтөлөлтөндөө мэргэжлийн хүн хөлслөх гэх мэт тохиромжтой шийдлийг сонгох, энэхүү шийдэлдээ тогтмол дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол солих.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нягтлан бодох бүртгэл, даатгал болон татварын тайлангаа заавал гаргадаг болно.</li> <li>Нягтлан бодох бүртгэл, тайлангийн хамгийн тохиромжтой шийдлийг итгэл төгс сонгодог болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн тайланг нэгтгэх</li> </ul>
<p>2.4 Богино хугацааны санхүүгийн удирдлага (үндсэн)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Хувийн болон бизнесийн санхүүгээ салгахын ач холбогдол, салгаагүйгээс үүсэх эрсдэлийн талаар ойлголттой болно.</li> <li>Тоног төхөөрөмжийн элэгдэл, харилцагчийн төлбөрийн нөхцөл болон нийлүүлэгчийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хувийн болон бизнесийн санхүүгээ салгах.</li> <li>Бизнес эрхлэгч/ээндээ орлого оруулах, энэхүү орлогоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хувийн болон бизнесийн санхүүгээ тусад нь хөтлөдөг болно.</li> <li>Бэлэн мөнгөний урсгалаа тогтмол, цаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1, 2 болон 3; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орлого, зарлагаа хянах (НББ-ын үндэс)</li> <li>Төсөв, төлөвлөгөө (богино хугацааны)</li> </ul>

2. Санхүү, бизнесийн удирдлага ба төлөвлөлт	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилгот бүлэг)	Сэдэв
	<p>төлбөрийн нөхцөл гэх мэт хүчин зүйлүүд богино хугацаанд бэлэн мөнгөний урсгалд хэрхэн нөлөөлдөг талаар ойлголттой болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>Богино хугацааны менежмент (инфляци, хүү, валютын арилжааны ханш, элэгдэл хорогдол гэх мэт)-тэй холбоотой санхүүгийн үндсэн ухагдахуун ба зарчмын талаар ойлголттой болно.</li> </ul>	<p>бизнесийн зардал болгох.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнес эхлүүлэх, орлого олж байгаа үед нь ажиллуулсаар байхад хангалттай хөрөнгийг хадгалах.</li> <li>Ирээдүйд гарах бэлэн мөнгөний хэрэгцээ, хөрвөх чадварт тулгарах асуудлыг тооцоолохын тулд бэлэн мөнгөний урсгалыг богино хугацаанд, тогтмол хянах.</li> <li>Орлого, зардлыг богино хугацаанд удирдаж, бизнесийн тогтмол зардлуудаа төлөх.</li> <li>Бэлэн мөнгөний урсгалын тооцооллыг бэлэн мөнгөний хэмжээтэй харьцуулж, бизнес төлөвлөсний дагуу ажиллаж байгааг хянах.</li> </ul>	<p>тухайд нь, нарийвчлан хянадаг болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнес эхлүүлэхдээ урагшаа харсан хандлагатай байна.</li> </ul>		
<p>2.5 Богино хугацааны санхүүгийн удирдлага (гүнзгий)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн бэлэн мөнгөний урсгалд богино хугацаанд нөлөөлж болзошгүй зээлийн эргэн төлөлт гэх мэт хүчин зүйлүүдийн талаар ойлголттой болно.</li> <li>Кредит данс гэх мэт богино хугацааны санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өвөрмөц онцлог, бэлэн мөнгөний урсгалыг удирдахад хэрхэн дэмжлэг болдог талаар ойлголттой болно.</li> <li>Богино хугацааны менежментэд хамааралтай санхүүгийн харьцаануудын талаар ойлголттой болно.</li> <li>Салбарын санхүүгийн харьцаануудыг тодорхойлдог болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн харьцаа ба харьцуулалтуудыг салбарын харьцаатай харьцуулж, бизнесээ богино хугацаанд хянах, удирдах.</li> <li>Орлого, зардал, хувьцаа ба бараа материалаа богино хугацаанд удирдах, нийлүүлэгчид төлөх төлбөр, татвар, зээлийн төлбөрөө төлөх чадвартай байх.</li> <li>Тогтмол зардлыг төлөхөд бэлэн мөнгөний асуудал тулгарсан үед зарим санхүүгийн эх сурвалжийг хурдан хугацаанд хөдөлгөөнд оруулах (богино хугацааны зээл, банкны хасах гэх мэт)</li> <li>Хэрэглэгч төлбөр хоцроосноос гарах хор уршгийг үнэлэх, түүнийг шийдвэрлэх арга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төлбөрөө хугацаанд нь төлөхөд анхаардаг, бэлтгэдэг байна.</li> <li>Богино хугацааны бэлэн мөнгөний хэрэгцээг тооцоолж чаддаг болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн тайлан нэгтгэх</li> <li>Төсөв, төлөвлөгөө</li> </ul>



2. Санхүү, бизнесийн удирдлага ба төлөвлөлт	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилгот бүлэг)	Сэдэв
		<p>замыг олох (харилцагчаа болгоомжтой сонгох, тэдний нөхцөл байдлыг зөв үнэлэх, төлбөрийг зээлийн даатгалаар дамжуулан урьдчилж авах гэх мэт).</p> <ul style="list-style-type: none"> <li>Өөр өөр бүтээгдэхүүн/үйлчилгээний ашигт байдлыг тодорхойлох.</li> </ul>			
<p>2.6 Богино хугацаанаас дээш төлөвлөлт (үндсэн)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн санхүүжилтийн ирээдүйн төлөвлөлттэй холбоотой санхүүгийн ухагдахуун ба зарчмууд (нийлмэл хүү гэх мэт)-ын талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесийн санхүүжилтийн ирээдүйн төлөвлөлтийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон санхүүгийн харьцаануудын талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесээ өргөжүүлэхийн тулд төлөх ёстой болох зардлууд (шинэ тоног төхөөрөмж, нэмэлт ажилтан, шинэ лиценз, шинэ байршил гэх мэт)-ын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Бизнесийн өсөлтийг санхүүжүүлэх олон хувилбарын давуу ба сул талуудын талаар ойлголттой болно.</li> <li>Ажилтан авах, хөдөлмөрийн хуулийн шаардлагуудыг биелүүлэхэд санхүүгийн талаас учруулах нөлөөний талаар ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дунд болон урт хугацааны бизнесийн хэрэгцээ (бэлэн мөнгөний хомсдол, татвар, зээлийн төлбөр, тоног төхөөрөмж хуучрах, бизнесээ өргөжүүлэх гэх мэт)-ээ харгалзан бизнесийн санхүүгээ удирдах.</li> <li>Хүлээгдэж буй орлого, зээлийн төлбөрийн хугацааг тохируулах, зээлээ төлөх бэлэн мөнгөгүй болохоос зайлсхийх.</li> <li>Дунд хугацаанд орлого нэмэгдүүлж зардлаа бууруулах үйл ажиллагаанууд (үнээ өөрчлөх, сурталчилгаа явуулах)-ыг хэрэгжүүлэх.</li> <li>Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө болон бизнесийг дунд-урт хугацаанд хөгжүүлэх төсвийг бий болгох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесээ өргөжүүлэх боломжуудыг эрэлхийлдэг байна.</li> <li>Бизнесээ урьдчилан төлөвлөх стратегийн хараа, мотиваци, урт хугацааны чиглэлтэй болно.</li> <li>Бизнесээ өргөжүүлэх боломж руу хөтөлдөг проактив хандлагатай болно.</li> <li>Ёс зүй, тогтвортой байдлын асуудлуудаа бизнесээ өргөжүүлэхдээ анхаардаг болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>2 болон 3; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төсөв, төлөвлөгөө (хагас жилийн)</li> <li>Жижиг хэмжээтэй хөрөнгө оруулалтын төлөвлөлт</li> <li>Цахим худалдаа</li> </ul>
<p>2.7 Богино хугацаанаас дээш төлөвлөлт (гүнзгий)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн санхүүжилтийн ирээдүйн төлөвлөлттэй холбоотой санхүүгийн ухагдахуун ба зарчмууд (нийлмэл хүү гэх мэт)-ын талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесийн санхүүжилтийн ирээдүйн төлөвлөлтийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон санхүүгийн харьцаануудын талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесээ өргөжүүлэхийн тулд төлөх ёстой болох зардлууд (шинэ тоног төхөөрөмж, нэмэлт ажилтан, шинэ лиценз, шинэ байршил гэх мэт)-ын талаар үндсэн ойлголттой болно.</li> <li>Бизнесийн өсөлтийг санхүүжүүлэх олон хувилбарын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесээ өргөжүүлэх шалтгаан, боломжуудыг судлах (үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагаар эсвэл өрсөлдөх чадвараа хадгалахын тулд).</li> <li>Тодорхой хөрөнгө оруулалт нь өөрийн бизнест илүү ашигтай болохыг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесээс гарах стратегийг урт хугацаагаар урьдчилан хардаг болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төсөв, төлөвлөгөө (урт хугацааны)</li> <li>Хөрөнгө оруулалтын төлөвлөлт</li> <li>Цахим худалдаа</li> </ul>

2. Санхүү, бизнесийн удирдлага ба төлөвлөлт	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
	<p>давуу ба сул талуудын талаар ойлголттой болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажилтан авах, хөдөлмөрийн хуулийн шаардлагуудыг биелүүлэхэд санхүүгийн талаас учруулах нөлөөний талаар ойлголттой болно.</li> <li>Бизнес зогсох, өмчлөлийн хэлбэр өөрчлөгдөх, шилжүүлэх (гэр бүлийн гишүүн, ажилтан, удирдлага, гадны байгууллага гэх мэт бусад этгээдэд шилжүүлэх, зарах) нөхцлийг тооцоолж боловсруулсан стратегийн хувь хүний болон бизнесийн санхүүд үзүүлэх нөлөөний талаар ойлголттой болно.</li> <li>Дампуурлын хувь хүний болон бизнесийн санхүүгийн хувьд үзүүлэх нөлөөний талаар ойлголттой болно.</li> <li>Бизнесийг зарах буюу өвлүүлэх зорилгоор зах зээлийн ханшийг нь тогтоох талаар мэддэг болно.</li> </ul>	<p>хөрөнгө оруулалтын анализ хийх.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнесээ гарах стратегийн хэлбэрүүдийг урьдчилан үнэлэх, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн зөвлөхийн тусламж авах.</li> <li>Бизнесээ хаах, шилжүүлэх, зарах, залгамжлуулах талаар урьдчилан төлөвлөх.</li> <li>Бизнесээ хаах, шилжүүлэх тохиолдолд авлагаа цуглуулах, бараа, бизнесийн хөрөнгөө зарах, үлдэгдэл зээлээ барагдуулах, бизнесийнхээ үнэлгээг тогтоох болон татвар, цалин, тэтгэврийн асуудлуудаа шийдвэрлэх гэх мэтээр бэлтгэл ажлуудаа хангах.</li> </ul>			

3. Эрсдэл ба даатгал	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилготот бүлэг)	Сэдэв
3.1 Хувь хүний эрсдэл ба даатгал (үндсэн)	<ul style="list-style-type: none"> <li>Бизнес эрхлэгч/эзэн тэтгэвэрт гарах, эрүүл мэндийн халамж шаардлагатай болох үед шаардлагатай зардлын талаар ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн зардал болон тэтгэврийн зардлыг даатгалаар шийдэхэд хангалттай эсэх, шаардлагатай бол нэмэлт зүйлсийг шийдвэрлэх.</li> <li>Бизнес эрхлэгч/эзний амьдралыг даатгах боломжуудыг судлах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнес эрхлэгч/эзний эрүүл мэнд, тэтгэврийн даатгалын хэрэгцээнд проактив байдлаар ханддаг болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1, 2, 3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсад байдаг даатгалуудын танилцуулга</li> </ul>
3.2 Бизнесийн эрсдэл ба даатгал (үндсэн)	<ul style="list-style-type: none"> <li>Түр зуурын алдагдал, орлого буурах, хулгай/алдагдал/гэмтэл, өвчин, бизнес эрхлэгч/эзэн нас барах, гуравдагч талд хохирол учруулах гэх мэт бэлэн мөнгөний урсгал, бизнесийн ерөнхий үйл ажиллагаанд эрсдэл учруулж болзошгүй зүйлсийн талаар мэдлэгтэй болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн гэнэтийн зардлуудаа төлөх төлөвлөгөөтэй байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тодорхой түвшний (хяналттай) эрсдэл хүлээхэд бэлэн болно.</li> <li>Тодорхой бус байдал, ухралт, түр зуурын амжилтгүй байдалд бэлтгэлтэй болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1, 2, 3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсад байдаг даатгалуудын танилцуулга</li> <li>Эрсдэлийн удирдлага ба бизнесийн тасралтгүй байдлын төлөвлөлт (үндсэн)</li> </ul>
3.3 Бизнесийн эрсдэл ба даатгал (гүнзгий)	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн зарим эрсдэлээс сэргийлэхийн тулд даатгалыг хэрхэн ашиглах, хуульд заасан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өөр өөр нөхцөл байдлыг харгалзсан, гэнэтийн үйл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өөрчлөлтийг удирдах тэвчээр, чадвартай болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>3, 4; болон 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрсдэлийн үнэлгээ ба удирдлага</li> <li>Эрсдэлийн удирдлага ба бизнесийн</li> </ul>

	<p>даатгалын шаардлагуудын талаар ойлголттой болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Даатгалаас гадна, эрсдэлийг бууруулахад ашиглаж болох зарим аргуудын талаар ойлголттой болно.</li> <li>• Өөр өөр цаг үед бизнесийн санхүүд нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлдог болно.</li> <li>• Урт хугацаанд бизнес өргөжиж, тогтвортой байхад нөлөөлж болзошгүй хүчин зүйл, эрсдэлүүдийн талаар ойлголттой болно.</li> <li>• Гэнэтийн нөхцөл байдалд зориулан хэтэрхий их нөөцийг хадгалах нь бизнесийн хөгжил, өсөлтөнд сөргөөр нөлөөлж болзошгүй талаар ойлголттой болно.</li> </ul>	<p>явдлуудад төлөвлөсөн, "хамгийн муу хувилбар"-ыг харгалзан үзсэн болзошгүй тохиолдлын төлөвлөгөө боловсруулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бизнесээ явуулахад шаардлагатай гол тоног төхөөрөмж, хөрөнгүүдийг даатгуулах; сонгосон даатгал нь хангалттай байгаа эсэхийг тогтмол үнэлэх.</li> <li>• Гэнэтийн нөхцөл байдал, ашиг орлого буурсан үед бизнесээ явуулахад хангалттай хөрөнгийг хадгалах.</li> <li>• Орлогын эх үүсвэрүүдээ олон болгох (олон харилцагч, бүтээгдэхүүн, байршил гэх мэт).</li> <li>• Хэрэглэгчээс гомдол гарах, бизнесийн нэр хүнд унах зэргээс гарах санхүүгийн хор уршгийг тооцоолох.</li> <li>• Валютын ханшийн өөрчлөлтийг давж гарах чадвартай байх.</li> <li>• Шинэ зах зээлийн судлах гэх мэт бизнесээ өргөжүүлэхэд тулгарах эрсдэлийг бууруулах алхамуудыг тооцоолох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гадны болон бизнесийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд уян хатан, зохицох чадвартай болно.</li> </ul>		<p>тасралтгүй байдлын төлөвлөлт</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсад байдаг даатгалуудын танилцуулга</li> </ul>
--	--	--	--	--	--

4. Санхүүгийн орчин	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилгот бүлэг)	Сэдэв
4.1 Гадны нөлөөллүүд (үндсэн)	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хүчин зүйлүүд (орон нутгийн зах зээл, өрсөлдөгчид гэх мэт) нь бизнест нөлөөлж болзошгүй бөгөөд бизнес нь өөрөө орон нутгийн амьдралд нөлөөлж болзошгүй талаар ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнест нөлөөлж болзошгүй үйл явдлуудын мэдээг анхаарах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнест нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллийг байнга дагадаг болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 1 болон 2</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөв, төлөвлөгөө (үндсэн)</li> </ul>
4.2 Гадны нөлөөллүүд (гүнзгий)	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засаг болон санхүүгийн голлох тоглогч нарын гүйцэтгэдэг үүргийн талаар ойлголттой болно.</li> <li>• Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болон тэдгээрийн хоорондын уялдааны талаар ойлголттой болно.</li> <li>• Understanding how changes in the economic and financial landscape – such as inflation, recession, changes in benefits and taxation – can affect the business Инфляци, эдийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнест нөлөөлж болзошгүй макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд болон хуулийн орчны өөрчлөлтийг судлах.</li> <li>• Бизнесийн шийдвэрийн орон нутаг, эдийн засаг, нийгэм болон орчинд үзүүлж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесийн шийдвэрийн үр дагаварыг илүү өргөн цар хүрээнд харж, үнэлдэг болно.</li> <li>• Эдийн засаг, санхүүгийн орчинд гарч буй өөрчлөлтүүдийн давуу талыг ашиглахдаа проактив хандлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• 3 болон 4; мөн 5</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төсөв, төлөвлөгөө (дунд, урт хугацааны)</li> </ul>

4. Санхүүгийн орчин	Мэдээлэл, мэдлэг, ойлголт	Ур чадвар болон зан төлөв	Хандлага	Тэргүүлэх чиглэл (зорилгот бүлэг)	Сэдэв
	<p>засгийн хямрал, нийгмийн халамж, татварын өөрчлөлт зэрэг эдийн засаг, санхүүгийн орчны өөрчлөлт нь бизнест хэрхэн нөлөөлдөг талаар ойлголттой болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн шийдвэр нь орон нутаг, эдийн засаг, нийгэм болон бизнесийн орчинд ямар нөлөө үзүүлдэг талаар ойлголттой болно.</li> </ul>	<p>болзошгүй нөлөөллийг бууруулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бизнесээ хөгжүүлэх стратегийн хараагаа тодорхойлохдоо тулд эдийн засаг, санхүүгийн орчны мэдээллийг ашиглах.</li> <li>Бизнесийн төлөвлөгөөгөө өөрчлөгдөж буй эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд тохируулах.</li> </ul>	<p>байж, бизнесээ өргөжүүлэхэд ашигладаг болно.</p>		
<p>4.3 БЖДБ-үүдийн санхүүг хамгаалах (үндсэн)</p>	<ul style="list-style-type: none"> <li>Албан бус, зохицуулалтгүй санхүүгийн бүтээгдэхүүн (bitcoin гэх мэт), үйлчилгээ (хувиараа мөнгө зээлэх гэх мэт) хүлээх эрсдэлийн талаар ойлголттой болно.</li> <li>БЖДБ-ийн хэрэглэгчийн хамгаалах чиглэлээр санхүүгийн зохицуулагчдын гүйцэтгэх үүргийн талаар үндсэн ойлголттой болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бизнесийн өгөгдөл, санхүүгийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах.</li> <li>Санхүүгийн нийтлэг гэмт хэрэг, залилан, луйврын талаар мэдээлэлтэй байх, аль болох урьдчилан сэргийлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн гэмт хэргийн эсрэг туштай тэмцэж, бизнесийнхээ аюулгүй байдлыг хангадаг байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>1 болон 2</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Орлого, зарлагаа хянах</li> <li>Санхүүгийн үндсэн бүтээгдэхүүнүүдийн ойлголт</li> <li>Ямар бүтээгдэхүүн ашиглах, ашиглахгүйг ойлгодог болох</li> <li>Санхүүгийн байгууллагатай хэрхэн ярилцах вэ?</li> <li>Гол асуудлуудаар мэдээллийн товхимол гаргах</li> <li>Хэрэглэгч/бизнесийг хамгаалах талаар мэдээлэл өгөх</li> <li>Цахим худалдааны үндсэн ойлголт, цахим аюулгүй байдал</li> </ul>
